МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

REDD+ MONGOLIA
Building resilience, livelihoods and economy



# МОНГОЛ УЛСАД REDD+-ИЙН СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС СЭРГИЙЛЭХ ЗАРЧМУУДЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮРЭЭ

2018 оны 11 сар

**Тайланг эрхлэн хэвлүүлсэн**

Монгол Улсын Байгаль орчин, аялал жуулчлалын яам (БОАЖЯ). 2018. Монгол Улсад REDD+-ийн сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг хэрэгжүүлэх хүрээ. 2018 оны 11 сар.

**Тайланг ашиглах зөвшөөрөл**

Уг тайлангийн эх сурвалжийг дурдсан тохиолдолд урьдчилж бичгээр зөвшөөрөл авахгүйгээр сургалтын болон бусад арилжааны бус зориулалтаар олшруулан хэвлэж болно.

Энэхүү тайланд зөвхөн зохиогчдын үзэл санаа тусгагдсан бөгөөд энэ нь Монгол орны UN-REDD Хөтөлбөр болон хамтран ажилладаг байгууллагуудын байр суурийг илэрхийлээгүй болно.

**Талархал**

Уг баримт бичгийг боловсруулахад үнэтэй санал, зөвлөгөө өгсөн Монгол орны UN-REDD хөтөлбөрийн баг, СНСЗ болон СНСМС-ийг боловсруулах техникийн ажлын хэсгийн гишүүд, СНСЗ болон СНСМС-ийн талаарх уулзалт семинарт оролцсон бусад хүмүүст талархал илэрхийлье. Мөн арга зүйн зөвлөгөө өгч ажилласан UN-REDD хөтөлбөрийн бүсийн болон олон улсын зөвлөхүүд, НҮБ-ын Байгаль орчин, дэлхийн байгаль хамгаалал, хяналтын төв (UNEP-WCMC)-д талархал илэрхийлье.

**Холбоо барих**

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Ойн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Оюунсанаатай (oyunsanaa@mne.gov.mn ) холбоо барина уу

# АГУУЛГА


Хураангуй ..... 5

1. REDD+-ийн сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх хүрээ ..... 7

1.1 Сөрөг нөлөөллөөс сэргийлэх Канкуны зарчмууд ..... 8

1.2 Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудтай төстэй бусад шаардлага ..... 9

1.3 СНСЗ-уудыг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх хүрээний бүрэлдэхүүн хэсгүүд ..... 9

2. Монгол Улсад сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг хэрэгжүүлэх хүрээг боловсруулах аргачлал ..... 11

3. Сөрөг нөлөөлөөс сэргийлэх зарчмуудын зорилго, цар хүрээг тодорхойлох нь ..... 13

3.1 Монгол оронд сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг хэрэгжүүлэх зорилго, хамрах хүрээ ..... 13

4. REDD+-ийн Бодлого, арга хэмжээний үр ашиг, эрсдэлийш үнэлэх нь ..... 14

4.1 Танилцуулга ..... 14

4.2 Үр ашиг, эрсдэлийг үнэлэх аргачлал ..... 15

4.3 Үр дүн ..... 15

4.4 Зөвлөмж ..... 25

5. Бодлого, хууль, журмын Үнэлгээ (БХЖ) ..... 33

5.1 Удиртгал ..... 33

5.2 БХЖ-ын үнэлгээний аргачлал ба үр дүн ..... 34

6. Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг Монгол орны онцлогт нийцүүлж тодорхойлсон нь ..... 36

6.1 Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг Монгол орны онцлогт нийцүүлж тодорхойлсон арга зам ..... 36

6.2 Монгол Улсад хэрэгжүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг тодорхойлсон үр дүн ..... 38

7. REDD+-ийг Монголд хэрэгжүүлэх явцад ашиглах ГБМ (гомдол барагдуулах механизм) ..... 38

7.1 Танилцуулга ..... 38

7.2 REDD+-тэй холбоотой үүсэж болох гомдол ..... 39

7.3 Монгол улсад мөрдөж байгаа одоогийн гомдол барагдуулах механизмууд 41

7.4 Зөвлөмж ..... 42

8. Дүгнэлт ба цаашид хэрэгжүүлэх алхмууд ..... 44

Хавсралт 1: СНСЗ-уудыг Монгол орны онцлогт нийцүүлж тодорхойлсон нь ..... 47

## Товчилсон үгс

| | |
|---|---|
| ГЗБГЗЗГ | Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар |
| УАӨТХН | Уур амьсгалын өөрчлөлтийн төсөл хэрэгжүүлэх нэгж |
| ТБХ | Талуудын бага хурал |
| ИНБ | Иргэний нийгмийн байгууллага |
| УАӨГХАГ | Уур амьсгалын өөрчлөлт, гадаад хамтын ажиллагааны газар |
| БОНБҮ | Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ |
| БОМТ | Байгаль орчны мэдээллийн төв |
| ОСХТ | Ойн судалгаа, хөгжлийн төв |
| ОСТ/ОЯХХСТ | Ойн суурь түвшин / Ойгоос ялгарах хүлэмжийн хийн суурь түвшин |
| ОН | Ойн нөхөрлөл |
| ГБМ | Гомдол барагдуулах механизм |
| МБОИЗ | Монголын байгаль орчны иргэний зөвлөл |
| БОАЖЯ | Байгаль орчин, аялал жуулчлалын яам |
| ХҮ | Хяналт, үнэлгээ |
| ОБЕГ | Онцгой байдлын ерөнхий газар |
| ТББ | Төрийн бус байгууллага |
| ҮС/ҮАТ | Үндэсний стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө |
| ҮСХ | Үндэсний статистикийн хороо |
| БАХ | Бодлого, арга хэмжээ |
| БХЖ | Бодлого, хууль, журам |
| REDD+ | Ойн хомсдол доройтлоос үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад байгаль хамгаалал, ойн тогтвортой менежмент, ойн нүүрстөрөгчийн шингээлтийг нэмэгдүүлэхийн ач холбогдол |
| ТХЗ | Тогтвортой хөгжлийн зорилтууд |
| БОСҮ | Байгаль орчны стратегийн үнэлгээ |
| СНСМС | Сөрөг нөлөөллөөс сэргийлэх мэдээллийн систем |
| SOI | НҮБ-ын УАӨСК-д өгөх Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудын хэрэгжилтийн тайлан |
| МХЕГ | Мэргэжлийн хяналтын ерөнхий газар |
| СНСЗ-СНСМС-ийн ТАХ | Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчим болон Сөрөг нөлөөллөөс сэргийлэх мэдээллийн системийг боловсруулах техникийн ажлын хэсэг |
| UNEP-WCMC | НҮБ-ын Байгаль орчин, дэлхийн байгаль хамгаалал, хяналтын төв |
| НҮБ-ын УАӨСК | НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенц |
| UN-REDD | Хөгжиж буй орнуудын ойн хомсдол, доройтлоос үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад чиглэсэн НҮБ-ын хамтарсан санаачилга |

## Хураангуй

Энэхүү баримт бичигт Монгол оронд REDD+-ийн сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг хэрэгжүүлэх хүрээнд хамаарах гол бүрэлдэхүүн хэсгүүдийг тайлбарлав. Олон улсын хэмжээнд мөрдөж байгаа сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмууд нь REDD+-ийн нийгэм, байгаль орчны эрсдлийг нь бууруулж, үр ашгийг нь дээшлүүлэх зорилготой юм. НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь Конвенцийн Талууд Мексикийн Канкун хотноо болсон 'Талуудын 16 дугаар бага хурал'-аар нийгэм, байгаль орчин, засаглалын хүрээнд баримтлах багц зарчмыг баталсан байна. REDD+-ийн СНСЗ-уудыг үндэсний нөхцөлд нутагшуулж хэрэгжүүлэх гэдэг нь тэдгээрийг үндэсний зорилго, зорилтууд болон нөхцөл байдалтай уялдуулж, одоогийн байгаа системүүдээ бүрэн ашиглах замаар олон улсын гэрээ, хэлэлцээрийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхийг хэлнэ.

Монгол улсад СНСЗ-уудыг хэрэгжүүлэх арга зам дараах гол үе шатуудаас бүрддэг:

**Алхам 1: СНСЗ-уудын зорилго, хамрах цар хүрээг тодорхойлох**

**Алхам 2: REDD+-ийн БАХ-нүүдийг хэрэгжүүлэх явцад үүсэж болох үр ашиг ба эрсдэлийг үнэлэх**

**Алхам 3: СНСЗ-уудтай холбоотой бодлого, хууль, журмуудыг үнэлэх**

**Алхам 4: СНСЗ-уудыг үндэсний нөхцөлд нийцүүлж тодорхойлох**

**Алхам 5: REDD+-ийн хүрээнд Гомдол барагдуулах механизмууд (ГБМ)-ын хувилбаруудыг үнэлэх**

Энэхүү баримт бичигт дээрх алхмуудыг хэрхэн хэрэгжүүлснийг дэлгэрэнгүй тайлбарласнаас гадна СНСЗ тус бүрийн тодорхойлолт болон зөвлөмжийг хураангуйлан үзүүллээ. Дээрх ажлын тайланг бүрэн эхээр нь үзэхэд зориулж холбоосыг зохих газар нь оруулсан болно. Монголд байгуулах сөрөг нөлөөллөөс сэргийлэх мэдээллийн системийн загварыг "Монгол орны REDD+-ийн Сөрөг нөлөөллөөс сэргийлэх мэдээллийн систем: Санал болгож байгаа бүтэц, үүрэг, хариуцлага" нэртэй тайланд тусад нь тайлбарлав. Мөн энэхүү баримт бичигт сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг Монгол Улсад REDD+-ийг хэрэгжүүлэх үйл явцтай хэрхэн уялдуулах талаар зөвлөмж боловсруулсан. Эдгээр нь СНСЗ-уудыг хэрэгжүүлэх арга замыг боловсруулахтай холбоотой хэрэгжүүлсэн алхмуудаас урган гарснаас гадна бусад ерөнхий зөвлөмжүүдийг багтаасан. Үүнд:

- REDD+-ийн хүрээнд хэрэгжүүлэхээр санал болгосон бодлого арга хэмжээг хэрэгжүүлэх явцад үүсэж болзошгүй үр ашиг, эрсдэлийн үнэлгээг тодорхойлсон үнэлгээний үр дүнгийн талаарх мэдээлэл, мөн үр ашгийг дээшлүүлэх, эрсдэлийг бууруулах сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмын асуудлуудыг тусгах зэрэгтэй холбоотой санал болгосон арга хэмжээнүүдийг оруулсан ба эдгээрийг "REDD+ үндэсний хөтөлбөрийг Монгол Улсад хэрэгжүүлэх явцад нэгтгэж авч үзэхийг зөвлөсөн байна. Эдгээр нь REDD+-ийн бодлого арга хэмжээний загвар болон хяналтын тогтолцоо, сөрөг нөлөөллөөс сэргийлэх мэдээллийн систем зэрэгтэй хамаатай.

- БХЖ-ын үнэлгээг хийсний дараа уг үнэлгээнээс гарсан үр дүнд тулгуурлан хэд хэдэн арга хэмжээг авлаа. Үүний дотор багц зөвлөмжийг боловсруулж Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлсэн бөгөөд эдгээр зөвлөмжүүдийг 2018 онд хийх байгаль орчны хууль эрх зүйн шинэчлэлд тусгахыг зөвлөсөн. БХЖ-ын хүрээнд гарч байгаа гол хийдэл, орхигдсон асуудлуудыг мөн энэ үеэр тодорхой

болгож, байгаль орчны болон бусад салбарын хууль эрх зүйн шинэчлэлийг хийхэд тусгахыг мөн зөвлөсөн, бусад хийдэл болон орхигдсон асуудлуудын тухайд БХЖ-н шинэчлэлийн асуудалд хамаарахгүй бөгөөд илүү түргэн шуурхай шийдэл болон бусад арга хэмжээг авах шаардлагатай болж магадгүй юм.

- Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг Монгол Улсын онцлогт нийцүүлж тодорхойлох ажлыг 2018 онд хийж дуусгасан бөгөөд ийнхүү тодорхойлохдоо сөрөг нөлөөллөөс сэргийлэх Канкуны зарчмуудыг чиг болгон баримталж, тэдгээрийн агуулга, элементүүдийг тус улсын онцлогт тохируулах замаар багц зарчмыг гаргаж ирсэн. Эдгээр боловсруулсан зарчмын элементүүдийг мөн олон улсын санхүүгийн корпорацийн “Үйл ажиллагааны стандарт”-тай харьцуулж үзсэн. Монгол Улсад “REDD+”-г өргөн цар хүрээтэйгээр хэрэгжүүлэх хандлага одоо л төлөвшиж байгаа тул сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг үндэсний онцлогт тохируулж тодорхойлсон баримт бичигт цаашид REDD+-ийг Монгол Улсад хэрэгжүүлэх явцад хянан үзэж, шаардлагатай өөрчлөлтүүдийг оруулж байх нь зүйтэй юм.

- REDD+-ийн хүрээнд үүсч болох санал, гомдлыг шийдвэрлэх, барагдуулах механизмыг цаашид бий болгохдоо Монгол Улсад одоогоор хэрэгжиж байгаа үндэсний гурван гомдол барагдуулах механизм дээр тулгуурлах нь зүйтэй. Хэдий тийм боловч, үүнийг хэрэгжүүлж эхлэхээсээ өмнө эдгээр гомдол барагдуулах механизмууд нь REDD+-ийн үйл ажиллагааны хэрэгцээ, шаардлагыг ямар хэмжээнд хангаж, олон улсын тэргүүн туршлагатай хэр уялдсан болох талаар нэмэлт судалгааг хийх нь зүйтэй.

- Монгол оронд “REDD+”-г хэрэгжүүлэх орчныг бүрэн дүүрэн тодорхойлж амжаагүй байна. Цаашид энэхүү санаачилга хэрхэн урагшлах нь сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчимуудыг хэрэгжүүлэх хүрээнд нөлөөлөх юм. Жишээлбэл, REDD+-ийн үйл ажиллагааг үндэсний хэмжээнд хэрхэн зохицуулах, орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх ажлыг зохих ёсоор тодорхойлсон эсэх зэрэг хүчин зүйлсийг харгалзах шаардлагатай. Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг хэрэгжүүлэхтэй холбоотой хангалттай нөөц, эх үүсвэр болон чиг үүргийг зохих байгууллага хэрэгжилтийн механизмд суулгаж өгсөн байх шаардлагатай.

- REDD+ Үндэсний хөтөлбөрт цаашид дараах хэдэн үйл ажиллагааг тусгахыг санал болгов. Үүнд: REDD+-ийг хэрэгжүүлэх үүрэгтэй төв болон орон нутгийн байгууллагуудын хэрэгцээнд зориулж Монгол оронд сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг хэрэгжүүлэх болон түүнд хяналт тавихтай холбоотой удирдамж боловсруулж, зохих сургалт явуулах, үндэсний хэмжээнд эдгээр зарчмуудын хэрэгжилтэд хяналт тавих, үнэлгээ хийхэд зориулсан шалгуур үзүүлэлт болон үйл ажиллагаануудыг REDD+-ийн Үндэсний хөтөлбөрт тусгах, Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчим болон нийгмийн бүлгүүдийн оролцоо, гомдол барагдуулах механизм зэрэгтэй холбоотой сургалтыг REDD+-ийн чадавх бэхжүүлэх хөтөлбөрт тусгах зэрэг болно.




## 1. REDD+-ийн сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх хүрээ

СНСЗ-уудын дагуу REDD+-ийн бодлого, арга хэмжээ (БАХ)-г хэрэгжүүлэх явцдаа тухайн үйл ажиллагаанаас үүдэж болзошгүй үр ашгийг нэмэгдүүлэх, эрсдлийг бууруулахад анхаарах ёстой гэсэн шаардлагыг олон улсын хэмжээнд тавьдаг. REDD+-ийн СНСЗ-уудыг үндэсний нөхцөлд тохируулж хэрэгжүүлэх гэдэг нь тухайн улс өөрийн улсын дотоодод дэвшүүлсэн зорилго, зорилтууд болон улс орныхоо нөхцөл байдалтай уялдуулж, одоогийн байгаа системүүдээ бүрэн ашиглах замаар олон улсын гэрээ, хэлэлцээрийг дагуу хүлээсэн үүргээ (НҮБУАӨСК болон бусад г.м) биелүүлэх явдал юм.

## 1.1 Сөрөг нөлөөллөөс сэргийлэх Канкуны зарчмууд

Эдгээр асуудлыг НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн Конвенцид нэгдсэн Талууд Мексикийн Канкун хотноо болсон 'Талуудын 16 дугаар бага хурал'-аар REDD+-ийн хүрээнд үүсч болох байгаь орчин, нийгмийн эрсдэлүүдийг бүүруулж, эерэг үр ашгийг бий болгоход чиглэсэн багц зарчмыг хэлэлцэж сөрөг нөлөөллөөс сэргийлэх багц зарчмыг баталсан[1]. Эдгээр зарчмыг Шигтгээ 1-д үзүүлэв.

***Шигтгээ 1: Канкуны зарчмууд***

[REDD+] –ийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дараах сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг дэмжиж, мөрдөх нь зүйтэй.

(a) Тухайн үйл ажиллагаа нь ойн үндэсний хөтөлбөр, холбогдох олон улсын гэрээ, хэлэлцээрүүдийн зорилгод хувь нэмэр оруулахуйц буюу эсвэл тэдгээрт нийцсэн байна;

(b) Хууль эрхзүй, бие даасан байдлыг харгалзан үзсэн ил тод, үр дүнтэй үндэсний ойн засаглалын бүтэцтэй байх;

(c) Олон улсын өмнө хүлээсэн үүрэг, үндэсний нөхцөл байдал, хууль тогтоомж, мөн НҮБ-ын Ерөнхий Ассемблейн баталсан Уугуул иргэдийн эрхийн тухай НҮБ-ын Тунхагийг харгалзан үзэж, уугуул иргэдийн болон орон нутгийн нөхөрлөлийн гишүүдийн мэдлэг, эрхийг хүндэтгэх;

(d) Оролцогч талууд, тухайлбал, нутгийн иргэд, орон нутгийн иргэдийн бүрэн бөгөөд үр дүнтэй оролцоог хангах;

(e) Тэдгээр үйл ажиллагаа нь байгалийн ой, биологийн олон янз байдлыг хамгаалах асуудалтай нийцсэн байх ба [REDD+] үйл ажиллагааг байгалийн ойг хувиргахад ашиглах бус харин байгалийн ой болон түүнийг экосистемийн үйлчилгээг хамгаалахад чиглэсэн урамшуулал бий болгох, мөн нийгэм, байгаль орчны бусад үр ашгийг сайжруулахад ашигладаг байх*;

(f) Үр дүн хувирах эрсдэлийг тооцох;

(g) Хүлэмжийн хийн ялгаралт өөр газар шилжих явдлыг бууруулах

* Уугуул иргэдийн тухай НҮБ-ын Тунхаг, "Олон улсын эх дэлхийн өдөр"-ийн баримт бичигт уугуул иргэд, орон нутгийн иргэдийн тогтвортой амьжиргааны хэрэгцээ болон ихэнх улсад нутгийн уугуул иргэдийн амьжиргаа ойгоос хамааралтай байдаг талаар тусгасан байгааг харгалзан үзэх

НҮБ-ын УАӨСК-ийн холбогдох шийдвэрийн дагуу REDD+ -ийг хэрэгжүүлж буй улс орнууд сөрөг нөлөөллөөс сэргийлэх дараах зарчмын шаардлагуудыг хангах ёстой[2]. Үүнд:

---

[1] Шийдвэр 1/CP.16, 17 дахь хэсэг

[2] UN-REDD Хөтөлбөрийн СНСЗ-ын хэрэгжилтийг зохицуулах бүлэг (2016) Мэдээллийн хураангуй: СНСЗ-уудыг үндэсний нөхцөлд тохируулж хэрэгжүүлэх нь. Арга зүйн гарын авлага 02. UN-REDD Хөтөлбөр, Женев. http://bit.ly/CASgds

I. Санхүүжилтийн эх үүсвэр, төрлөөс үл хамааран, REDD+ үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад Канкуны сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг дэмжиж, сурталчилах;
II. Канкуны сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг хэрхэн тусгаж, хэрэгжүүлж байгаа талаар мэдээлэл өгөх системийг боловсруулах (ж.нь: Сөрөг нөлөөллөөс сэргийлэх мэдээллийн систем г.м);
III. Канкунын сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг REDD+ үйл ажиллагааныхаа хэрэгжилтэд хэрхэн тусгаж, хэрэгжүүлж байгаа талаар нэгдсэн мэдээлэл өгч байх зэрэг болно.

## 1.2 Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудтай төстэй бусад шаардлага

Сөрөг нөлөөллөөс сэргийлэх Канкуны зарчмуудыг хэрэгжүүлснээр тухайн улс орнууд НҮБ-н уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенцын хүрээнд үр дүнд суурилсан урамшуулал авах үндсэн шалгуурыг хангаж чадна. Гэхдээ Монгол Улс REDD+ийг хэрэгжүүлэхэд зориулж бусад эх үүсвэрээс хөрөнгө татахыг хүсвэл сөрөг нөлөөллөөс сэргийлэх Канкуны зарчмууд буюу НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенцийн зүгээс тавигдах суурь шаардлагыг хангахаас гадна санхүүжүүлэгчдийн тавьдаг олон улсын бусад зарчмын стандартыг биелүүлэх шаардлагатай болно.

Жишээ нь, Уур амьсгалын ногоон сан /УАНС/ нь REDD+-ийн үйл ажиллагаанд хөрөнгө оруулалт хийх боломжтой санхүүжүүлэгч мөн бөгөөд тус сан нь REDD+-ийн үйл ажиллагааны үр дүнд суурилсан урамшууллыг олгохдоо Олон улсын санхүүгийн корпорац /ОУСК/-ийн байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн стандартыг хангасан эсэхийг шалгуур болгодог.[3]

REDD+ болон уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой санаачилгыг Монголд хэрэгжүүлэхэд санхүүжилт олгох боломжтой байгууллагуудын тоонд хөгжлийн банкнууд орно. Тухайлбал Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк нь мөн өөрийн гэсэн сөрөг нөлөөллөөс сэргийлэх стандартуудтай ажээ. Жишээлбэл: Дэлхийн банкнаас санхүүжүүлэх төслүүд нь банкны үйл ажиллагааны бодлогод суурилсан сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмын заалтуудыг хангасан байх ёстой байдаг. Дэлхийн банкнаас санхүүжүүлж байгаа төслийн саналуудыг эрсдэлээр нь ангилдаг бөгөөд шаардлагатай тохиолдолд тусгай Үйл ажиллагааны бодлогыг хэрэгжүүлэхийг санал болгодог.

## 1.3 СНСЗ-уудыг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх хүрээний бүрэлдэхүүн хэсгүүд

REDD+-ийн СНСЗ-уудыг үндэсний нөхцөлд тохируулж хэрэгжүүлэх гэдэг нь тухайн улс өөрийн улсын дотоодод дэвшүүлсэн зорилго, зорилтууд болон улс орныхоо нөхцөл байдалтай уялдуулж, одоогийн байгаа системүүдээ бүрэн ашиглах замаар олон улсын гэрээ, хэлэлцээрийг дагуу хүлээсэн үүргээ (НҮБУАӨСК болон бусад г.м) биелүүлэхийг хэлнэ. СНСЗ-уудыг үндэсний нөхцөлд нийцүүлж тодорхойлох, хэрэгжүүлэх ажил нь дараах үндсэн хэсгүүдээс бүрддэг. Үүнд:

I. СНСЗ-тай холбогдож болохуйц тухайн улсад хэрэгжиж байгаа бодлого, хууль, журмууд,

II. СНСЗ-уудыг хэрэгжүүлэхтэй холбоотой институцийн чиг үүрэг, журам, чадавх,

[3] UN REDD 2016. REDD+ Академийн сургалтын гарын авлага, 2 дахь хэвлэлт. НҮБУАӨСК-ийн хүрээнд баталсан REDD+ СНСЗ-ууд.

III. СНСЗ-уудыг бодлого, хууль, журамд хэрхэн тусгаж, хэрэгжүүлж байгаа талаарх мэдээллийг бүрдүүлэх СНСМС,

Тухайн улс орон бүрийн нөхцөл байдал харилцан адилгүй боловч сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг тухайн улс оронд хэрэгжүүлэх арга барилыг боловсруулахад хэрэг болох ерөнхий алхмууд нь төстэй байдаг бөгөөд бусад улсуудын өнөөг хүртэл хуримтлуулж ирсэн туршлагын үр дүнд тэдгээр нь улам тодорхой боловсронгуй болж байна. Зураг 1-т эдгээр алхмыг дэлгэрэнгүй тайлбарлаж харуулав.

Ийм арга барил нь олон талын ач холбогдолтой. Монгол Улс REDD+-ийн СНСЗ-уудыг боловсруулах, мөн НҮБУАӨСК-ийн шаардлагад нийцсэн СНСМС-ийг бий болгох үндэс суурийг тодорхой үе, шаттайгаар тавьсан. Эдгээрийг боловсруулахдаа одоогийн байгаа хууль, журам, институц болон мэдээллийн системд аль болох түшиглэхийг эрмэлзэж байгаа бөгөөд ингэснээр Монгол улс олон улсын СНСЗ-уудыг биелүүлээд зогсохгүй үндэснийхээ тогтвортой хөгжлийн зорилтуудтай тэдгээр зарчмуудыг уялдуулах боломжтой болно. Мөн REDD+-ийг үндэсний нөхцөл зөв хэрэгжүүлэх итгэлтэй болдог. Мөн өөрийн улсын хувьд хамгийн чухал гэж үзсэн үр ашиг, эрсдэлийг тодорхойлж, улмаар REDD+-ийн бодлого, арга хэмжээ (БАХ)-нүүдийг илүү тогтвортой, үр дүнтэй байхаар төлөвлөхөд хувь нэмэр оруулна.

Одоогийн байгаа тогтолцоо болон системүүд дээр суурилж СНСЗ-ын хүрээг хэрэгжүүлэх арга замыг боловсруулснаар эдгээр зарчим нь тухайн улс орны засаглалын бүтцэд урт хугацааны ахиц дэвшлийг авч ирэхэд хувь нэмэр оруулна. Эдгээр зарчмыг REDD+-тэй холбоотой ойгоос бусад тухайлбал хөдөө аж ахуй, эрчим хүч зэрэг салбарт ашиглаж болно. Ингэснээр сөрөг нөлөөллөөс сэргийлэх мэдээллийн систем (СНСМС)-ийг тухайн улсын хувьд шаардлагатай байгаа холбогдох мэдээллийн хэрэгцээ, мэдээллийн системийн гүйцэтгэх үүрэг, институцийн зохион байгуулалт дээр тулгуурлаж үр дүнтэй боловсруулахад тусална.

*Зураг 1: СНСЗ-уудын үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх хүрээ*[4]




## 2. Монгол Улсад сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг хэрэгжүүлэх хүрээг боловсруулах аргачлал

Монгол Улс REDD+-ийн сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг хэрэгжүүлэх хүрээг боловсруулах, мөн НҮБУАӨСК-ийн шаардлагад нийцсэн СНСМС-ийг бий болгох үндэс суурийг тодорхой үе, шаттайгаар тавьсан. Эдгээрийг хэрэгжүүлэхдээ одоогийн байгаа хууль, журам, институц болон мэдээллийн системд аль болох түшиглэхийг эрмэлзэж байгаа бөгөөд ингэснээр Монгол Улс олон улсын СНСЗ-уудыг биелүүлээд зогсохгүй үндэснийхээ зорилтуудтай тэдгээр зарчмуудыг уялдуулах боломжтой болов. Энэ үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд улсын болон орон нутгийн түвшний холбогдох талуудын оролцуулсан уулзалт, зөвлөгөөн зохион байгуулж, REDD+-ийн БАХ (бодлого, арга хэмжээ), REDD+ Үндэсний хөтөлбөр зэргийг боловсруулах үйл явцтай нягт уялдуулсан.

СНСЗ-уудыг үндэсний онцлогт тохируулж хэрэгжүүлэх арга замыг боловсруулах үйл ажиллагааны явцад гарсан гол үр дүн нь үр ашгийг дээшлүүлэх, эрсдэлийг бууруулахтай холбоотой арга хэмжээг REDD+-ийн Үндэсний хөтөлбөрт тусгасан, СНСЗ-удтай холбогдох бодлого, хууль журмын үнэлгээг хийсэн, REDD+-ийн СНСЗ-уудыг Монгол орны онцлог тохируулж тодорхойлсон зэрэг болно. СНСМС-ийн загвар болон түүнийг баталгаажуулах ажлын үр дүнг тусгай тайланд оруулсан (www.reddplus.mn)

[4]Энэ бүдүүвч зураг болон нэмэлт дэлгэрэнгүй мэдээллийг: UN-REDD Хөтөлбөрийн СНСЗ-ын хэрэгжилтийг зохицуулах бүлэг (2016), СНСЗ-уудыг үндэсний нөхцөлд тохируулж хэрэгжүүлэх нь. Арга зүйн гарын авлага 02. UN-REDD Хөтөлбөр, 2016 оны 2 дугаар сар.

Монгол оронд сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг хэрэгжүүлэх хүрээг боловсруулах ажил нь 5 гол алхмаас бүрдсэн бөгөөд тэдгээрийг доор дэлгэрэнгүй тайлбарлав:

**Алхам 1: Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудын зорилго, цар хүрээг тодорхойлох**

Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг хэрэгжүүлэхтэй холбоотой зорилгууд болон цар хүрээг эхний байдлаар тодорхойлж холбогдох талуудтай зөвшилцсөн бөгөөд энэ нь эдгээр зарчмуудыг үндэсний хэмжээнд цаашид хэрэгжүүлэх ажилд үндсэн чиг болно.

**Алхам 2: . REDD+-ийнбодлого, арга хэмжээнүүд (БАХ)-н үр ашиг, эрсдэлийг үнэлэх**

Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчим болон сөрөг нөлөөллөөс сэргийлэх мэдээллийн системийг боловсруулах техникийн ажлын хэсгийн (СНСЗ, СНСМС-н ТАХ) удирдлагаар талуудын оролцоог хангасан уулзалт семинаруудыг зохион байгуулж санал болгож байгаа бодлого арга хэмжээний байгаль орчин, нийгэм, засаглалтай холбоотой эрсдэл үр ашгийг тодорхойлж, дүн шинжилгээ хийв. Дээрх дүн шинжилгээний үр дүнг REDD+-ийн Үндэсний хөтөлбөр боловсруулахад тусгаж оруулсан бөгөөд эдгээр нь сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх хүрээг тодорхойлох, сөрөг нөлөөллөөс сэргийлэх мэдээллийн системийн зохих агуулгыг тодорхойлох эхний алхмыг бүрдүүлж өгсөн.

**Алхам 3: Бодлого хууль журмын (БХЖ) үнэлгээ**

Тухайн улс орнуудад мөрдөгдөж байгаа хууль журмууд нь СНСЗ-уудыг хэрэгжүүлэх үндэс, суурь болдог бөгөөд эдгээр зарчмыг БХЖ-д хэрхэн тусгасныг тодорхойлоход хэрэг болдог. Энэ үнэлгээгээр REDD+-ийн хүрээнд санал болгож байгаа БАХ-үүдийн байгаль орчны болон нийгмийн үр ашгийг дээшлүүлэх, тэдгээрээс үүдэж болох эрсдэлийг бууруулахтай холбоотой байж болохуйц, одоогийн мөрдөж байгаа бодлого хууль журмуудыг авч үзэв. Мөн үүнд бодлого, хууль, журмын тогтолцоонд тусгагдаагүй орхигдсон, хийдсэн асуудлуудыг тодорхойлж холбогдох зөвлөмжийг гаргасан бөгөөд бодлого хууль журмаас гарсан үр дүнг REDD+-ийн СНСЗ-уудыг үндэсний онцлогт нийцүүлж тодорхойлох ажилд ашигласан болно.

**Алхам 4: Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг Монгол орны онцлогт нийцүүлж тодорхойлох**

Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг үндэсний онцлогт нийцүүлж тодорхойлох ажлыг оролцооны аргаар СНСЗ, СНСМС-н ТАХ-н удирдлаган доор авч хэрэгжүүлсэн. Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг ийнхүү үндэсний онцлогт нийцүүлж тодорхойлох нь эдгээрийг тухайн улсын хүрээнд хэрхэн ойлгохыг тайлбарлаж өгдөг бөгөөд үүндээ үндэсний хэмжээнд нийтээр хүлээн зөвшөөрч, ойлгодог үг хэллэгүүдийг ашигладаг. Үүнд тухайн улс орны хүрээнд хамгийн тулгамдсан, нэн тэргүүний асуудлуудыг тухайлбал REDD+-ийн хүрээнд байгаль орчин, нийгмийн чиглэлээр үүдэж болох ямар үр ашиг чухал вэ гэдгийг авч үзсэн бөгөөд үүнийгээ одоогийн бодлого, хууль журмын тогтолцоотой холбосон байна.

**Алхам 5: REDD+-ийн хүрээнд үүсэж болох санал, гомдлыг барагдуулах механизмын хувилбаруудыг үнэлэх**

Гомдол барагдуулах механизм (ГБМ) гэдэг нь үндэсний болон орон нутгийн төрийн байгууллагуудын зүгээс тухайн хэрэгжүүлж байгаа бодлого хөтөлбөр болон үйл ажиллагаанууд нь оролцогч талуудад хэрхэн нөлөөлж байгаа талаар санал болон

гомдлыг хүлээж авах үүрэгтэйгээр байгуулсан механизмууд юм. Монгол оронд байгаа одоогийн гомдол барагдуулах механизмуудыг үнэлсэн бөгөөд цаашид REDD+-ийг хэрэгжүүлэх хүрээнд ашиглах гомдол барагдуулах механизмыг хөгжүүлэхтэй холбоотой зөвлөмжийг боловсруулсан.

# 3. Сөрөг нөлөөлөөс сэргийлэх зарчмуудын зорилго, цар хүрээг тодорхойлох нь

Сөрөг нөлөөллөөс сэргийлэх Канкуны зарчмуудыг биелүүлэх, тэдгээрийг хэрхэн хэрэгжүүлж байгаа талаар тогтмол тайлан өгөх зэрэг нь НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенцийн зүгээс тавьдаг нэг шаардлага бөгөөд эдгээр зарчмыг үндэсний онцлогт нийцүүлэн одоогийн байгаа засаглалын тогтолцоо (бодлого, хууль, журам, институц, мэдээллийн систем гэх мэт)-нд тусган хэрэгжүүлэх шаардлагатай болдог. Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг тодорхойлох гэдэг нь тухайн улс REDD+-ийг хэрэгжүүлэхдээ баримтлах зарчим, хэрэгжүүлэх цар хүрээ, REDD+-ийн ямар үйл ажиллагаанд тэдгээрийг тусгах зэргийг тодорхойлно.

## 3.1 Монгол оронд сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг хэрэгжүүлэх зорилго, хамрах хүрээ

Монгол оронд сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг хэрэгжүүлэх зорилго, цар хүрээг тодорхойлох ажил ид дундаа үргэлжилж байгаа бөгөөд анхны тодорхойлолтыг нь 2017 онд боловсруулсан. Энэ нь тодорхойлолт цаашид REDD+ Үндэсний хөтөлбөрийг боловсруулах, REDD+-ийн үйл ажиллагааг санхүүжүүлэх байгууллагуудын зүгээс тавигддаг шаардлагуудын талаарх ойлголт улам сайжрахын хэрээр боловсронгуй болох юм.

СНСЗ-уудыг хэрэгжүүлэх зорилго болон цар хүрээг тодорхойлсон төслийг Монгол орны UN-REDD үндэсний хөтөлбөрийн ажилтнууд болон холбогдох талуудтай сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчим ба нийгмийн бүлгүүдийн оролцооны талаарх 2017 оны 1 сард зохион байгуулсан семинарын үеэр хэлэлцсэн[5]. Уг семинарт төрийн болон иргэний нийгмийн байгууллагууд, аж үйлдвэрийн холбоод, ойн нөхөрлөл, олон улсын байгууллагуудын төлөөлөл болох 50 гаруй хүн оролцсон. Ийнхүү тодорхойлсон зорилго болон цар хүрээг уг семинарын дараа 2017 оны 5 сард болсон СНСЗ болон СНСМС-ийн техникийн ажлын хэсгийн хурлаар хянуулсан. Эдгээр хэлэлцүүлгээс дараах асуудлуудыг онцолсон.

- Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудын зорилго: НҮБ-н Уур амьсгалын өөрчлөлтийн суурь Конвенцийн хүрээнд баталсан Канкуны зарчмуудын шаардлагыг хангах, Монгол Улсад уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой санаачилгуудыг хэрэгжүүлэх санхүүжилт авахад тавигдах бусад шаардлагыг хангах, тухайлбал Уур амьсгалын ногоон сан нь Олон улсын санхүүгийн корпорацийн Үйл ажиллагааны стандартыг авч ашигладаг г.м.
- Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудын хамрах хүрээ: Эдгээр зарчмыг REDD+-ийн бүх үйл ажиллагаа, REDD+ Үндэсний хөтөлбөрт тусгасан бүх бодлого, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх явцад ашиглана. Ингэхдээ уур амьсгалын

[5] Семинарын тайлан, материал: Англи

өөрчлөлтийг сааруулах, түүнд дасан зохицох “ногоон хөгжил” хөтөлбөрүүдийн олон талын зорилтуудыг харгалзаж үзнэ.



2017 оны 1 сард зохион байгуулсан СНСЗ-ын семинарт оролцогчид. 2017 Зураг ©UNEP-WCMC

## 4. REDD+-ийн Бодлого, арга хэмжээний үр ашиг, эрсдэлийг үнэлэх нь

### 4.1 Танилцуулга

Хэдий REDD+ хөтөлбөрийн гол зорилго нь дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад хувь нэмэр оруулахад чиглэх боловч, тус хөтөлбөрийг хэрэгжүүлснээр нийгэм, байгаль орчны салбарт нэмэлт үр ашиг бий болж болно гэж үздэг. REDD+ Хөтөлбөрийн хүрээнд тодорхой бодлого, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлснээр орон нутгийн иргэдийн амьжиргаа дээшлэх (орлогын өөр эх үүсвэр бий болгох, ойн бүтээгдэхүүнийг ашиглах боломжтой болох г.м), байгалийн нөөцийн удирдлага сайжрах зэрэг нийгмийн үр ашиг бий болж болох юм. Харин байгаль орчны чиглэлээр бий болох үр ашигт биологийн төрөл зүйлийн амьдрах орчныг хамгаалах, сайжруулах, бусад экосистемийн үйлчилгээ, тухайлбал усны горим, хөрсний эвдрэлийг бууруулах зэрэг багтана. Мөн REDD+-ийн бодлого, арга хэмжээнүүдийг хаана, хэрхэн хэрэгжүүлснээс хамаараад тодорхой эрсдэлүүд ч үүсч болдог. Байгаль орчны салбарт үүсэх эрсдэлийн тоонд REDD+ хөтөлбөрт хамрагдаагүй нутгийн байгалийн экосистемд дарамт учрах (үүнийг сөрөг нөлөө шилжих гэж нэрлэдэг), байгалийн ой болон бусад экосистемийг мод тарих талбай болгон хувиргах зэрэг багтана. Нийгмийн эрсдэлүүдэд ойгоос хамааралтай аж төрдөг иргэдийн ойн санд нэвтрэх болон ойн нөөцийг ашиглах боломж хязгаарлагдах, холбогдох талууд REDD+-ийн үйл ажиллагаанд оролцох нь хязгаарлагдах зэрэг орно.

REDD+-ийн хүрээнд хэрэгжүүлэхээр санал болгож байгаа бодлого арга хэмжээнүүдийн нийгэм байгаль орчны болон бусад нөлөөллүүдийг үнэлснээр цаашид тухайн улсад REDD+-ийн сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг үндэсний хэмжээнд зөв тодорхойлоход хэрэг болно. Мөн дээрх үнэлгээг хийснээр үндэсний REDD+-ийн стратеги буюу хөтөлбөрт тусгагдах бодлого арга хэмжээнүүдийг сонгох, боловсруулах, тэдгээрийн нийгэм байгаль орчны тогтвортой байдлыг дээшлүүлэх, эрсдэл үүсч болох талбарыг тодруулж өгөх зэрэг ач холбогдолтой.

## 4.2 Үр ашиг, эрсдэлийг үнэлэх аргачлал

Монгол Улс нь REDD+-ийг хэрэгжүүлэхтэй холбоотой үүдэж болох үр ашиг ба эрсдэлийг тодорхойлох ажлыг 2017 оноос 2018 онуудад олон талын оролцоотой авч хэрэгжүүлсэн бөгөөд үр ашгийг нэмэгдүүлэх эрсдэлийг бууруулахтай холбоотой хэд хэдэн зөвлөмжийг боловсруулсан. Энэ үйл явц нь дараах хэдэн алхмаас бүрдсэн.

Үүнд:

- REDD+-ийн эрсдэл үр ашгийг тодорхойлох ажлыг үндэсний хэмжээнд талуудын оролцоотойгоор хийсэн бөгөөд тэдгээрийг зохицуулах арга хэмжээнүүдийг боловсруулсан[6].
- Хэнтий, Хөвсгөл, Сэлэнгэ аймагт REDD+-ийг хэрэгжүүлэх дэд хөтөлбөрийг боловсруулах явцад аймгийн түвшинд үүсч болох эрсдэл, үр ашгийн талаар хэлэлцүүлэг хийсэн.
- БАХ-ний талаарх хэлэлцүүлгээс гарсан нэмэлт үр ашиг, эрсдэлийн үр дүнг бүрэн хэмжээний дүн шинжилгээ, зөвлөмж, сүүлийн шатны үнэлгээнд оруулсан.[7]
- Үндэсний хэмжээнд, бодлогын түвшинд хэрэгжүүлэх бодлого арга хэмжээний үр нөлөөг үнэлэх ажлын СНСЗ-СНСМС-ийн ТАХ-ийн удирдлага доор хийж гүйцэтгэв.[8]

Энэ үнэлгээнээс гарсан үр дүнг Монгол орны UN-REDD хөтөлбөр болон холбогдох талуудад хүргүүлж бодлого арга хэмжээг боловсруулах, сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг үндэсний хэмжээнд боловсруулах арга барилыг боловсруулах цаашдын ажилд ашигласан. Үнэлгээний үр дүнг бүрэн эхээр нь хүснэгт хэлбэрээр тайлангийн хамт цахим хуудсанд байршуулсан. (Суурь тайлан: Англи, Монгол; Үнэлгээний ажлын хүснэгт: Англи, Монгол)

## 4.3 Үр дүн

Үр ашиг, эрсдэлийн үнэлгээнээс гарсан үр дүнг доорх Хүснэгт 1-т харуулав.

Үнэлгээний явцад дараах үр ашгийг хамгийн олон удаа дурдсан байлаа. Тухайлбал: нутгийн иргэдийн дунд ажил эрхлэх болон орлого олох боломж нэмэгдэнэ;.улсын төсөвт тэр дундаа орон нутгийн төсөвт ойн салбараас орох орлого нэмэгдэнэ; байгалийн болон бусад төрлийн ойн нөхөн сэргээлт сайжирна; ойн салбарын засаглал сайжирна, түүнчлэн төлөвлөлт зохицуулалт болон хяналт сайжирна; ойн экосистемийн үйлчилгээг хамгаалах байдал сайжирна; тэр дундаа хөрс, усыг хамгаалахтай холбоотой экосистемийн үйлчилгээ улам дээшилнэ гэжээ. Хамгийн чухал

[6] Үр ашиг, эрсдлийг үнэлэх семинар, 2017 оны 5 сар (Семинарын материал: Англи, Монгол)
[7] 2018 оны 1 сард зохион байгуулсан СНСЗ-СНСМС байгуулах ТАХ-ийн хурлын үеэр тодорхойлсон үр ашиг, эрсдэлийн үр дүнгийн танилцуулга. (уулзалтын тайлан: Англи, Монгол).
[8] СНСЗ-СНСМС-ийн ТАХ-ийн Бодлогын түвшинд хэрэгжүүлэх БАХ-ний үнэлгээний уулзалт, 2017 оны 9 сар (Уулзалтын тайлан: Англи, Монгол)

гэж үзсэн эрсдэлүүдийг тоонд авлигатай тэмцэх, танил тал харах болон удирдлага зохион байгуулалт буруу байх эрсдэл; нутгийн иргэд REDD+-ийн үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх ажилд оролцох оролцоо хязгаарлагдмал байх; ойд ирж байсан ачаалал бусад ойн талбай болон өөр экосистемд шилжих, тухайлбал бэлчээрт гэх мэт: ойн бүтээгдэхүүн  ялангуяа мод болон түлшний модыг тогтвортой бус хууль бусаар ашиглах явдал нь биологийн төрөл зүйл болон экосистемийн үйлчилгээнд сөргөөр нөлөөлөх: бодлого ойр ойрхон өөрчлөгдөх, төрийн албан хаагчид тогтворгүй байх зэрэг нь REDD+-ийн БАХ-г тогтвортой хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлөх үйл ажиллагааны эрсдэл мөн бөгөөд энэ нь үр дүн хувирах эрсдэлийг нэмэгдүүлж болзошгүй. Үнэлгээний явцад тодорхойлсон үр ашиг, эрсдэлийн үнэлгээг бүрэн эхээр нь доор хураангуйлж нэгтгэн, байгаль орчин, нийгэм эдийн засаг, засаглалын гэсэн гурван ангилалд хуваасан. Үйл ажиллагааны эрсдэл гэдэг нь REDD+-ийн үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэхэд учрах эрсдэл юм. Эдгээрийг хүснэгтийн төгсгөлд оруууллаа.





Ой нь монголынхөдөө орон нутгийн иргэдийн амьжиргаанд чухал үүрэгтэй.  Зургийг © Cory Wright

Зургийг © Cory Wright



*Хүснэгт 1: Монгол улсын REDD+-ийн үр ашиг ба эрсдэлийн үнэлгээний үр дүнгийн тойм*

| Байгаль орчны | Нийгэм - эдийн засгийн | Засаглалын |
|---|---|---|
| **Тодорхойлсон үр ашиг** | **Тодорхойлсон үр ашиг** | **Тодорхойлсон үр ашиг** |
| Нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа, үрийн чанар ба хяналтыг сайжруулж ойн өсөлт ба бүтээмжийг дээшлүүлэх замаар ойн чанар ба байгалийн нөхөөн сэргээлт сайжирна. | Ойн баялгийг ашиглах боломж нэмэгдэх тул орон нутгийн иргэд, ойн нөхөрлөлийн гишүүд ба ААН-ийн орлого, амьжиргаа дээшилнэ. | Орон нутгийн засаглал ба тусгай хамгаалалттай газар нутаг дахь олон нийтийн оролцоо сайжирна. Ойн нөхөрлөлийг оролцуулснаар ойн хамгаалал сайжирч, түймрийн эрсдэл буурна. |
| Ойн нөхөн сэргээлт ба хамгаалалт мөн усны эх үүсвэрийг хамгаалахад чиглэсэн БАХ-г хэрэгжүүлснээр экосистемийн үйлчилгээ дээшилж, биологийн олон янз байдлын хамгаалал сайжирна. | Ойн тогтвортой менежмент, түймрийн эрсдэл ба нөлөөллийг багасгах арга хэмжээ нь орон нутгийн дэд бүтцийн (жишээ нь ойн зам) хөгжилд дэмжлэг үзүүлнэ. Ойн тогтвортой менежментийн эдийн засгийн урамшууллыг нэмэгдүүлэх нь ойгоос хамааралтай салбаруудад хөрөнгө оруулалтыг өсгөх магадлалтай. | Ойн тогтвортой менежментийн хууль эрх зүй, төлөвлөлтийн тогтолцоо сайжирч ойн нөхөрлөлүүд ойн тогтвортой менежментийн хөтөлбөрийг илүү сайн хэрэгжүүлнэ. Мөн төрийн албан хаагчид болон орон нутгийн иргэдийн чадавхыг нэмэгдүүлж, ойн тогтвортой менежментийн ойлголт сайжирна. |
| Унанги модыг цэвэрлэх ойн арчилгааны огтлолт хийснээр түймэр, хөнөөлт шавжийн эрсдэл буурна. Ойн замууд түймрийн менежмент болон хөнөөлт шавжийн эсрэг тэмцлийн арга хэмжээнд нааштай нөлөөлнө. | Өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нийлүүлэлт өсч чанартай, тогтвортой бүтээгдэхүүний үнэ дээд зэрэгт хүрч болно. | Ойн хяналтын үйл явц сайжирна, жишээ нь хяналт шалгалтад зарцуулах орлого нэмэгдсэн тохиолдолд гэх мэт. Гэрчилгээний мэдээллийн сан байгуулах боломжтой. |
| Ойн нөхөрлөл, ойн анги болон бусад оролцогч талуудтай хамтрах замаар ойн тогтвортой менежментийн чадавх сайжирна. | Модны нийлүүлэлт нэмэгдэж магадгүй ба түүхий эдийн нийлүүлэлт баталгаатай, тогтвортой болсны улмаас бүтээгдэхүүний үнэ тогтворжино. | Оролцогч талуудын оролцоо нэмэгдсэнээр хяналт шалгалт, ил тод байдал мөн санхүүжилтийн хуваарилалт зэрэг ойн нөхөн сэргээлтийн засаглал ба хөнөөлт шавжийн эсрэг тэмцлийн арга хэмжээ сайжирна. |
| Ойн доройтол багассанаар цөлжилт ба хөрсний доройтол мөн буурна. | Ойн менежментийн төлөвлөгөө боловсруулах, чадавх нэмэгдүүлэх боломж бололцоог ашиглах замаар ойн нөхөрлөлүүд болон бусад оролцогч талуудын мэдлэг чадвар дээшилнэ. | Талуудын оролцоо нэмэгдсэнээр ОБЕГ ба Тусгай хамгаалалттай газар нутгийн захиргааны санхүүгийн дарамт буурна. |
| Байгалийн баялаг ашигласны хураамж болон экосистемийн үйлчилгээний төлбөрийн хуваарилалт ба менежментийг сайжирснаар байгаль хамгаалал, менежментийн санхүүжилтийг орон нутгийн түвшинд нэмэгдүүлнэ. | Усны нөөц нэмэгдсэнээр эдийн засгийн бусад салбар (ХАА г.м) хөгжих бололцоо бүрдэж хүнсний аюулгүй байдал сайжирна. | Хяналт шалгалт, хуулийн хэрэгжилт сайжирснаар хууль бус мод бэлтгэл болон бусад хууль зөрчих явдлын талаарх мэдээлэл илүү түргэн шуурхай болох ба холбогдох гэмт хэрэг (татвараас зайлсхийх, зэрлэг ан амьтан, ургамлын арилжаа г.м) буурна. |

| |
|---|
| Бэлчээрийн менежмент сайжирснаар бэлчээр нөхөн сэргээгдэж хөрсний доройтол буурна. Эрчимжүүлсэн мал аж ахуй хөгжүүлэх боломж нээгдэнэ. |
| Ойн хамгаалал ба менежментийн урамшууллаар дамжуулан орон нутгийн иргэдийн дунд байгалиа хайрлах уламжлал хандлага сэргэнэ. |
| Хуурай газрын ойн экосистем бүхий газар нутагт байгаль хамгааллыг сайжруулснаар заган ой сэргэж бусад ургамлын ургалтын дэмжинэ (жишээ нь эмийн ургамал). |
| Түлээний мод бэлтгэлийг тогтвортой болгосноор түлээний модтой холбоотой үйл ажиллагааг сайжруулах, үүний дотор түлшний бусад эх үүсвэр, эрчим хүчний хэмнэлтийг нэмэгдүүлж бохирдлыг бууруулах боломжтой. |
| Мод боловсруулах боловсронгуй технологийг нэвтрүүлснээр түүхий эдийн ашиглалт сайжирч хог хаягдлын хэмжээ буурна. Логистикийн үйлчилгээ болон аж үйлдвэрийн нэгдсэн төвүүдийн хамтын ажиллагаа сайжирснаар хог хаягдлын менежмент сайжирна. |
| **Тодорхойлсон эрсдэлүүд** |
| Ашиглалтын ойд ойн цэвэрлэгээ болон эсвэл арчилгааны огтлолт хэт нэмэгдсэнээр байгалийн баялгийн хэт ашиглалт, хууль бус мод бэлтгэл ихсэх мөн ойн эрүүл мэнд, биологийн олон янз байдал ба экосистемийн |

| |
|---|
| Нөхөрлөлүүдийн эдийн засгийн идэвх ба нөөц нэмэгдэж орон нутгийн хөгжлийн санд хувь нэмэр оруулна. БОСҮ-үүд татвар, зөвшөөрөл ба зээлийн эргэн төлөлтөөр дамжуулан орон нутгийн төсвийн орлогын урсгалыг нэмэгдүүлнэ. |
| “Ногоон” бөгөөд илүү чанартай модон бүтээгдэхүүн дэлгэрснээр хүний эрүүл мэндэд эерэг нөлөө үзүүлнэ (утаа багатай түлш г.м.) |
| Мал аж ахуйн салбарт тодорхой арга хэмжээ хэрэгжүүлснээр малын бүтээгдэхүүний чанарыг сайжруулж экспортыг нэмэгдүүлнэ. |
| Амьжиргааны эх үүсвэрийн төрөл нэмэгдэж, агро ойн аж ахуйн хөгжлийн үр дүнд экосистемийн үйлчилгээ сайжирснаар нутгийн иргэдийн дунд уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах чадавх  сайжирна. |
| Ойн тогтвортой менежмент ба гэрчилгээ олгох ажлын үр дүнд техник технологи сайжирч үр бүтээл нэмэгдэнэ. Мөн хөдөлмөр хамгааллын стандарт, эрүүл мэнд аюулгүй байдал сайжирна. |
| **Тодорхойлсон эрсдэлүүд** |
| Хамгаалалтын дэглэм нэмэгдсэнээр байгалийн баялгийн хүртээмж багасах, бэлчээр болон нийтийн хэрэгцээний газар хомсдох эсвэл ан агнуур хийх, унанги түүх эрх хязгаарлагдах |

| |
|---|
| REDD+ БАХ-үүд (жишээ нь хууль бус мод бэлтгэлийг бууруулах хуулийн хэрэгжилт сайжирсны үр дүнд) Монголд олон салбарын төрийн байгууллагууд мөн хөрш зэргэлдээ орнуудын ойн болон байгаль орчны асуудал хамарсан хамтын ажиллагааг сайжруулна. |
| Байгаль хамгаалах сангийн менежмент сайжирч, төсвийн хуваарилалт илүү зохистой болсноор байгалийн баялгийн нөөц ашигласны төлбөр төлөгчдийн итгэл, төлбөр төлөх идэвх нэмэгдэнэ. |
| Орлого зарлагын ил тод байдал ялангуяа орон нутгийн түвшинд нэмэгдэх ба орлогыг зүй бусаар зарцуулах явдлыг шуурхай илрүүлж таслан зогсоох бололцоотой болно. Ойн салбарын үйл ажиллагаанд талуудын оролцоо нэмэгдсэнээр тендертэй холбоотой авлига буурна. |
| Ойн дагалт баялагтай холбоотой REDD+ БАХ-үүд эрх зүйн тогтолцоо, баялаг бэлтгэх тогтвортой байдал мөн ойн дагалт баялагтай холбоотой хуулийн хэрэгжилтийг сайжруулах бололцоог бүрдүүлнэ. |
| Олон салбарын оролцогч талуудын хамтын ажиллагаа ба хоорондын уялдаа сайжирна, жишээ нь ойн нөхөрлөлүүд ба ААН-ийн зөрчил буурна. |
| Агро ойн аж ахуйн хөгжлийг дэмжсэний үр дүнд ой, ХАА мөн газрын асуудал хариуцсан нэгжүүдийн хамтын ажиллагааг сайжирна. |
| **Тодорхойлсон эрсдэлүүд** |
| Шат шатны түвшинд авлига нэмэгдэж болзошгүй. |

| | | |
|---|---|---|
| үйлчилгээ өөрөөр хэлбэл нүүрстөрөгчийн агууламж, зэрлэг ан амьтан ба ургамлын амьдрах орчин зэрэгт сөрөг нөлөө үзүүлж болзошгүй. | зэргээр орон нутгийн иргэдийн амьжиргаанд сөрөг нөлөөлөл учруулж болзошгүй. | |
| Түймрийн эрсдэл, нөлөөллийг бууруулах зорилгоор зориуд тавьсан гал алдагдах эсвэл энэ талаар ойлголт муутай, хяналт эргүүл багатай газар нутагт түймэр шилжих эрсдэлтэй. | Газар ба ойн баялгийн ашиглалт, урамшуулал, үр ашгийн хуваарилалттай холбоотойгоор талуудын хооронд зөрчил маргаан гарч болзошгүй. | Мэдлэг дээшлүүлэх, ойлголт нэмэгдүүлэх кампанит ажлууд зорилтот бүлэгтээ хүрэхгүй байх магадлалтай (жишээ нь алслагдсан орон нутагт). |
| Хөнөөлт шавжийн эсрэг тэмцлийн ажил хэт сайжирснаар экологийн тэнцвэрт байдал алдагдах аюултай. Механик болон биологийн тэмцлийн аргуудын зэрлэг ан амьтан, ургамалд үзүүлэх эрсдэл тодорхой бус. | REDD+ -д оролцсоноор эсвэл аж ахуй эрхлэх хэлбэр нь хязгаарлагдсаны улмаас орон нутгийн иргэдийн ажлын ачаалал хариуцлага нэмэгдэж болзошгүй. | Улс төрийн нөхцөл байдлаас шалтгаалж бодлого, хөтөлбөр ойр ойрхон өөрчлөгдөх нь үр дүн хувирах эрсдэлийг дагуулна. |
| Хүлэмжийн хийн ялгаралт өөр газарт шилжих эрсдэлүүд, үүнд: зарим ой бүхий газар нутагт ойн хамгаалал, менежмент сайжирсны улмаас ойн, хомсдол доройтлын хүчин зүйлс болон дарамтууд ойн болон ойн бус газар нутагт шилжих, ойн бус экосистемүүдийг байгаль хамгааллын ач холбогдол багатай гэж үзсэн тохиолдолд тэдгээр газар сөрөг нөлөөлөлд өртөх, түлээний мод бэлтгэлийг хязгаарласан эсвэл өөр сонголтгүй газар нутагт түлээний мод бэлтгэх явдал нэмэгдэх магадлалтай. | Хөнөөлт шавжтай тэмцэх ажлыг өргөжүүлэх нь улсын төсвийн зардлыг нэмэгдүүлэх ба засгийн газар болон хувийн хэвшлийн зүгээс өөр өөрсдийн эдийн ашиг сонирхлын үүднээс төсвийн санхүүжилтийг нэмэгдүүлэх сонирхол төрүүлж болзошгүй. | Тарьц суулгац ургаагүйн улмаас торгууль ногдуулснаас болж иргэд итгэл алдрах, ойн нөхөн сэргээлтийн үйл ажиллагаанд оролцох идэвхгүй болох магадлалтай. |
| Мод тарих ажлын үр дүн нэмэгдсэнээс болж хэт их тод тарих болсноор байгалийн ойн төрлүүд хаягдах эсвэл тохиромжгүй газарт (бэлчээрийн талбай г.м) плантаци бий болох зэрэг эрсдэлтэй. | Ирээдүйд улсын төсөвт их хэмжээний дарамт учруулах эрсдэлтэй, жишээ нь засвар үйлчилгээ шаардлагатай дэд бүтэц ба тоног төхөөрөмж (ойн зам г.м.), ойжуулах, ойн нөхөн сэргээлт хийх тэр тусмаа заган ой бүхий газар нутагт төсвийг нэмэгдүүлэх, , алслагдсан газар нутагт эко аялал жуулчлал хөгжүүлэх г.м. | Шинээр тусгай хамгаалалттай газар нутаг байгуулах нь орон нутгийн засаг захиргаа ба тусгай хамгаалалттай газар нутгийн захиргаанд дарамт үзүүлж тэдгээрийн хамтын ажиллагааг сулруулж магадгүй (улсын тусгай хамгаалалттай газар нутаг). |
| Орон нутгийн иргэдийн дасан зохицох чадварыг нэмэгдүүлэх нь байгаль хамгаалалтай зөрчилдөх арга хэмжээнүүдийг дэлгэрүүлж болзошгүй (дэд бүтэц хөгжүүлэх г.м). | Мод бэлтгэлийн хязгаарласнаар болон түлээний модны нийлүүлэлт буурах, тэдгээр бүтээгдэхүүний үнэ өсч, орлого багатай иргэдэд хүндээр тусах. | Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөх мөн усны хагалбар газрын менежментийн төлөвлөгөө зэрэг нь бусад хөгжлийн бодлого (уул уурхай, зам, бэлчээр, эрчим хүчний г.м)-той зөрчилдөж болзошгүй тул зохицуулалт шаардлагатай. |

| | | |
|---|---|---|
| Бичил зээл эсвэл амьжиргааны дэмжлэгийг малын тоо толгойг нэмэгдүүлэх зэрэг тогтвортой бус зориулалтаар ашиглах эрсдэлтэй. | REDD+ нь нүүдлийн мал аж ахуй зэрэг уламжлалт аж амьдралд дарамт учруулах мөн тусгай хамгаалалттай газар нутгийг өргөжүүлэх нь зан заншлаа хадгалахад чиглэсэн журам, зохицуулалттай зөрчилдөх магадлалтай. | Хуулийн хэрэгжилтийг сайжруулж хууль сахиулах байгууллагуудын үүрэг оролцоог нэмэгдүүлэх нь орон нутгийн иргэдийн оролцоо болон ойн хамгаалал, менежментэд оролцох санаачилгыг бууруулж магадгүй. |
| Мал аж ахуйн үйлдвэрлэл илүү ашигтай болбол малын тоо толгой өсч ялангуяа усны эх үүсвэр хомс газар нутагт хөрсний доройтолд хүргэж болзошгүй. | Бэлчээрийн нутаг хомсдож амьжиргааны боломж багассанаас дотоод шилжих хөдөлгөөн нэмэгдэж магадгүй. | Зохистой техникийн дэмжлэггүйгээр хамгааллын зардлыг нэмэгдүүлбэл төлөвлөлт муутай байгаль хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлж магадгүй юм, жишээ нь нөхөн сэргээлтэд ганц зүйл ургамал ашиглах, усны нөөцийн дэд бүтэц г.м. |
| Усны эх үүсвэр нэмэгдсэн газар нутагт ХАА ба жижиг бизнес өргөжиж хөрсний доройтолд хүргэж болзошгүй. Химийн бордооны хэрэглээ ялангуяа ХАА ойн салбарт өсч магадгүй. | Түлшний мод болон бусад байгалийн нөөцөөс хамаарах хамаарал өсч магадгүй (өөрөөр хэлбэл өөр эрчим хүчний эх үүсвэр ашиглах эсвэл амьжиргааны арга барилаа өөрчлөхийн оронд). | Мал бэлчээх бэлчээрийн талбай хомсдож газрын менежментэд өргөн хүрээнд нөлөөлөх, бэлчээрт зориулсан эсвэл хориглосон газар нутгийг зохицуулах эрх зүйн орчин хангалтгүй. |
| Нөхөн сэргээсэн газар нутгийг хамгаалахад зориулсан хашаа болон бусад арга хэмжээ нь зэрлэг ан амьтны нүүдэл хөдөлгөөнийг хязгаарлана. | Зорилт бүлгүүдэд өөр төрлийн эрчим хүчний эх үүсвэр, мод боловсруулах шинэ технологи г.м. боловсронгуй арга технологийг ашиглах хөрөнгө дутмаг эсвэл тэгш бус, олдоц муу зэрэг бэрхшээл тулгарч болзошгүй | Хувийн хэвшлийн олборлогч, боловсруулагчид болон засгийн газрын харилцаа сайжирснаар малчид, тариаланчид болон ойн дагалт баялаг хэрэглэгчдийн эрх хаягдах, хязгаарлагдах. |
| Хуурай газрын ойн экосистемд авч хэрэгжүүлсэн байгаль хамгааллын арга хэмжээний үр дүнд заган ой ургаснаар шар чичүүл болон загаар хооллодог хортон шавж өсөх магадлалтай. | REDD+ БАХ-үүд том хэмжээний ойн аж ахуй, боловсруулах компанид илүү өгөөжтэй харин жижиг компаниуд тэдэнтэй өрсөлдөх боломжгүй болох, жижиг ААН-үүд болон нөхөрлөлүүд зээлийн хөрөнгийн олдоц нэмэгдсэн мөн шинэ технологи нэвтрүүлэх хэрэгцээ шаардлагаас болж төлбөрийн чадваргүй болох магадлалтай. | |
| | Жендерийн тэнцвэрт байдлын эрсдэл, жишээ нь эрчүүдэд ажил олох боломж нэмэгдэж жендерийн харьцаа алдагдах. | |

**REDD+ ийн үйл ажиллагааны эрсдэл**

- Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл нь ойн байгалийн нөхөн сэргээлтийг удаашруулж нөхөн сэргээлтийн БАХ-ний биелэлтэд нөлөөлөх.
- Агро ойн аж ахуйн загварууд бүх газар нутагт эсвэл бүх төрлийн ойд тэр бүр тохирохгүй байх, үүнээс болж хэрэгжилт жигд бус эсвэл тогтворгүй байх.
- Улс төрийн нөхцөл байдлаас шалтгаалж бодлого, хөтөлбөр ойр ойрхон өөрчлөгдөх нь БАХ-ний тогтвортой байдлыг эрсдэлд оруулна.
- Хяналт шалгалтын системийг сайжруулахгүй бол хөнөөлт шавжтай тэмцэхдээ үр дүн муутай арга хэмжээ хэрэгжүүлж үр дүнг нь зохистой үнэлэхэд хүндрэл учрах.
- Хөнөөлт шавжтай тэмцэх биологийн аргууд уур амьсгалын өөрчлөлтийн нөхцөлд үр дүн муутай байх.

*Бодлогын түвшний БАХ-нүүдтэй холбоотой үр дүн*

Үндэсний түвшинд бодлогын шинэчлэл хийхэд чиглэсэн REDD+-ийн БАХ-нүүдээс үүдэж болох нөлөөллийг авч үзэхийн холбогдох бичиг баримтуудыг судлах, талуудтай уулзаж, зөвлөлдөх зэрэг ажлыг хэрэгжүүлсэн. Үндэсний REDD+ хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэхээр санал болгож буй доорх бодлогын түвшний дөрвөн БАХ-нд үнэлгээ хийв:

1. Олон улсын стандартад нийцсэн ойн гэрчилгээний үндэсний стандартыг бий болгож мөрдүүлэх.
2. Ногоон худалдан авалтын хөтөлбөрөөр дамжуулан модон бүтээгдэхүүний хэрэглээг дэмжих (Төрийн өмчийн байшин барилгад Монголд үйлдвэрлэсэн модон тавилга хэрэгсэл болон бусад тогтвортой эх үүсвэртэй, дотоодын бүтээгдэхүүн худалдан авах).
3. Хувийн хэвшил болон банкны байгууллагуудтай хамтран Нөлөөллийн Хөрөнгө оруулалтын сан байгуулах.
4. Ойн нөхөрлөл болон орон нутгийн бүлгүүдэд зориулж байгалийн нөөц хэрэглэгчдийн эрх болон зохицуулалтыг сайжруулах үүднээс бодлогоор дэмжих тогтолцоо бий болгох.

Тэдгээр бодлогын түвшний БАХ-үүд үндэсний түвшинд хэрэгжих магадлалтай бөгөөд бодлогын өөрчлөлт ба санхүүгийн зохицуулалтын дүнд эргээд ой болон газар нутгийн менежментийн арга барил өөрчлөгдөхөөс үүдээд эерэг үр нөлөө ба эрсдэл үүсгэх арга замууд нь илүү нарийн эсвэл шууд бус байх магадлал өндөртэйЭнэхүү үнэлгээний арга нь бодлогын нөлөөллийг үнэлэх гурван аргачлал дээр суурилсан. Тэдгээр нь:

- Нөлөөлөл дамжих сувгуудад дүн шинжилгээ хийх: Энэ аргыг Дэлхийн банк боловсруулсан бөгөөд аливаа бодлогын шинэчлэлийн үр дүнд бий болох ядуурал болон нийгэмд үзүүлэх бусад нөлөөллийг үнэлэхэд чиглэсэн байх ба ингэхдээ тэдгээр нөлөөлөл нь хэрхэн дамжих, хэнд нөлөөлж болох мөн үр дүн нь хэзээ илрэх зэрэгт анхаарал хандуулдаг.
- Монгол Улсын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн журмыг (Засгийн газрын 2016 оны 59-р тогтоолын 3-р хавсралт) үнэлж үзэхэд, энэ журамд шинээр санал болгож буй хууль тогтоомжийн үзүүлэх нөлөөллийн үнэлгээг хийх арга замыг зааж өгсөн байна. Үүнд, учирч болох нөлөөллийг үнэлэх үндсэн 6 шалгуураас гадна шалгуур тус бүрийн зааварчилгаа багтана.
- Их Британийн Нэгдсэн Вант Улсын Засгийн хэрэгжүүлдэг газрын хууль тогтоомжийн нөлөөллийн үнэлгээ: Нэгдсэн Вант Улсын хууль тогтоомжийн нөлөөллийн үнэлгээ (RIA)-ний зорилго нь санал болгож буй хууль тогтоомжийн зорилгуудыг тодорхойлж эрсдэлүүдийг тооцох, зорилгуудыг биелүүлэх сонголтууд, хамрагдсан талуудад гарч болох урьдчилан тооцоолсон зардлууд ба үр ашгууд мөн бусад хууль тогтоомжид хэрхэн нийцэх, хэрэгжилтийг хэрхэн хангах зэргийг судлах явдал юм. Олон нийтийн хэлэлцүүлэг ба хяналт шалгалт үнэлгээний шалгуурыг бас авч үзнэ.

Санал болгож буй БАХ-нүүдэд ашиглах багц асуулт бэлдсэн ба үнэлгээ хийхдээ эхлээд холбогдох баримт бичгүүдийг судалж, дараа нь СНСЗ-СНСМС-ийн ТАХ[9]-ийн хурлаар хэлэлцүүлсэн. Гарсан үр дүнг дор тоймлон харуулав:

[9] 2017 оны 9 сард зохион байгуулсан хурлын тайлангаас илүү мэдээлэл авч болно: Англи хэл дээр, Монгол хэл дээр

Дээрх дөрвөн ***БАХ-г хэрэгжүүлсний үр дүнд ойн болон газрын менежментийн арга барил*** өөрчлөгдөх магадлалтай бөгөөд ингэснээр REDD+ -ийн зорилгуудаас хальж зарим тохиолдолд тэдгээр зорилгуудтай зөрчилдөж ч болзошгүй. Жишээ нь:

- Ойн салбарын хөрөнгө оруулалт, ашиг орлого нэмэгдсэнээр дотоодын модон бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээ өсч мод бэлтгэхэд ашигладаг талбай тэлэх эсвэл одоогийн мод бэлтгэл эрчимжих зэрэг үр дагаварт хүргэж болзошгүй. Энэ нь ойн бүтээмжид сайнаар нөлөөлж болох боловч биологийн олон янз байдал болон экосистемийн үйлчилгээг хамгаалахад хүндрэл учруулна (доор харна уу).
- Ойн менежмент идэвхжих мөн ойжуулалт нэмэгдсэн тохиолдолд ойн газар нутгийг бусад зориулалтаар ашиглахад (бэлчээрийн, ойн дагалт баялаг ба түлээний мод бэлтгэх г.м.) нөлөө үзүүлж магадгүй ба ингэснээр ойн доройтол буурах боловч иргэдийн амьжиргаанд сөргөөр нөлөөлнө. Ойн ААН-үүд ба эсвэл иргэд тодорхой **ойн талбай**т уламжлалт амьжиргаа эрхлэх боломж нь хязгаарлагдсанаар өөр газар нутагт мод бэлтгэх, х эсвэл хууль бус арга зам хайх хэлбэрт шилжих эрсдэлтэй. Мөн одоогийн бэлчээрийн талбайн ачаалал нэмэгдэж магадгүй.

Эдгээр БАХ нь мөн **биологийн олон янз байдал ба экосистемд** урт хугацааны нөлөөлөл үзүүлэх магадлалтай ба үүнд:

- Ойн салбарын хөрөнгө оруулалт өсч модон бүтээгдэхүүний хэрэгцээ нэмэгдсэнээр ойн менежмент идэвхжиж ойжуулалтыг дэмжих ажил нэмэгдэх ба ингэснээр ойн бүрхэвч ба бүтээмж сайжирна. Мод бэлтгэх хэмжээ үндэслэл сайтай бөгөөд тогтвортой байж чадвал ойн өсөлт сайжирч болно (жишээ нь тогтвортой бус мод бэлтгэлийн горим эсвэл идэвхтэй менежмент, хамгаалал дутагдсанаас доройтолд орсон ойн талбайтай харьцуулахад). Энэ нь зарим экосистемийн үйлчилгээнд эерэг үр нөлөө үзүүлж болох боловч (жишээ нь хөрсний эвдрэлтэй тэмцэх, усны зохицуулалт г.м.) модны амьдралын мөчлөгийн сүүлийн шатанд бий болж үрждэг зүйлүүд болон унанги модны орчинд амьдардаг биологийн олон янз байдлын зарим бүрэлдэхүүн хэсэгт сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.
- “Ногоон” худалдан авалт, ногоон хөрөнгө оруулалт ба гэрчилгээ олголт зэрэгтэй хамаатай хатуу шаардлагуудыг хэрэгжүүлснээр ойн менежмент сайжирч, мод бэлтгэлийн сөрөг нөлөөлөл буурна. Мөн хамгааллын ач холбогдол өндөртэй, нүүрстөрөгчийн шингээлт ихтэй ойн хамгаалал байдал сайжирч, экосистемийн үйлчилгээ ба биологийн олон янз байдалд эерэг нөлөөлнө. “Ногоон” гэж юуг тодорхойлж буйгаас хамааран тэдгээр шаардлагыг хэрэгжүүлснээр ойн салбарын байгаль орчны болон нийгмийн үйл ажиллагааг сайжруулах үр нөлөө үзүүлж болно. Жишээ нь хог хаягдлын менежмент, эрчим хүчний эерэг үр нөлөөтай хэрэглээ болон ажилчдын аюулгүй ажиллагааны арга барил сайжрах г.м.
- Ойн төлөв байдал болон экосистемийн үйлчилгээ сайжирснаар эргээд ойн болон ойгоос хамааралтай аж төрдөг нутгийн иргэдийн дунд уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах чадавхыг дээшлүүлэх нөлөө үзүүлнэ.
- Хэдий тийм боловч дээр дурдсанчлан ойн бүтээгдэхүүний ашиг ба эрэлт хэрэгцээ нэмэгдсэнээр мод бэлтгэл хэт өсч хэвийн байдал алдагдах (зам нэмэгдсэн, хүрэхэд хялбар болсон г.м.) магадлалтай ба ойн экосистемүүд болон биологийн олон янз байдалд сөрөг нөлөөтэй. Мод бэлтгэлийн хэмжээ хэтэрсэн эвсэл удаан хугацаанд үргэлжилсэн бол (хэдий харьцангуй тогтвортой байсан ч) ойн эрүүл мэнд, үүрэг ба экосистемийн үйлчилгээнд үзүүлэх сөрөг нөлөө хуримтлагдах ба үүнд нүүрстөрөгчийн агууламж ба шингээлт зэрэг багтана.

- Малчид болон бусад ойн ашиглагчдыг өөр ойн талбай эсвэл бусад экосистемд нүүлгэн суурьшуулах нь бэлчээрийн ачаалал зэрэг дарамт тэдгээр бүс нутагт шилжиж газрын доройтолд хүргэх эрсдэлтэй.

Орон нутаг болон нутгийн иргэд зэрэг оролцогч талуудад учрах ***нийгмийн нөлөөллийн*** хүрээнд дараах асуудлыг тодорхойлов:

- Ойн салбарын хөрөнгө оруулалт ба үр ашиг өсч ойн ашиглагчид ойн нөөц, баялгийг ашиглах боломцоо нэмэгдсэнээр тэдний ажил эрхлэх, амьжиргаагаа залгуулах боломж өснө. Түүнээс гадна мод бэлтгэх, болосвруулах техник технологи боловсронгуй болсноор хөдөлмөрийн бүтээмж, ажилтны чадвар, эрүүл мэнд ба аюулгүй ажиллагааг сайжруулна. Гэхдээ бүтээмж өсч гар ажиллагаа багассанаар тус салбар дах ажлын байрны тоо яваандаа буурах эрсдэлтэй.
- Хэрэглэгчдийн эрхийг хангах мөн гэрчилгээ олгох зэрэг үйл явцын эрх зүйн орчин сайжирснаар засгийн газрын агентлагууд, ААН-үүд болон ойн нөхөрлөлүүд зэрэг гол оролцогч талуудын хамтын ажиллагааны түвшин дээшилнэ.
- Гэсэн хэдий ч ойн менежмент ба хамгаалал, ойжуулалтын үйл ажиллагаа сайжрах нь зарим иргэдийн амьжиргаанд нөлөөлж болох юм (жишээ нь бэлчээрийн талбай, ойн дагалт баялаг, түлээний мод түүх боломж хомсдох г.м.). Түүнээс гадна түлээний мод мэтийн модон бүтээгдэхүүний олдоц багасч үнэ нь өссөн тохиолдолд хэрэглэгчдэд сөрөг нөлөө үзүүлнэ.
- Эдгээр БАХ-нүүд ойн нөхөрлөл, нутгийн иргэд болон ААН-ийн хоорондын сонирхлын зөрчлийг нэмэгдүүлж болзошгүй. Жишээ нь, засгийн газрын байгууллагууд болон ойн нөхөрлөлийн хамтын ажиллагаанд нутгийн иргэдийг оролцуулаагүй тохиолдолд зарим иргэд дургүйцэх, харин ААН-үүд болон ойн нөхөрлөлүүд ой бүхий газар нутгийг ашиглах эрхтэй холбоотойгоор сонирхол нь зөрчилдөх г.м эрсдэлтэй. Ойн нөхөрлөлийн гишүүн бус иргэд, ялангуяа залуучууд ба эмэгтэйчүүдийн REDD+-ийн үйл ажиллагаанд оролцох оролцоо хангалтгүй тэр ч бүү хэл бусад оролцогч талуудын оролцоо нэмэгдэх хирээр буурах магадлалтай. Гэрчилгээ олгох үйл явцад жижиг ААН ба нөхөрлөлүүд оролцох чадавхи дутагдаж, том компаниудад ашигтай байж магадгүй.
- Дотоодын үйлдвэрлэгчдэд давуу тал үүссэнээр, ялангуяа БАХ хэрэгжүүлсний үр дүнд гаалийн татвар (жишээ нь импортын татварыг нэмэгдэх г.м) өөрчлөгдсөн тохиолдолд модон бүтээгдэхүүн импортлогч компаниудад сөрөг нөлөө учирч болзошгүй.

Бодлогын түвшний БАХ-нд үнэлгээ хийхдээ **үр *хувирах ба сөрөг нөлөө шилжиж*** болзошгүй эрсдэлд онцгой анхаарал хандуулав:

- Шилжих эрсдэл: модон бүтээгдэхүүний хэрэгцээ өсөн нэмэгдэх нь яваандаа үйлдвэрлэл явуулах ойн нөөц буурч мод бэлтгэл бусад ойн талбай руу халих (тэгснээр доройтолд хүргэх) эсвэл импортын хэмжээ нэмэгдэх эрсдэлийг дагуулна; малчид, тариаланчид болон бусад баялгийн нөөц хэрэглэгчид зарим ойн талбайд нэвтрэх боломжгүй болсноор өөр бусад ойн болон ойн бус талбайг ашиглах болсноор үр дүнд нь мөн адил тэдгээр газар нутаг доройтолд орох (жишээ нь бэлчээрийн даац хэтрэх) эрсдэлтэй: “ногоон” шаардлагыг зөвхөн зарим зах зээлд нэвтрүүлснээр гэрчилгээ олгогдоогүй газраас бэлтгэсэн бүтээгдэхүүнүүдийг өөр бусад зах зээлд борлуулсан хэвээр байх эрсдэлтэй. .
- Хувирах эрсдэл: Ойн нөөцийн хэрэгцээ ихэсвэл мод бэлтгэл хэт их нэмэгдэх бөгөөд үүний улмаас ойн менежментийн үр дүнд бий болсон нүүрстөрөгчийн шингээлт

нэмэгдсэн үр дүн талаар болох эрсдэлтэй; улс төрийн байдал ойр ойрхон өөрчлөгдсөний улмаас бодлого өөрчлөгдөх, цаашлаад олон нийтийн салбарын төсөв хасагдах, алдагдал нэмэгдэх эрсдэлтэй; ойн салбарын (одоогийн байдлаар санхүүгийн байгууллагуудын оролцоо бага) хөрөнгө оруулалтын эрсдэлүүд нөлөөллийн хөрөнгө оруулалтын сан байгуулах зэрэг БАХ-ний хэтийн үр дүнг тогтворгүй болгох эрсдэлтэй; хангалттай техникийн дэмжлэг үзүүлэхгүй байх, эсвэл зах зээлийн хүрэлцээг сайжруулахгүй бол яваандаа ААН-ийн хувьд гэрчилгээ олгох зардал хэт өндөр болох ялангуяа үнэ дээд цэгтээ хүрэхгүй, борлуулалт өсөхгүй тохиолдолд эсвэл бусийн эсвэл орон нутгийн зах зээлд тогтвортой бус эх үүсвэрээс бэлтгэсэн бүтээгдэхүүний өрсөлдөөн хэт их байвал аж ахуйн нэгжүүдэд хүндрэл учирна: мөн ой ашиглалтын гэрээний хугацааг эргэн харах шаардлагатай учир нь богино хугацааны гэрээ нь гэрчилгээ олгоход хөрөнгө оруулалт хийх сонирхлыг бууруулах эсвэл тогтмол хэмжээнд барихад хүндрэлтэй болгох талтай.

Бодлогын түвшний БАХ-ний үнэлгээний сүүлчийн бүрэлдэхүүн хэсэгт ***үндэсний бусад гол бодлого, хууль ба хөтөлбөрт хэрхэн нийцэж*** буйд анхаарал хандуулсан. Эдгээр дөрвөн БАХ бүгд Ногоон хөгжлийн бодлого, Парисын хэлэлцээрт оруулах Үндэсний хувь нэмэр ба Ойн талаар төрөөс баримтлах бодлого болон Тогтвортой хөгжлийн зорилтууд зэрэг бодлогыг дэмжих нь тогтоогдсон. Харин эдгээртэй нийцэхгүй байж болзошгүй зөрчилтэй зүйлсийг тодруулсан. Үүнд:

- Ойн зарим бүтээгдэхүүний ашиглалтыг нэмэгдүүлэх нь  Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн зарим зүйл заалттай зөрчилдөж магадгүй. Түүнээс гадна ойн нөхөрлөлүүдийн  ойн баялаг ашиглах эрхийг нэмэгдүүлэхийн тулд Ойн тухай хуульд нэмэлт өөрчлөлт шаардагдаж магадгүй.
- Хэт ашиглалтаас үүдэн  биологийн олон янз байдлын хамгаалал болон газрын доройтолтой тэмцэхэд  сөрөг үр дагаварууд бий болж улмаар Биологийн олон янз байдлын тухай конвенц, НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенцийн дагуу Монгол улсын хүлээсэн зорилтууд ба холбогдох үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэд саад болж болох тул тэдгээр нөлөөллийг  сайтар анхаарах шаардлагатай.
- Орон нутгийн иргэдийн амьжиргаа, тэр тусмаа нүүдлийн мал аж ахуйд учрах эрсдлүүдийг Монгол Улсын нийгэм эдийн засгийн хөгжлийн зорилтууд, Ногоон хөгжлийн бодлогод тусгасан бэлчээрийн газар нутагтай холбоотой  зорилтууд мөн уламжлалт аж амьдралын хэв маягийг хадгалах бодлогуудын хүрээнд дахин нягталж арга хэмжээ авах шаардлагатай.

## 4.4 Зөвлөмж

REDD+-ийн үр ашиг ба эрсдэлийг үнэлэхдээ нэн чухал үр  ашгийг дээшлүүлж, хамгийн гол гэж эрэмбэлсэн эрсдэлүүдийг бууруулахын тулд хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээг мөн тодорхойлсон. Энэ ажил дээр үндэслэн Үндэсний REDD+ хөтөлбөр болон БАХ-нүүдийг цаашид боловсруулахтай холбоотой зөвлөмжүүдийг дэвшүүлсэн. Эдгээр зөвлөмж нь REDD+-ийг хэрэгжүүлж эхлэхээс өмнө авах шаардлагатай алхмуудыг хамарч, БАХ-г төлөвлөж хэрэгжүүлэхэд анхаарах зүйлс, тухайлбал тодорхой БАХ-г хэрэгжүүлэхтэй холбоотой хийх эрхзүйн шинэчлэл зэрэг асуудлыг  уялдуулж авч үзэхийг санал болгосон. Зөвлөмж болгосон арга хэмжээг БАХ-нүүдийг боловсруулж, хэрэгжүүлэхдээ тусгахын зэрэгцээ тэдгээрийн бодит хэрэгжилтэд хяналт тавих асуудлыг REDD+ хэрэгжилтийн хяналт, үнэлгээний систем, СНСМС зэрэгт суулгасан байх шаардлагатай.

БАХ тус бүрээр боловсруулсан дэлгэрэнгүй зөвлөмжийг Хүснэгт 2-т нэгтгэн үзүүлэв.

*Хүснэгт 2: Үр ашиг, эрсдэлийн үнэлгээнээс гарсан зөвлөмжийн тойм*

| **REDD+ явцыг хэрэгжүүлэх эхлэхээс өмнө авах шаардлагатай арга хэмжээ** |
| --- |
| • Хэд хэдэн БАХ-нд унанги мод болон бусад модон бүтээгдэхүүний ашиглалтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн. Ашиглалт БАХ-д тодорхой тусгахад тус болох үүднээс **санал болгож буй мод бэлтгэлийн хэмжээг цаашид гарч болох өөрчлөлттэй харьцуулахад урт хугацаанд ямар сөрөг нөлөөлөл үүсч болохыг** баримт нотолгоогоор нэгтгэж харуулах шаардлагатай (эсвэл болзошгүй нөлөөллийн үнэлгээг хийх, жишээ нь бодит нотолгоо байхгүй тохиолдолд бусад тайгын ойн талбайн харьцуулалт дээр суурилсан үнэлгээ хийж болно)[10]. Ингэснээр санал болгож буй мод бэлтгэлийн ашиглалтын горимын мөн чанарыг сайтар ойлгож авахын зэрэгцээ нүүрстөрөгчийн ба нүүрстөрөгчийн бус эерэг үр нөлөө, эрсдэлүүдийн талаар мэдлэгтэй болж, улмаар Монголын ойд тохирсон арга хэмжээ төлөвлөх боломж бүрдэнэ. Энэ үнэлгээний хүрээнд дараах зүйлсийг үнэлэх ёстой. Тухайлбал, урьдчилан таамаглаж буй ашиглалтын ашиглал төсөх хэмжээ,хэт нь нүүрстөрөгчийн нөөцөд нөлөөлөх эерэг ба сөрөг дагавар, биологийн олон янз байдал, экосистемийн үйлчилгээнд учирч болзошгүй нөлөөлөл, мөн ойн нийгэм эдийн засгийн эерэг үр нөлөө зэрэг болно.<br>• Экосистемтэй холбоотой (жишээ нь экосистемийн үйлчилгээ болон биологийн олон янз байдлын хамгаалал сайжрах г.м) үр ашгийг дээшлүүлж (хүлэр намагтай газар, усны нөөц болон бусад тэргүүлэх ач холбогдолтой газар нутагт нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах г.м) эрсдэлийг бууруулахын тулд юуны өмнө хаана БАХ-нүүдийг хэрэгжүүлбэл экосистемийн өндөр үр ашиг бий болж, эрсдэл бага байж болохыг **тооцож тохирох газар нутгийг сонгох үнэлгээ** хийх шаардлагатай. Экосистемийн үйлчилгээ, зэрлэг ан амьтан, ургамлын амьдрах орчинтой холбоотой бусад хүчин зүйлсэд чухал ач холбогдолтой газар нутгийг сонгохын тулд орон зайн анализ болон орон нутгийн иргэдтэй зөвлөлдөх нь тустай. Мөн ойн бус экосистемд (бэлчээрийн газар нутаг, намаг, хүлэр намагтай газар г.м.) учирч болзошгүй нөлөөлөлд анхаарал хандуулах хэрэгтэй. REDD+-ийн хувьд хамгийн чухал гэж үзэх экосистемийн үйлчилгээг тодорхойлж, баталгаажуулах үнэлгээг хийхдээ олон талыг хамруулж, хэлэлцүүлэг зохион байгуулах нь чухал.<br>• Ялангуяа Монгол улсын хувьд шинээр хэрэгжүүлэх гэж байгаа эсвэл өмнө нь үнэлгээ хийгдэж байгаагүй БАХ-нд (жишээ нь экосистемийн үйлчилгээний төлбөрийн схем, Ойн цэвэрлэгээ хөтөлбөр г.м.) хууль тогтоомжийн дагуу (жишээ нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль) **байгаль орчны болон нийгмийн нөлөөллийн үнэлгээ**, зардал-үр ашгийн анализ хийх нь зүйтэй бөгөөд үүнд орон нутгийн иргэд болон бусад оролцогч талуудад (жишээ нь, хувийн хэвшилд) байгалийн баялаг хүртэх эрхтэй холбоотой үүсэж болох нийгэм эдийн засгийн нөлөөллийг багтаан авч үзэх шаардлагатай. БАХ-ний хуримтлагдах нөлөөллийг үнэлгээнд Байгаль орчны стратегийн үнэлгээний журам зэргийг ашиглах нь тустай. БАХ-нүүдийг хэрэгжүүлэх орон нутгийн төлөвлөгөө, гэрээний баримт бичигт байгаль орчны болон нийгмийн нөлөөллийн асуудлуудыг тусгах шаардлагатай.<br>• **Санал болгож буй дэд бүтцийг хөгжүүлэх арга хэмжээ** (жишээ нь, ойн зам)-ний сөрөг нөлөөллийг бууруулж, үр ашгийг дээшлүүлэхийн тулд Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх шаардлагатай. Ойн замаас үүдэх хуримтлагдах нөлөөлөл болон байгаль орчны стратегийн үнэлгээг тооцохдоо ойн замын сүлжээг нийтэд нь (жишээ нь том, хоорондоо холбогдсон ойн талбайд г.м) хамруулах шаардлагатай бөгөөд мөн замын |

[10] Түргэвчилсэн байдлаар, ямар нэг системчлэлгүйгээр нягталж үзэхэд сэрүүн бүсийн тэр дундаа монголын сэрүүн бүсийн ойн менежменттэй холбоотой ангил хэлээрх судалгааны материал маш цөөн байдаг нь ажиглагдлаа. Сэрүүн бүсийн ойн менежментийн үр дүн тухайн ойн сан бүхий талбайгаас шалтгаалдаг учир ойн цэвэрлэгээ, арчилгааны огтлолын үр дүнг урьдчилан хэлэхэд хэцүү. Бусад сэрүүн бүсийн ойн талбайд хийсэн судалгаанаас харахад биологийн олон янз байдалд үзүүлэх нөлөөлөл тухайн зүйл тус бүрд харилцан адилгүй байх бөгөөд зарим зүйлд эерэг нөлөөлж байхад заримд нь сөргөөр нөлөөлдөг аж. Ойн цэвэрлэгээ болон арчилгааны огтлолд ашигласан арга барилаас хамаарч хөнөөлт шавжийн хор хөнөөл, ойн түймрийн эрсдэлийг бууруулдаг нь харагдаж байна. Тэдгээр менежментийн арга барил нийгэм эдийн засгийн эерэг нөлөө үзүүлдэг нь батлагдсан байгаа боловч санамсаргүй байдлаар сэрүүн бүсийн ойд нэмэлт дарамт, хүний хүчин зүйлээс үүдэлтэй ачаалал үзүүлэх үр нөлөө бас байдаг байна.

засвар, үйлчилгээний хэрэгцээг тооцох ёстой. Өмнө нь тавигдсан ойн замын нөлөөллийг үнэлэхдээ доройтлыг бууруулахад нөлөө үзүүлсэн тавигдсан ойн замын нөлөөллийг холбоотой доройтлыг бууруулсан эсэхийг тодорхойлохын тулд орон зайн үнэлгээ хийх шаардлагатай. Боломжтой бол замын байршил ба төлөвлөлтөд олон талын шалгуурыг дээд зэргээр хангах хэрэгтэй ба үүнд: түймэртэй тэмцэхэд тохиромжтой эсэх, хөнөөлт шавжийг бууруулах, ойн тогтвортой менежмент ба орон нутгийн хэрэглээ зэрэг багтана. Тэдгээр үйл ажиллагаа болон замын нөлөөллийг REDD+-ийн мониторингийн нэг салшгүй хэсэг болгон тусгах ёстой.

- **Ойд нэвтрэх болон ойн нөөц баялаг ашиглах эрх хаагдахтай холбоотой** олон тооны эрсдэлийг тодорхойлсон ба үүнд бэлчээр ашиглах эрх багтана. Ойн болон бэлчээрийн эрх хөндсөн БАХ-ний тухайд хамрагдах нөөц баялаг, эрсдэлд өртөж болзошгүй хэрэглэгчдийн бүлгийг тодорхойлох шаардлагатай. Нутгийн иргэдийг амьдарч байгаа орон нутгаас нь нүүлгэн шилжүүлэх, зөрчил үүсэхээс сэргийлэх, ийм эрсдэлийг бууруулах үүднээс ойн нөөц баялаг ашиглах эрхийг бэлчээрийн нөөц ашиглах эрхтэй хамаатуулах бололцоо бий эсэхэд үнэлгээ хийх хэрэгтэй. Тэдгээр эрхийг хөндсөн БАХ-ээг хэрэгжүүлэхээс урьтаж холбогдох бүх оролцогч талуудыг хамруулан хэлэлцээр хийж нэгдсэн шийдэлд хүрэх ёстой.
- Байгалийн нөөц баялгийн төлбөрийг зохицуулахтай холбоотой БАХ дээр өөр төрлийн үнэлгээ санал болгосон. Одоогийн **байгаль хамгаалалд зориулж буй санхүүгийн урсгалын** зураглалыг гаргаж орлогын эх үүсвэрүүд болон тэдгээрийг хэрхэн зарцуулж буйг харуулах хэрэгтэй. Түүнд мөн ирээдүйд байгалийн нөөц баялгийн төлбөрөөс орж ирэх магадлалтай орлогын эх үүсвэрийг тусгаж байгаль хамгааллын хэрэгцээний үнэлгээ хийх буюу орлогыг хэрхэн хамгийн үр ашигтайгаар зарцуулж болохыг судлах шаардлагатай.
- **БАХ-ний хүрээнд уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах чадавхыг бэхжих нь чухал гэдгийг** ойлгох нь чухал. Орон нутгийн зүгээс уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг өртөмтгий байдал, уур амьсгалын өөрчлөлт эргээд БАХ-нд сөргөөр нөлөөлөх магадлалтай эсэхийг үнэлэх нь чухал. Ийм үнэлгээг хийснээр бэлчээрийн болон мал аж ахуйн менежмент, орон нутгийн хөгжил ба дасан зохицох байдал, ойн нөхөн сэргээлт, хөнөөлт шавжтай тэмцэх, түймрээс урьдчилан сэргийлэх ба тэмцэх зэрэг үйл ажиллагаанд чухал нөлөөтэй. Монгол орны уур амьсгалын өөрчлөлтийн урьдчилсан таамгаас харахад дээрх арга хэмжээнүүдийг боловсруулж төлөвлөхдөө дасан зохицох чадварыг нэмэгдүүлэхэд анхаарч, дасан зохицох чадварыг бууруулах сөрөг дагавраас зайлсхийсэн байх нь зүйтэй юм. Экосистемд суурилсан дасан зохицох арга барилыг дэмжих хэрэгтэй. Одоо хэрэгжиж байгаа ойн салбарын уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадвар ба Үндэсний дасан зохицох хөтөлбөрийн бэлтгэл судалгаа нь шаардлагатай ойлголтыг бий болгоход хувь нэмэр оруулна.
- Санал болгож буй **Нөлөөллийн хөрөнгө оруулалтын сангийн** хувьд ийм төрлийн сантай холбоотой эрх зүйн тогтолцоо ба уг сангийн санхүүжилтэд ойн салбарыг хамруулахын тулд одоо ажиллаж байгаа сангууд болон механизмуудыг зохицуулан өөрчилж болох эсэх (шинэ сан байгуулахын оронд) талаар үнэлгээ хийх нь зүйтэй.
- **Агро ойн аж ахуйн салбар** нь Монгол улсын хувьд харьцангуй шинэ туршлага бөгөөд энэ нь иргэдийн амьжиргаа болон байгаль орчинд эрсдэл учруулж болзошгүй. Зохих ТЭЗҮ боловсруулах хэрэгтэй ба Монголын болон ижил төстэй нөхцөлтэй бусад улс орны агро ойн аж ахуйн салбарын туршлагыг харгалзан үзэж, байгаль орчинд ээлтэй арга хэрэгсэл, агро ойн аж ахуйн салбарын бүтээгдэхүүний зах зээлийн судалгаа, зохих зүйл ургамал мөн уур амьсгалын өөрчлөлтийн болзошгүй нөлөөллийг тусгах шаардлагатай. Агро ойн аж ахуйн салбарын загварыг тухайн газар, орон нутагт тохируулан өөрчлөх хэрэгтэй.
- **Хөнөөлт шавжийн тэмцлийн ажилтай холбоотой БАХ** нь бодит баримт, нотолгоонд тулгуурласан байх ёстой ба одоогийн байдлаар өмнө нь явуулж байсан, одоо хэрэгжүүлж байгаа хөнөөлт шавжтай тэмцэх хөтөлбөрийн үр дүнгийн талаар тодорхой мэдээлэл дутагдалтай байна. Мөн хөнөөлт шавжтай тэмцэх шинэ арга хэмжээний эерэг үр нөлөөг дээшлүүлж сөрөг нөлөөг бууруулахын тулд тэдгээрийн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ мөн хөнөөлт шавжийн тархалт ба түүнтэй тэмцэхэд уур амьсгалын өөрчлөлтийн үзүүлэх нөлөөллийн урьдчилсан таамгийн тооцоолол гүйцэтгэх шаардлагатай. Хязгаарлагдмал нөөц бололцоог аль болох үр дүнтэй ашиглаж үр ашгийг нэмэгдүүлэхийн тулд тэмцлийн ажил явуулах гол бүс нутгийг тодорхойлж хэрэгжүүлбэл зохино.

- Одоо байгаа бүтэц дээр суурилан **үр ашиг болон урамшууллыг тэгш хуваарилах арга зам** боловсруулах хэрэгтэй. Тэдгээр бүтэц зохион байгуулалт нь сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудад нийцсэн, мөн хяналт шалгалтыг зохих ёсоор хэрэгжүүлэхэд зохицсон байх талаарх удирдамжаар хангах шаардлагатай. Зөрчил болон менежментийн алдааны эрсдэлийг бууруулахын тулд холбогдох бүх оролцогч талуудыг дэлгэрэнгүй, ил тод мэдээллээр хангах ёстой, жишээлбэл үр ашиг хүртэгсэд ба арга хэмжээ хэрэгжүүлэх байршлыг хэрхэн сонгосон, урамшуулал, ашгийн төлбөрийн нөхцөл, урамшуулал үр ашгийг хэрхэн хуваарилж байгаа, оролцогчдын үүрэг ба хариуцлага, урамшуулал үр ашгийн хуваарилалт, мөн холбогдох гомдол барагдуулах механизмуудын талаар ил тод мэдээлж байх нь зүйтэй.
- Орон нутгийн тогтвортой хөгжлийг цаашид дэмжихийн тулд тогтсон **орон нутгийн хөгжлийн сангуудын** тоог төрөөс нэмж тэдгээрийг орон нутгийн үйл ажиллагааг дэмжихэд, жишээ нь жижиг бизнесийг хөгжүүлэхэд ашиглахыг зөвшөөрөх ёстой. Орон нутгийн хөгжлийн сангуудын санхүүжилт ба зарлагуудыг ил тод байлгаж хяналт шалгалт тавих ёстой.
- REDD+-ийн үйл ажиллагааны эдийн засгийн өгөөжийг, тухайлбал ойн бүтээгдэхүүн боловсруулах асуудлыг хамарсан БАХ-ний үр ашгийг дэмжихийн тулд гол бараа, бүтээгдэхүүн дээр **зах зээлийн эрэлтийн үнэлгээ, зах зээлийн олдоц, мөн нийлүүлэх шат дамжлагын үнэлгээ** хийж боломж боломжоо ба саадыг тодорхойлох шаардлагатай (жишээ нь гэрчилгээтэй модон бүтээгдэхүүний эрэлт, Монголын модны ирээдүйн зах зээл, түлшний модны эрэлт нийлүүлэлт г.м). Дараа нь зохих маркетингийн болон бизнес төлөвлөгөө боловсруулах шаардлагатай.
- Худалдан авалтын бодлого, гэрчилгээний талаарх БАХ-ний урьдчилан тооцоолсон байгаль орчны болон нийгмийн үр ашгийг сайжруулж “дүр эсгэсэн ногоон” үйл ажиллагаа үүсэх эрсдэлийг бууруулахын тулд “**ногоон” ба “дотоодын” гэдэг тодорхойлолтыг** маш тодорхой боловсруулж, бүтээгдэхүүний гарал үүслийг тодорхойлох, ногоон худалдан авалтын хяналт шалгалтын (жишээ нь магадлан шинжилгээний шаардлага, хяналт шалгалтын систем) заавар журмыг мөн ойлгомжтой боловсруулах хэрэгтэй. Мөн гэрчилгээ олгох системийг улсын төсвөөс худалдан авалтад ашиглах боломжийг судлах нь зүйтэй.

**REDD+ хэрэгжүүлэх үед авах шаардлагатай арга хэмжээ**

- **Ойн тогтвортой менежментийн урт хугацааны салбарын төлөвлөгөө** боловсруулахад санал болгож буй БАХ-ний үр ашгийг аль болох нэмэгдүүлэхийн тулд сийрүүлэх огтлолоос гарч болзошгүй нөлөөллийн талаарх ойлголтод үндэслэн (дээр санал болгосон үнэлгээг харна уу) ойн зарим хэсгийг хэвээр нь үлдээх хэрэгтэй. Жишээ нь, байгаль хамгааллын ач холбогдол өндөртэй болон нүүрстөрөгчийн шингээлт ихтэй ойг тодорхойлсны үндсэн дээр сийрүүлэх огтлолт эсвэл бусад оролцоонд хамрагдахгүй ойн хэсгүүдийг сонгох нь зүйтэй. Мөн Монголын нөхцөлд чухал гэж тооцох нэмэлт шалгуурыг бас харгалзах шаардлагатай юм. Салбарын аливаа урт хугацааны төлөвлөгөөний хяналт шалгалтын бүтцэд нийгэм эдийн засгийн үр ашиг, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадвар, экосистемийн үйлчилгээ ба биологийн олон янз байдлын нэн тэргүүний үзүүлэлтүүдийг хамруулах ёстой.
- **Ойн менежментийн төлөвлөгөө (ОМТ)** боловсруулж хэрэгжүүлэх явдлыг сайжруулах нь (салбарын урт хугацааны төлөвлөлтөөс гадна) санал болгож буй хэд хэдэн БАХ-ээг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай гэж үзсэн. Ойн нөхөрлөлүүдийн цөөхөн нь л ОМТ-тэй эсвэл хэрэгжилтэд нь хяналт тавьдаг ба олон нөхөрлөл ойн тогтвортой менежмент явуулах чадвар дутмаг. Ойн менежмент явуулдаг бүх ойн нөхөрлөлүүд болон ААН-үүд ойн менежментийн төлөвлөгөөтэй байх ёстой ба уг төлөвлөгөөнд дараах асуудлыг тусгах ёстой. Үүнд: ойн талбайг зохистой үнэлсний үндсэн дээр тогтвортой мод бэлтгэх хэмжээг тогтоох, ойн төлөв байдал, экосистемийн үйлчилгээ ба биологийн олон янз байдлын шалгуур үзүүлэлтүүдийг оруулах, мөн орон нутгийн түвшинд оролцогч талуудтай санал солилцсоныг тусгах зэрэг болно. Мөн үүний нэгэн адил ойн дагалт баялагтай холбоотой **БАХ-нүүдэд ч бас дагалт баялгийн тогтвортой ашиглалтын төлөвлөгөө,** квотын дагуу тогтвортой ашиглалтын хэмжээнд нийцүүлэн айл өрх, ойн нөхөрлөл ба ААН-ийн олборлох хэмжээг зааж өгөх мөн олборлох байршил болон олборлох аргуудыг тусгах ёстой.

- **Хуурай газрын ойн экосистемийн** үйл ажиллагаанд хэрэгжүүлж тогтвортой байдлыг нь хангахын тулд ойн нөхөрлөл, малчид болон орон нутгийн иргэдийн **оролцоог өргөжүүлэх** үүднээс нэмэлт хүчин чармайлт шаардагдаж магадгүй. Үүнд жишээ нь дараах ажил багтана: зорилтот газар нутагт шинэ нөхөрлөл байгуулах, нийгмийн бусад бүлгүүд буюу нөхөрлөлийн гишүүн бус иргэдийн хамрагдах боломжийг хэрхэн өргөжүүлж болохыг судлах, заган ойн менежмент ба нөхөн сэргээлтийн талаар сургалт явуулах, цагаан гоёо болон өвсөрхөг ургамал зэрэг бусад чухал зүйлүүдийг анхаарах, мөн хуурай газрын ойд зориулж сурталчилгаа, кампанит ажил явуулах. Хуурай газрын бүсэд хөнөөлт шавжтай тэмцэх үйл ажиллагааг тооцох ёстой, учир нь заган нөхөн сэргээлтийг дагаад хөнөөлт шавжийн тоо өсч магадгүй.
- Санал болгож буй хэд хэдэн үйл ажиллагаа **ус хамгаалалтай** холбоотой буюу үүнд нөлөөлөл үзүүлж болзошгүй. Тэдгээрийн эерэг үр нөлөөг дээшлүүлж эрсдэлүүдийг бууруулахаар дараах арга хэмжээг санал болгож байна: холбогдох газар нутагт ус хангамжийн шаардлагыг тооцон ойн нөхөн сэргээлтийн үйл ажиллагаанд усанд хэмнэлттэй технологи ашиглах, орон нутгийн иргэдийн ус цуглуулах арга, усны хэмнэлт, ус дахин ашиглах г.м. чадварыг дээшлүүлэх, БАХ-ний хяналт шалгалтын бүтцэд усны хэт хэрэглээний эрсдэлүүд болон экосистемүүдийн усны урсгал хангалттай байх хэрэгцээг тусгах, мөн булаг шанд хамгаалах ажиллагааг шаардлагатай үед усны эх үүсвэрийн эргэн тойронд мод суулгах ажилтай хослуулах.
- Ойн анги, ойн нөхөрлөлүүд, ААН-үүдийн оролцоо болон эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэхийн тулд тэдэнд **орчин үеийн тоног төхөөрөмж ба технологи нэвтрүүлэх** хэрэгцээтэй байгааг оролцогч талууд тодорхойлогдсон. Жишээ нь одоогийн байдлаар ойн нөхөрлөлүүдэд түймрээс сэргийлэх, тэмцэх тоног төхөөрөмж дутагдалтай байдаг. Боломжоотой газар нь техник технологийг хэрхэн шинэчилж болох асуудлыг холбогдох БАХ-дэд тусгах ёстой ба (хөнгөлөлттэй зээл, тоног төхөөрөмжийг шинэчлэх г.м. сонголтууд байж болно) технологи нь байгаль орчинд ээлтэй, болж өгвөл дотоодод үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн ашигласан, мөн Монголын нөхцөлд тохирсон байх ёстой гэдгийг тэмдэглэнэ
- Хэт ашиглалт болон бусад болзошгүй сөрөг нөлөөллийн эрсдэлийг бууруулж, үр ашгийг дээшлүүлэхийн тулд **хяналт тавих ажилд ашиглах** хангалттай нөөц, эх үүсвэртэй байх шаардлагатай. Орон нутгийн ойн ангиудад хяналт шалгалтад шаардлагатай төсөв, мэргэшсэн боловсон хүчин хангалтгүй байдаг. ИНБ-тай хамтарч мөн ААН-ийн техник хэрэгслийг ашиглах боломжийг судлах хэрэгтэй (жишээ нь зарим ИНБ-ууд байгаль орчны хяналт шалгалтын үүрэг гүйцэтгэж байна). Хяналт шалгалтын бүтцүүд мөн байгаль орчны болон нийгмийн нөлөөллийн үзүүлэлтүүдийг багтаах ёстой. Жишээ нь бичил зээл болон бусад амьжиргааны оролцоо, үүний дотор нийгмийн болон байгаль орчны үзүүлэлтүүдийн эсрэг оролцоонд нарийвчилсан хяналт тавих шаардлагатай.
- Төрийн байгууллагууд, ойн нөхөрлөлүүд болон орон нутгийн иргэд хоорондын **мэдээллийн урсгалыг** сайжруулж алслагдсан орон нутагт хүргэхийн тулд тохиромжтой сувгуудыг ашиглах шаардлагатай ба байгаль хамгааллын хууль журам ба түймрийн эрсдэлийн түвшин зэрэг сэдвийн болон REDD+-ийн хэрэгжилттэй холбоотой мэдээллийг тогтмол, ил тод хүргэх ёстой.
- **Илүү тогтвортой эрчим хүчний хэрэглээтэй** холбоотой эерэг үр нөлөөг дээшлүүлж түлшний модноос хамаарах хамаарал буюу түүний хэт олборлолттой холбоотой эрсдэлүүдийг бууруулахын тулд түлшний модны хэрэглээг зохицуулах БАХ-г нарны эрчим хүч, байгалийн хий, био түлш зэрэг эрчим хүчний бусад эх үүсвэрийн дэмжлэгтэй холбож өгч одоо байгаа засгийн газрын хөтөлбөрүүдэд дэмжлэг үзүүлэх шаардлагатай байна. Түүнээс гадна түлшний модны түгээлтэд анхаарал хандуулах хэрэгтэй (одоогийн байдлаар зарим газарт л түлшний модны зах зээл байна). Эмзэг айл өрхийн түлшний модны хангамжийг ААН-тэй эсвэл ойн нөхөрлөлүүдтэй түгээлтийн зориулалтаар гэрээ хийх замаар дэмжиж болох юм. Нэмж хэлэхэд эрчим хүчний хэрэглээ өөрчлөгдөх нь **хүлэмжийн хийн ялгаралтад** хэрхэн нөлөөлж болох талаар тодорхой ойлголт хэрэгтэй байна.
- Ойн тогтвортой менежмент болон ойн бүтээгдэхүүнийг боловсруулах (үүний дотор ойн дагалт баялаг) талаарх REDD+ БАХ-ний чадавхыг нэмэгдүүлэхийн тулд тэдгээр БАХ-нд **чадавх бэхжүүлэх мөн сургалт** явуулах асуудлыг тусгаж өгөх шаардлагатай ба тухайлбал ойн нөхөрлөл, ойн анги ба ААН-үүдэд хамаатай. Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүд (МСҮТ)-тэй хамтран сургалтын хөтөлбөрүүд хэрэгжүүлэх боломжийг хайх хэрэгтэй.

- **Тусгай хамгаалалттай газар нутагтай** холбоотой БАХ-ний үр ашгийг дээшлүүлэхийн тулд менежментийн ба чадавхыг хүчирхэгжүүлэх шаардлагатай. Үүнийг тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төсвийн санхүүжилтийг нэмэгдүүлэх мөн боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх замаар биелүүлж болно. Бусад саналууд: тусгай хамгаалалттай газрын захиргаа болон хяналт шалгалтад SMART програм хангамжийг өргөнөөр ашиглах, орон нутгийн засаг захиргаа болон тусгай хамгаалалттай газрын захиргааг уур амьсгалын өөрчлөлт ба амьжиргааны талаар сургалтад хамруулах.
- Ойн хамгаалал, менежментийг сайжруулахад зориулж **олгох урамшууллын системийг бэхжүүлэхэд чиглэсэн** БАХ хэд хэд байгаа**.** Эргүүл хийх, мэдээлэл өгөх (жишээ нь хууль бус мод бэлтгэлийг мэдээлэх) оролцоог үр ашигтай нэмэгдүүлэхийн тулд төлбөрийн хэмжээг нэмэгдүүлэх хэрэгтэй байж магадгүй ба гэхдээ мөнгөн бус хэлбэрээр (жишээ нь бензин, галын хор ба бусад техник хэрэгсэл г.м.) олгож болох юм. Эдгээр тохиолдолд мэдээллийг боловсруулах, урамшуулал олгохдоо нууцлалыг сахих ёстой. Санхүүжилтийг ногдуулсан торгууль, хураагдсан модны хэмжээтэй уялдуулахаас зайлсхийх ёстой (эрх баригчдад санхүүжилтийн эх үүсвэрийг хадгалж үлдээхийн тулд хууль бус мод бэлтгэлийг таслан зогсоохгүй байх сэдэл төрүүлэх магадлалтай).
- Олон нийтийн хяналтад байдаг **ойн нөхөн сэргээлтийн сан** байгуулах асуудлыг судлах хэрэгтэй ба тус сан нь ойн нөхөн сэргээлт, нөхөн сэргээсэн газар нутгийн хамгаалалт, арчилгааг сайжруулахад чиглэсэн урамшууллыг бүрдүүлж өгнө. Монгол улсад одоогийн байдлаар үүнтэй төстэй сан алга байна. Ойн нөхөн сэргээлт нэмэгдсэнээс учрах ачааллыг бууруулах өөр нэг сонголт бол **"буцаан худалдан авах"** тогтолцооны өгөөжийг нэмэгдүүлэх буюу мод тарьсан ААН-үүд болон иргэд таван жилийн дараа тарьсан модны ургалт, амьдралтын тооноос хамаарч нөхөн олговор авч болох арга юм. Ойн нөхөн сэргээлтийн оролцоог нэмэгдүүлэхийн тулд зүгээр л муу үр дүн үзүүлсэн тохиолдолд торгохоос өөр аргуудыг эрэлхийлэх хэрэгтэй.
- Хэд хэдэн БАХ-ээг хэрэгжүүлэхийн тулд нарийвчилсан **заавар, стандарт ба шалгуур** боловсруулах эсвэл сайжруулах шаардлагатай. Жишээ нь:
  - Зориудаар гал тавих г.м. түймрээс сэргийлэх арга хэмжээг хэрхэн зохистой гүйцэтгэх талаар техникийн заавар
  - Ойн тэргүүлэх бүтээгдэхүүнд зориулсан стандартууд ба чанарын хяналтын заавруud (Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамтай хамтран)
  - Ойн тогтвортой менежмент ба гэрчилгээ олгох заавар ба стандартууд, үүнд талбайн сонголт, оролцогч талуудын зөвлөгөөн, оролцоо, нийгмийн болон байгаль орчны шалгуур ба Магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн үүрэг хариуцлагыг тусгах
  - Ойн менежментийн төлөвлөгөөнүүд хоцрогдсон бөгөөд ойн талбайн нарийвчилсан шинжилгээ хийх шаардлага тусгах ёстой тул төлөвлөгөө боловсруулах заавры г шинэчлэх
  - Эмзэг бүлгүүдэд хүрэх явдлыг хангах, бага хэмжээний, орон нутгийн үйлдвэрлэлийг дэмжих, мөн экологид ээлтэй, нийгмийн хариуцлагатай бүтээгдэхүүн ба үйл ажиллагаа зэргийг дэмжиж амьжиргаа дээшлүүлэх, бичил зээл олгох үйл ажиллагааг төлөвлөж хүргэх заавар ба шалгуурууд
  - Эко аялал жуулчлалын чанд стандарт боловсруулж түүндээ байгаль орчны бохирдол, нийгмийн нөлөөлөл, биологийн олон янз байдал, үр ашиг хуваарилалт г.м. нийгмийн болон байгаль орчны асуудлуудыг тусгах
  - Нөлөөллийн хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгө оруулалтад зориулсан чанд, тодорхой нийгмийн болон байгаль орчны заавар боловсруулах, зээлдэгчдийг шаардлага хангаж буй эсэхэд үнэлгээ хийх бүтэц бий болгох.
- Үндэсний мод бэлтгэлийн стандартыг илүү сайн мөрдүүлэх ажлыг дэмжих шаардлагатай.
- Эдийн засгийн үр ашгийг дээшлүүлж иргэдийн амьжиргаанд учрах эрсдэлийг бууруулж газрын доройтлыг шийдвэрлэх, **мал сүргийн эрүүл мэндийг сайжруулах** арга хэмжээг эрчимжүүлэх, үүний дотор мал эмнэлгийн сайжруулсан стандартыг ашиглах, мөн малын бүтээгдэхүүний экспортын олон улсын стандартуудыг хангахын тулд REDD+-ийн үйл ажиллагаанд оролцсон **бэлчээр ашиглагчдын бүлгүүдийг урамшуулах**

боломжийг хайх, одоо байгаа төслүүд болон үйлчилгээтэй (жишээ нь Малын чанар үүлдэр угсааг сайжруулах хөтөлбөр г.м) уялдуулах бололцоог хайх хэрэгтэй.

- Одоогийн байдлаар санал болгож буй БАХ-ний үйл ажиллагааны төрлүүдэд тусгагдсан **орон нутгийн түвшний оролцоо** нь тодорхой хэдэн талуудаар (жишээ нь ойн нөхөрлөлүүд, орчны бүсийн зөвлөлүүд г.м.) хязгаарлагдаж байгаа бөгөөд сайжруулах боломж байна. Орон нутгийн түвшний оролцоог дээшлүүлэхийн тулд хамрагдахгүй хасагдах эрсдэлтэй нийгмийн бүлгүүд буюу эмэгтэйчүүд, залуучуудтай зөвлөлдөх хэрэгтэй ба шаардлагатай бол тэдгээрийн хамрагдах бололцоог нэмэгдүүлэхийн тулд зорилт, арга хэрэгсэл боловсруулах ёстой**. Газар ашиглалтын төлөвлөлтөд** ойн нөхөрлөл болон бэлчээрийн газар нутгийн нөхөрлөлийн оролцоог нэмэгдүүлэх ёстой ба тэдгээрийн санал санаачилгыг нэгтгэх механизм боловсруулах шаардлагатай байна. Жишээ нь малчид, нутгийн иргэдийг ойн менежментийн төлөвлөгөөнд хувь нэмэр оруулах бололцоогоор хангах ба ойн нөхөрлөлүүдийг бэлчээрийн газар нутгийн менежментийн төлөвлөгөө боловсруулахад хамруулах. Орчны бүсийн зөвлөлүүд нь Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хуулийн дагуу тавигдаж буй шаардлага юм. Харин тэдгээр зөвлөлийн бүтцийг тэлж шинэ тусгай хамгаалалттай газар нутагт байгуулах (мөн боломжтой бол орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагт зохистой бүтцийг байгуулах) хэрэгтэй байна.
- БАХ-нд хамрагдсан иргэдийн (мод боловсруулах эсвэл хөнөөлт шавжтай тэмцэх үйл ажиллагааны явцад) **эрүүл мэнд, аюулгүй байдлын** эрсдэлүүдийг шийдвэрлэхийн тулд шаардлага хангасан тоног төхөөрөмжөөр хангах ёстой ба эрүүл мэнд, аюулгүй байдлын дүрэм журмыг мөрдвөл зохино, тэдгээр дүрэм журам байхгүй тохиолдолд боловсруулах шаардлагатай.
- REDD+ БАХ-нүүд **мэдээлэл цуглуулах, ил тод байдлыг хангах** явдлыг сайжруулах бололцоо олгож орон нутгийн болон улсын түвшинд ойн засаглалыг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ. Жишээ нь ойн нөхөрлөлийн үйл ажиллагаа, хөнөөлт шавьжтай тэмцэх зэргийн хяналт шалгалтын протоколыг сайжруулж /ойн гэрчилгээний мэдээллийн сан бий болгох замаар г.м/ болно. Ойн менежментийг чиглүүлэх мөн REDD+ -ийн сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг хэрэгжүүлэх явдлыг мэдээлэл цуглуулах үйл явц болон мэдээллийн санд суулгаж өгөх ёстой ба мэдээллийг төрийн байгууллагууд ашиглах бололцоотой мөн оролцогч талуудтай хуваалцах боломжтой байна. Түүнээс гадна ойтой холбоотой гэмт хэрэг, зөрчлийн мэдээллийн санг байгуулах ёстой.
- **Усны нөөцийн нэгдсэн менежмент** (УННМ)-ийг сонгогдсон голын ай сав газруудад (одоогийн байдлаар ганцхан Сэлэнгэ мөрөн) хэрэгжүүлэх шаардлагатай. Усны хагалбарын менежментийн төлөвлөгөөнүүдийг нөхцөл байдлын бүрэн хэмжээний үнэлгээн дээр тулгуурлаж дараа нь газар ашиглалтын төлөвлөгөө болон тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөөтэй нэгтгэх ёстой. Экосистемийн үйлчилгээний үр ашгийг дээд хэмжээнд хүргэхийн тулд усны хагалбарын менежментийн төлөвлөгөөнүүд нь доройтсон экосистемийг нөхөн сэргээхэд голлон анхаарсны дээр тухай газар нутгийн ойн менежментийн төлөвлөгөөтэй уялдсан байх ёстой.

**Бусад асуудал**

- Өмнө тодорхойлсон үр ашгийг дээшлүүлж, эрсдэлүүдийг бууруулахын тулд санал болгож буй БАХ-нүүдийг **хооронд нь зохих ёсоор уял-дуулах** хэрэгтэй. Жишээ нь:
  - Түймрээс сэргийлэх болон түймэртэй тэмцэх арга хэмжээнүүдийг ойн нөхөрлөлд дэмжлэг үзүүлэх буюу тэдний түймрээс сэргийлэх чадавхыг нэмэгдүүлэх БАХ-тэй холбож өгөх шаардлагатай.
  - Эко аялал жуулчлалыг ойн нөхөн сэргээлтийн арга хэмжээг тусгай хамгаалалттай газар нутгийг хамарсан БАХ-тэй холбох нь зүйтэй. Одоогийн байдлаар жуулчлалын орлогоос ойн нөхөн сэргээлтэд оруулах хувь нэмэр байхгүй ба энэ байдлыг өөрчлөх гарц аргыг хайх хэрэгтэй. Жуулчлалын маршрутыг нөхөн сэргээгдэж байгаа газар нутгийг дайран өнгөрөхгүйгээр бодож төлөвлөж мөн бусад чухал байршилд (хүлэрт намаг) нөлөөлөл үзүүлэхээс зайлсхийх шаардлагатайг тооцох ёстой.

- Хууль бус мод бэлтгэлтэй тэмцэх БАХ-г амьжиргааг дэмжих арга хэмжээг холбож өгөх шаардлагатай ба орон нутгийн засаг захиргаа орлогын бусад эх үүсвэрийг (ХАА-ойн салбар, ойн дагалт баялгийн тогтвортой хэрэглээ, ХАА ба ойн салбарт түр ажлын байр г.м.) дэмжиж сурталчлах арга хэмжээ авах шаардлагатай.
- Экосистемийн үйлчилгээний төлбөрийн арга хэмжээг тусгай хамгаалалттай газар нутаг байгуулах, хамгаалалтыг нь сайжруулах, усны нөөцийн менежмент, ойн газар нутаг болон орчны бүсийн хамтарсан менежмент болон орон нутгийн амьжиргааны эх үүсвэрүүдийг төрөлжүүлэх арга хэмжээтэй холбох нь зүйтэй.
- Ойн нөхөн сэргээлтийг хамарсан БАХ-г хөнөөлт шавжтай тэмцэх мөн амьжиргаа дээшлүүлэх ба мал сүрэг, бэлчээрийн менежменттэй холбох хэрэгтэй.
- Гэрчилгээ олгох арга хэмжээг урт хугацааны, ойн тогтвортой менежментийн төлөвлөгөө боловсруулах асуудалтай холбох хэрэгтэй.

- Хэд хэдэн **чухал хууль эрх зүйн** асуудлыг тодорхойлсон ба эдгээрийг БХЖ-ын үнэлгээнд хамруулсан. Үүнд:
  - Бэлчээрийн менежментийн эрх зүйн орчин одоо болтол тодорхой бус хэвээр, ойн тухай болон газрын тухай хуулийн заалтууд зөрчилдөж байгаа нь олон тооны БАХ-г үр дүнтэй хэрэгжүүлэх, болон ойн нөхөн сэргээлтийн эерэг үр нөлөө, газрын доройтлын бууралт ба малчдын амьжиргаа сайжрах зэрэг ирээдүйд бий болох үр дүнд нөлөөлж болзошгүй.
  - Хуулиар заг мод хэрэглэхийг хориглосон боловч тэдгээр бүс нутагт түлээний мод түүх, мал бэлчээх явдал үргэлжилсээр байна. Хуурай газрын БАХ-үүд энэ асуудлыг хэрхэн зохицуулахыг тодорхой болгох шаардлагатай байна.
  - Төрийн албаны тухай хуульд мэргэшсэн боловсон хүчин шаардагдах бүх албан тушаалд мэргэжлийн ажилтан байх ёстой гэсэн заалт багтсан. Энэ хуулийн хэрэгжилтийг хангаж, мэргэжлийн боловсон хүчнийг тогтвортой ажиллах боломцоогоор хангах хэрэгтэй байна.

- Үр ашиг ба эрсдэлийн үнэлгээний явцад тодорхойлсон зарим үр ашиг, эрсдэлүүд нь ойн салбар дахь **тендер шалгаруулах болон гэрээ байгуулах** үйл ажиллагаатай холбоотой байв. Нийгэм-эдийн засгийн үр ашгийг дээшлүүлж, зөрчлийг бууруулахын тулд тендер шалгаруулах үйл явцад орон нутгийн компани, хоршоодод давуу тал олгох боломцоо бий эсэхийг судлах шаардлагатай. Жишээ нь зарим аймгууд хөнөөлт шавжтай тэмцэх үйл ажиллагаанд орон нутгийн иргэдийг оролцуулж ажлаар хангах шаардлага тавьж эхэлсэн байна. Мөн тендер шалгаруулах үйл явц нь нээлттэй, ил тод байж сонгох шалгуур нь ойлгомжтой байх ёстой. Мод тарих, хөнөөлт шавжтай тэмцэх тендерийн одоогийн хугацаа тохиромж муутай бөгөөд үр ашиггүй тул жилийн эхэн үе рүү шилжүүлэх хэрэгтэй.

- Оролцогч талууд **Байгаль хамгаалах сангийн** санхүүжилт хуваарилах үйл явцыг өөрчилж тэдгээрийг орон нутгийн төсвөөс салгахыг санал болгосон ба одоогийн байдлаар тэдгээр нөөцийг байгаль хамгааллын зориулалтаар бус орон нутгийн хэрэгцээнд зарцуулах явдал түгээмэл байна. Хуульд зааснаар ойн нөөц баялаг ашигласан төлбөрийн 85 хувийг ой хамгаалах ажилд зарцуулах ёстой. Оролцогч талууд мөн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхтэй холбоотой шийдвэрүүдэд байгалийн нөөц баялаг ашигласны төлбөрийн орлогыг зарцуулах талаар тусгадаг болгохыг шаардсан нэмэлт өөрчлөлтийг санал болгож байна.

- Оролцогч талуудын зарим санал **татвар хураамжтай** холбоотой ба үүнд дотоодын модны үйлдвэрлэлийг цаашид дэмжих, дотоодын үйлдвэрлэгчдэд таатай татварын бодлого мөрдөх, модны импортын татварыг нэмэх, экспортын татварыг бууруулах, мод боловсруулах салбарын ЖДҮ-т хөнгөлөлттэй зээл олгох зэрэг замаар улам дэмжих зэрэг багтана. Дотоодын модны үйлдвэрлэлийг дэмжих бодлогуудыг хэрэгжүүлснээр гарах хуримтлагдах үр нөлөөг ашиглалтын хэмжээний урт хугацааны нөлөөлөл болон тэдгээрийн нүүрстөрөгчийн болон нүүрстөрөгчийн бус үр ашиг ба эрсдлүүдэд үзүүлэх үр дагавар зэрэг үзүүлэлтийн дагуу тооцох ёстой.

# 5. Бодлого, хууль, журмын Үнэлгээ (БХЖ)

## 5.1 Удиртгал

СНСЗ-уудыг тусгах гэдгийг НҮБ-ын УАӨ-ийн суурь конвенцийн зүгээс тусгайлан тодорхойлоогүй. Хэдий тийм боловч, REDD+-ийн БАХ-нүүдтэй холбоотой байгаль орчин, нийгмийн нөлөөллүүдээс сэргийлэх зарчмуудыг бодлого, хууль, журмууд (БХЖ) болон институцийн зохион байгуулалтад *тусгаж байхаар* ерөнхийдөө санал нэгдсэн байдаг.

Харин дээрх БХЖ, холбогдох үйл ажиллагаануудыг бодит байдал дээр үр дүнтэй хэрэгжүүлж, тодорхой нааштай үр өгөөж гарсан тохиолдолд сая СНСЗ-ууд *хэрэгжсэн* гэж ерөнхийд нь ойлгодог. Аль нэг орны БХЖ-уудад үнэлгээ хийхдээ цаасан дээрх агуулга ба амьдрал дээрх хэрэгжилт аль алиныг үнэлэх ба зарчмуудтай холбоотой ямар БХЖ байна, тэдгээрийг аль байгууллага хэрэгжүүлэх эрхтэй ба чадамжтай, мөн холбогдох засаглалын зохицуулалт дахь ямар цоорхой, давхцал мөн зөрчилтэй байдал нь REDD+ явцын хэрэгжилтийн үед дээрх зарчмуудыг тусгаж, хэрэгжүүлэхэд саад болох вэ гэдгийг тогтооход дөхөм болдог.


СНСЗ-СНСМС-ийн ТАХ-ийн гишүүд уулзалтын үеэр. Улаанбаатар хот. Зургийг © UNEP-WCMC

Монгол Улсад дээрх зарчмуудыг тусгаж хэрэгжүүлэхтэй холбоотой БХЖ-д үнэлгээ хийх ажил 2017-2018 онуудад явагдсан. REDD+-ийн хэрэгжилтээс үүдэж болзошгүй эерэг үр нөлөө болон эрсдэлүүдийн үнэлгээ (4 хэсгийг харна уу) болон Канкуны зарчмуудын текст дээр үндэслэн холбогдох БХЖ-уудыг жагсааж, СНСЗ-уудыг дэмжсэн зүйл, заалтуудыг тодорхойлсон. Түүнээс гадна одоо байгаа БХЖ-ын тогтолцооны хийдлийг судалж тэдгээрийг арилгахад чиглэсэн зөвлөмжийг боловсруулсан. Тодорхойлсон БХЖ-ууд болон зөвлөмжүүдийг СНСЗ-СНСМС-ийн ТАХ[11]-ийн хэд хэдэн семинар дээр хэлэлцүүлсэн. БХЖ-ын үнэлгээний бүрэн хэмжээний тайланг англи, монгол хэлээр үзэж болно.

[11] Жишээ нь СНСЗ-СНСМС-ийн ТАХ-ийн 2018 оны 1 сарын хэлэлцүүлгийн үр дүнгийн жишээг хурлын тайлангаас үз: Англи, Монгол

## 5.2 БХЖ-ын үнэлгээний аргачлал ба үр дүн

Монгол улсын БХЖ үнэлгээ нь үндсэн гурван бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ:

i) Тус улсын одоо байгаа БХЖ-д REDD+-ийн үндсэн эрсдэлүүдийг хэрхэн “тусгасан” эсвэл гол үр ашгийг хэрхэн дэмжиж байгаа, мөн БХЖ-ын тогтолцоонд засч залруулах шаардлагатай хийдэл, сул тал байгаа эсэхэд үнэлгээ хийсэн

ii) Тус улсын одоо байгаа БХЖ-ууд амьдрал дээр хэрхэн хэрэгжиж байгаа, одоогийн байгууллагуудын хүчин чадал ямар байна, мөн Канкуны зарчмуудыг илүү сайн “хэрэгжүүлэх” үүднээс засаж залруулах шаардлагатай цоорхой, сул тал байгаа эсэхийг үнэлсэн

iii) СНСМС-ийн бүтцэд ашиглах боломжтой одоогийн мэдээллийн эх сурвалжууд, эрсдэлүүд ба холбогдох БХЖ-ыг тэмдэглэсэн.

БХЖ-ын үнэлгээний үр дүнг дараа нь хэд ажилд ашигласан. Нэгдүгээрт, холбогдох БХЖ, тэдгээрийн заалтууд ба  тусгаагүй орхигдсон хийдлийг СНСЗ-уудыг үндэсний онцлогт нийцүүлж тодорхойлох ажилд (6-р хэсгийг харна уу) ашигласан. СНСЗ-уудыг үндэсний онцлогт нийцүүлж тодорхойлох явцад тодорхой БХЖ-ын заалтуудыг  нарийвчлан судалж нэмэлт БХЖ-ын мэдээлэл оруулав. Уг үнэлгээний үр дүнг мөн СНСМС-д ашиглах мэдээллийн систем ба эх үүсвэрийн үнэлгээнд ашигласан. Эцэст нь БХЖ-ын үнэлгээнээс гарсан зөвлөмжийг 2018 онд хийсэн байгаль орчны салбар хууль тогтоомжийн үнэлгээнд нэгтгэхээр Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлсэн.

БХЖ-ын үнэлгээний дүнд Монгол улсад REDD+ явцын болзошгүй эрсдэлүүдийг бууруулж эерэг үр нөлөөг дээшлүүлэх бололцоотой тал бүрийг хамарсан БХЖ-ын систем байна гэдэг нь харагдсан. Гэхдээ зарим дутагдалтай тал байгаа бөгөөд үүнд: тус үнэлгээ нь эрх зүйн орчны зарим цоорхойг тодоор харуулж, зарим салбарт хуулиуд хоорондоо зөрчилтэй байгаа, мөн хэрэгжилтийн тал дээр сул талууд байгаа нь харагдсан. Канкуны зарчмуудын дагуу REDD+ явцыг хэрэгжүүлэхэд хамгийн тохиромжтой Монгол улсын зарим БХЖ-ыг үнэлгээu үндэслэн дурдвал:

- Төрөөс ойн талаар баримтлах бодлого (2015)
- Ойн тухай хууль (2012)
- Газрын тухай хууль (2002)
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль (2012)
- Авлигын эсрэг хууль (2006), Төрийн болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны тухай хууль (2005);
- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль (2011)
- Төсвийн ил тод байдлын тухай хууль (2014)
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль (2011)
- Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль (1994) Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль (1997)
- Ойн цэвэрлэгээ хөтөлбөр (2014)
- Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хууль (1995);
- Захиргааны ерөнхий хууль (2016), мөн Хөгжлийн бодлого хөтөлбөр боловсруулах нэгдсэн журам (2016)
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль (2012)
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль (2012)

Зөвлөмжүүдийг бүрэн хэмжээгээр БХЖ-ын үнэлгээний тайланд оруулсан бөгөөд хамгийн чухал анхаарах зүйлд дараах багтана.

- Ойн тухай хууль болон Газрын тухай хуульд ойн бүхий газар нутагт мал бэлчээх талаар зөрчилтэй заалтууд байгаа эхний хуульд хориглосон байхад нөгөө хуульд зөвшөөрсөн байна. Мал бэлчээх нь Монгол улсын ойн доройтолд хувь нэмэр оруулж байгаа боловч орон нутгийн иргэдийн амьжиргаанд туйлын чухал учраас энэхүү хуулийн тодорхой бус орчин нь зөрчилд хүргэж магадлалтай. Тиймээс уг үнэлгээ нь дээр дурдсан хуульд нэмэлт өөрчлөлт оруулж нөхөн сэргээгдэж байгаа болон зулзаган ойд мал бэлчээхийг хориглох талаар тодорхой тусгах зөвлөмж гаргасан.
- Цаашлаад тус үнэлгээ нь байгалийн нөхөн сэргээлтийг, үүний дотор мод тарих санхүүжилт ба нөхөн олговрыг дэмжих үүднээс төлөвлөлтийн арга хэмжээ авахад дэмжлэг үзүүлэх журам боловсруулах зөвлөмж гаргасан. “Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх журам”-д нэмэлт өөрчлөлт оруулж зулзаган модыг баталгаатай буцаан худалдан авах буюу мод тарих үйл ажиллагаа эрхэлдэг хувийн хэвшлийн оролцогчдоос тодорхой хугацаа өнгөрсний дараа худалдан авах талаар тусгах шаардлагатай. Түүнээс гадна байгалийн нөхөн сэргээлт явагдах боломжтой, тиймээс мод суулгахад илүү тохиромжтой газрыг тодорхойлоход дэмжлэг үзүүлэх үүднээс заавар боловсруулах хэрэгтэй.
- Оролцогч талуудын зөрчлөөс мөн ойн нөөц баялгийг орон нутгийн иргэд хэт их ашиглахаас сэргийлэхийн тулд Ойн тухайн хуулийн хүрээнд үр ашгийн хуваарилалт, зохицуулалт ба баялгийн ашиглалттай холбоотой маргааныг зохицуулах зориулалт бүхий шинэ журам эсвэл захирамж боловсруулах шаардлагатай. Ингэснээр ойн менежментийн төлөвлөгөөнд орон нутгийн оролцоог тусгасан, үр ашгийг зөвлөлдсөний үндсэн дээр хуваарилах тухай заалт багтаах асуудлыг баталгаажуулах юм.
- Ойн гэрчилгээ олгогдох газар нутгийг сонгох үйл явцын нээлттэй ил тод байдлыг хангахын тулд Ойн тухай хуулийн хүрээнд холбогдох журамд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай. Нэмэлт өөрчлөлт нь мөн гэрчилгээ горилж буй ААН-үүд орон нутгийн иргэдэд үр ашиг хүртээх талаар хуульчилж өгөх ёстой.
- Үүнтэй адилаар ойн салбарын тендерийн баримт бичигт хувийн ААН-ийг гүйцэтгэх гэж буй ажилдаа орон нутгийн иргэд болон ойн нөхөрлөлийн оролцоог хангахыг шаардах ёстой бөгөөд тэгээгүй тохиолдолд ирээдүйд орон нутгийн иргэдийн орлогын эх үүсвэр буурах эрсдэлтэй.
- Эко аялал жуулчлал орон нутгийн амьжиргаанд үр ашиг авчирч орон нутгийн төсвийн орлогыг нэмэгдүүлж болох боловч энэ талын эрх зүйн орчин хангалтгүй байна. Эко аялал жуулчлалыг дэмжих, менежмент явуулах журам, захирамж боловсруулах зөвлөмж гаргасан.
- Төрөөс Ойн цэвэрлэгээ хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд илүү их хөрөнгө хуваарилах шаардлагатай байна. Тус хөтөлбөр хэрэгжихгүй байгаагаас болж хэд хэдэн БАХ-ээг хэрэгжүүлэхэд хүндрэл учирч орон нутгийн иргэд ойн бүтээгдэхүүнээс үр ашиг хүртэх боломжид нөлөөлж байна. Түүний зэрэгцээ Монгол улсын Үндэсний REDD+ Хөтөлбөр нь унанги мод цэвэрлэх, ойн бүтээгдэхүүн олборлох ажлыг өргөжүүлснээс

нүүрстөрөгчийн болон нүүрстөрөгчийн бус үр ашигт учирч болзошгүй эрсдэлүүдийг санаж байх хэрэгтэй.

- Авлига ба менежментийн алдааны эрсдэлийг бууруулж БАХ-ний тогтвортой байдлыг сайжруулахын тулд орон нутгийн оршин суугчид болон иргэний нийгмийг ойн нөхөн сэргээлт, хөнөөлт шавжтай тэмцэх, эргүүл хийх г.м. ойн үйл ажиллагааны хяналт шалгалт ба мэдээлэх үйл явцад хамрагдах оролцоог нэмэгдүүлэхийг зөвлөсөн. Одоогийн байдлаар эргүүл ба хяналт шалгалтыг ойн ангиуд МХЕГ-тай хамтран гүйцэтгэж байна. Олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, жишээ нь орон нутгийн иргэд, ойн нөхөрлөлүүдэд эргүүл хийх эрх олгохын тулд Ойн тухай хуулийн хүрээнд журам эсвэл захирамж шаардагдаж магадгүй.
- Байгаль орчны сан ба байгалийн баялаг ашигласны төлбөрийн санхүүжилттэй холбоотой хэд хэдэн зөвлөмж гаргасан. Байгаль орчны санг хамарсан хууль зүйн заалтууд тус сангийн санхүүжилтийг орон нутгийн төсвүүдээс тусад нь байлгах явдлыг хангах ёстой.
- Экосистемийн үйлчилгээний төлбөр (ЭҮТ) гэдэг нь Монгол улсын хувьд шинэ ойлголт ба одоогийн байдлаар ЭҮТ-ийн бүтэц байхгүй байна. ЭҮТ-ийг тусгасан БАХ-ээг хэрэгжүүлэхэд ЭҮТ-тэй холбоотой хууль эсвэл журам боловсруулах шаардлага тулгарч магадгүй бөгөөд ингэхдээ зарим иргэдийн амьжиргаанд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлээс зайлсхийхийг эрмэлзэх ёстой.
- БХЖ-ын тогтолцоонд ойн салбарт болон илүү өргөн хүрээнд шийдвэр гаргахад оролцогч талуудыг хамруулах талаар тусгагдсан олон тооны заалт байна. Ойн менежментэд оролцогч талуудын оролцоог нэмэгдүүлэх талаар тусгагдсан одоогийн заалтуудыг тусгай журам эсвэл захирамж болгон нэгтгэх зөвлөмж гаргасан.

БХЖ-ын үнэлгээг үндэслэн дор дурдсан асуудлуудаар илүү өргөн хүрээний зөвлөмжийг мөн гаргасан. Удахгүй байгаль орчны мөн бусад хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах үеэр БХЖ-ын үнэлгээнээс гарсан хийдлийг авч үзнэ (жишээ нь БОАЖЯ-ын 2018 оны хуулийн үнэлгээ ба урамшуулал олгох зэрэг асуудлаар шинэ журам боловсруулсны дараагаар). Эдгээр БХЖ-ын шинэчлэлд хамрагдахгүй өөр хийдлүүдийг мөн илүү богино хугацаад шийдвэрлэх шаардлагатай бөгөөд энэ талаар Үндэсний REDD+ хөтөлбөр өөр арга хэмжээ төлөвлөх шаардлагатай (жишээ нь ойн хамгаалал болон мал бэлчээх үйл ажиллагааны зөрчлийг бууруулах сайн дурын эсвэл нэмэлт үйл ажиллагаа зохион байгуулж болно г.м).

# 6. Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг Монгол орны онцлогт нийцүүлж тодорхойлсон нь

## 6.1 Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг Монгол орны онцлогт нийцүүлж тодорхойлсон арга зам

Үндэсний нөхцөлд нийцүүлж тодорхойлох гэдэг нь REDD+-ийн сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмууд (СНСЗ)-ыг тухайн улсын хүрээнд ямар утгаар ойлгохыг тайлбарлахыг хэлэх бөгөөд үүнд нийтээр хүлээн зөвшөөрсөн нэр томьёог ашигладаг. Мөн тухайн улсын хувьд хамгийн нэн тэргүүнд шийдвэрлэх асуудлуудыг тодорхойлдог. Тухайлбал, REDD+-ийн

хэрэгжилтийн явцад бий болох байгаль орчин, нийгмийн үр ашгаас аль нь тухайн улсад хамгийн чухал бөгөөд одоо хэрэгжиж байгаа бодлого, хууль, журмуудтай (БХЖ) холбоотой болохыг тодорхойлж өгнө. Ихэнх оронд энэ үйл явцыг талуудын оролцоотой хэрэгжүүлдэг бөгөөд энэ талуудын оролцоог эхлүүлэх алхам болдог.

Монгол Улсад сөрөг нөлөөллөөс сэргийлэх Канкуны зарчмуудыг үндэсний онцлогт тохируулж тодорхойлох ажлыг сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчим ба сөрөг нөлөөллөөс сэргийлэх мэдээллийн системийн техникийн ажлын хэсгийн (СНСЗ-СНСМС-ийн ТАХ) удирдлага дор холбогдох талуудыг оролцуулан хэрэгжүүлсэн.

Үүнд:

- REDD+-ийн бусад холбогдох техникийн ажлын хэсгүүдийн гишүүд тухайлбал бодлого стратегийн техникийн ажлын хэсэг гэх мэт
- Гол төрийн байгууллагууд, агентлаг,судалгааны хүрээлэнгийн төлөөлөл
- Олон нийт иргэний нийгэм, хувийн хэвшлийн байгууллагуудын төлөөлөл
- Холбогдох олон улсын төсөл хөтөлбөрүүдийн төлөөлөл зэрэг оролцов.

2017 оны 9 сард зохион байгуулсан сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчим, сөрөг нөлөөллөөс сэргийлэх мэдээллийн системийн техникийн ажлын хэсгийн(СНСЗ-СНСМС-ийн ТАХ) хурлын[12] үеэр талууд сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг үндэсний онцлогт нийцүүлэн тодорхойлох ажлын зорилго,үндэслэлийг тодорхойлж холбогдох загвар ямар байвал зохихыг мөн сонгосон (нэмэлт тайлбар бүхий хүснэгт хэлбэрээр). Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг тодорхойлох ажлын зорилгыг дараах байдлаар эхний удаад тодорхойлсон байна: Бодлого , хууль журмыг үнэлэхэд дэмжлэг болгох, бодлого хууль журмууд болон тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавих ажлыг сайжруулах; бодлого арга хэмжээг үнэлэх, сонгох ажилд дэмжлэг үзүүлэх; донор болон санхүүжүүлэгчдийн зүгээс тавигдах шаардлагыг хангах, сөрөг нөлөөллөөс сэргийлэх мэдээллийн системийн загвар болон REDD+-ийн хяналт үнэлгээний загвар боловсруулахад ашиглах зэрэг болно.

Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг тодорхойлох ажилд ашиглах тусгай маягтыг боловсруулсан бөгөөд үүнийг тусгай баг өмнөх хэрэгжүүлсэн алхмууд болох үр ашиг эрсдэлийн үнэлгээ, бодлого хууль журмын үнэлгээний үр дүнд тулгуурлан бөглөсөн. Олон улсын туршлага, тэргүүн туршлага дээр тулгуурлан сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчим тус бүрд харгалзах ерөнхий багц элементүүдийн дагуу уг маягтыг бөглөв.

Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг тодорхойлох ажлыг эцэслэх үүднээс 2017 оны 12 сард олон талын оролцоотой семинарыг зохион байгуулж[13], зарчмуудыг тодорхойлсон хүснэгтийг уг семинарын үеэр талуудад танилцуулж монгол орны хувьд хамгийн нэн тэргүүний гэж үзсэн асуудлуудтай холбогдох саналуудыг авлаа. Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг үндэсний нөхцөлд тохируулж тодорхойлсон ажлыг 2018 оны 3 сард зохион байгуулсан Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчим ба мэдээллийн системийн ТАХ-ийн уулзалтын[14] үеэр улам тодорхой болголоо

Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг тодорхойлсон ажлын төсөл дээр үндэслээд холбогдох ажлын хэсэг тэдгээр тодорхойлолтыг Олон Улсын Санхүүгийн корпорацийн ашигладаг сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудтай[15] харьцуулж монгол орны

[12] Уулзалтын материал, тайлан: англи, монгол
[13] Уулзалтын материал, тайлан: англи, монгол
[14] Уулзалтын материал, тайлан: англи, монгол
[15]Олон улсын санхүүгийн корпорацийн (ОУСК) болон Уур амьсгалын ногоон сан (УАНС)-ийн зүгээс үйл ажиллагаандаа байгаль орчин, нийгмийн үр ашгийг хангах талаар баримталдаг стандарт.

нөхцөлд нийцүүлсэн энэхүү тодорхойлолтыг сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмын тодорхойлолттой хэр нийцэж байгааг ажиглаж үзлээ. Ингэж харьцуулахын учир нь Монгол улсад. уур амьсгалын өөрчлөлт болон ойн салбарт хэрэгжүүлэх санаачилгуудыг санхүүжүүлэх хандивлагч хэд хэдэн холбогдох байгууллагуудын баримталдаг сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудтай бидний боловсруулсан зарчим хэр нийцэж байгааг тодруулах зорилготой юм. Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмыг тодорхойлсон сүүлийн баримт бичгийг сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчим болон мэдээллийн системийн ажлын хэсгүүд болон бусад холбогдох талуудад танилцуулж, сүүлийн удаа санал авлаа.

### 6.2 Монгол Улсад хэрэгжүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг тодорхойлсон үр дүн

Монгол улсад хэрэгжүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг үндэсний онцлогт тохируулж тодорхойлох ажлыг 2018 онд эцэслэв. Ингэж тодорхойлохдоо сөрөг нөлөөллөөс сэргийлэх Канкуны 7 зарчмуудад тулгуурлаж, тэдгээр зарчим тус бүрийн дагуу Монгол улсад тохирох зарчмуудыг сонгон авч доторх агуулгууд болох бүрэлдэхүүн элементүүдийг нь тодорхойлсон. Нийт 36 элементийг тодорхойлсон байна. Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг үндэсний онцлогт нийцүүлж тодорхойлсон ажлыг Хавсралт 1-т үзүүлэв. Энэхүү зарчмуудыг тодорхойлох ажлын бүрэн тайланг, үүнд суурь мэдээлэл болон сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг Олон улсын санхүүгийн корпорацийн үйл ажиллагааны стандартуудтай харьцуулсан харьцуулалтын мэдээллийг www.reddplus.mn хуудсанд бүрэн эхээр нь байршуулсан. Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг тодорхойлох ажлын баримт бичиг нь “цаашид өөрчлөгдөж” болох бөгөөд REDD+-ийн үйл ажиллагааг Монгол Улсад хэрэгжүүлэх явцад энэ тодорхойлолтуудад зохих өөрчлөлтийг оруулж болох бөгөөд мөн бодлого, хууль, журмыг шинэчлэх, санхүүжүүлэгч байгууллагуудаас тавигдах шаардлагуудыг биелүүлэх зэрэгтэй холбогдуулан энэхүү баримт бичгийг мөн өөрчилж болох юм.

## 7. REDD+-ийг Монголд хэрэгжүүлэх явцад ашиглах ГБМ (гомдол барагдуулах механизм)

### 7.1 Танилцуулга

Ойн нүүрстөрөгчийг хадгалах хамтарсан санаачилга болон UN-REDD хөтөлбөрийн хамтарсан гомдол барагдуулах механизмын (ГБМ) удирдамж бичигт[16] гомдол барагдуулах механизмуудыг тодорхойлохдоо эдгээр нь тухайн улсын төрийн байгууллагуудаас (бүсийн болон орон нутгийн байгууллагууд) хэрэгжүүлж байгаа бодлого хөтөлбөр болон үйл ажиллагааны хүрээнд холбогдох талуудад гарч байгаа өөрчлөлттэй холбоотой санал гомдлыг хүлээж авах, шийдвэрлэх механизм юм гэж тодорхойлсон байна. Эдгээр систем болон журмаар дамжуулж талуудаас ирүүлж байгаа өгсөн саналыг “гомдол, санал, өөр холбогдох нэр томьёогоор нэрлэдэг”.

Монгол Улсын өнөөгийн хууль тогтоомжийн хүрээнд “хохирол” гэдэг үгийг хэрэглэдэггүй бөгөөд харин үүний оронд “өргөдөл, гомдол” гэдэг үгийг ашигладаг ажээ. Иргэдээс төрийн байгууллага болон албан хаагчдад ирүүлсэн санал гомдлыг хүлээн авч

[16] Ойн нүүрстөрөгчийг хадгалах хамтарсан санаачилга болон UN-REDD хөтөлбөрөөс хамтран гомдол барагдуулах механизмын (ГБМ)-ын талаар REDD+-ийг хэрэгжүүлж байгаа орнуудад зориулж боловсруулсан удирдамж бичигт: Гомдол барагдуулах механизмыг байгуулж бэхжүүлэх нь, 2015 оны 6 сар.

шийдвэрлэх тухай хуульд (1995 “Өргөдөл” гэж улс орон, нийгэмд хамаатай асуудлаар төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан хүсэлт, санал, мэдэгдэл юм, “гомдол" гэж төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаагаар иргэдийн хуулиар хамгаалагдсан эрх, эрх чөлөө, ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзэж сэргээлгэхээр гаргасан хүсэлтийг хэлнэ гэж заажээ. Хууль эрхзүйн хүрээнд тайлбарласан энэ тодорхойлолтод тулгуурлан цаашид REDD+-ийн хүрээнд үүсч болох гомдол, саналыг барагдуулах механизмуудын талаар хэлэлцэнэ.

## 7.2 REDD+-тэй холбоотой үүсэж болох гомдол

REDD+-ийн хүрээнд Монгол улсад хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа бодлого, арга хэмжээнүүдийн эрсдэл, үр ашгийг үнэлэх явцад REDD+-тэй холбоотой гарч болох санал, гомдлуудыг таамаглаж 7 бүлэгт хуваасан. Эдгээр нь хууль журмаар шийдэгдэх, тусгай шинж чанартай санал гомдол байсан. Энэ гомдлууд нь ойн нөхөрлөл, нутгийн иргэд, малчид болон ажилтнуудад нөлөөлж болохоос гадна холбогдох талууд болон төрийн байгууллага болон бусад талуудын хооронд үүсч болох зөрчлийг тусгасан байна. Дээрх 7 ангилалд хуваасан санал гомдлын жишээг доорх хүснэгтэд үзүүлэв.

*Хүснэгт 3. Монгол Улсад REDD+-ийг хэрэгжүүлэхтэй холбоотой гарч болох маргаан, гомдлууд*

| **Ангилал** | **Үр ашиг, эрсдэлийн үнэлгээний үеэр тодорхойлсон гомдол, зөрчил үүсэх шалтгааныг жишээгээр харуулсан нь :** |
|---|---|
| **Байгалийн нөөц ашиглах, эзэмших.** | Ойг ашиглах , ойгоос мод бэлтгэхтэй холбоотойгоор аж ахуй нэгж болон нөхөрлөлүүдийн хооронд зөрчил үүсч болно.(Аж ахуй нэгжүүд нь илүү чанартай модыг бэлтгэж авдаг бол ойн нөхөрлөлүүд нь зөвхөн унанги модыг ашиглах эрхтэй байдаг) |
| | Ойг нөхөн сэргээхэд зориулж тусгаарласан газрыг ашиглахтай холбоотойгоор малчдын зүгээс зөрчил гомдол гаргаж болзошгүй. |
| | REDD+-ийн бодлого, арга хэмжээг хэрэгжүүлэх явцад усны нөөц ашиглагчдын дунд ус ашиглахтай холбоотой маргаан, зөрчил үүсч болзошгүй. |
| | Нутгийн иргэд болон орон нутгийн байгаль хамгаалагчдын дунд зөрчил үүсч болно. Ойн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой. |
| | Ойн сангаас ойн нөөц баялгийг ашиглахтай холбоотойгоор тусгай хамгаалалттай газар нутгийн захиргаа, нутгийн иргэд, ойн нөхөрлөлүүдийн хооронд зөрчил маргаан үүсч болно(Түлшний мод болон бусад ойн дагалдах баялаг гэх мэт) |
| | Тусгай хамгаалалттай газар нутгийг тэлэх бэлчээрийн менежменттэй холбоотой бодлого арга хэмжээг хэрэгжүүлснээр олон нийтийн зориулалтаар ашиглах газар багасаж (мал бэлчих гэх мэт ) бэлчээр ашиглах боломж хязгаарлагдсанаар малчдад хүндрэл учирна. |
| | Усны нөөцийг хамгаалах болсноор газар ашиглах боломж хязгаарлагдаж усны нөөцийн хомсдол үүсэж улмаар малчдад хүндрэл учирна |
| | Ойг нөхөн сэргээж, агро ойн аж ахуйг ашиглах явдал нэмэгдсэнээр бэлчээрийн зориулалтаар ашиглах газрын хэмжээ багасч, газартай холбоотой маргаан зөрчил үүснэ. |
| **Амьжиргаа** | Ажилчид болон мод боловсруулах үйлдвэрүүдийн удирдлагуудын дунд цалин хөлс бага өгч байгаатай холбоотойгоор маргаан зөрчил үүснэ. |

| | |
|---|---|
| | Газар ашиглах,эзэмших боломж өөрчлөгдсөнөөр (хамгаалалтыг нэмэгдүүлэх, ойг нөхөн сэргээх, бэлчээрийн газрыг багасгах, албадан нүүлгэх) зэргээс шилжилт хөдөлгөөн нэмэгдэж амьжиргааны эх үүсвэр, боломж буурна. |
| | Ой хамгаалахад чиглэсэн бодлого арга хэмжээ нь зарим иргэдийн амьжиргаанд сөргөөр нөлөөлнө. Ан агнах, унанги мод бэлтгэх зорилгоор зориуд гал түймэр тавьдаг иргэд, ойн дагалдах баялаг ашигладаг, хууль бус мод бэлтгэл модны худалдаа эрхэлдэг, усны нөөц ашигладаг иргэдэд гэх мэт |
| | Татварын шинэ ачаалал бий болно (экосистемийн үйлчилгээний төлбөр) гэх мэт |
| | Амьжиргааны хэлбэр өөрчлөгдсөнөөр нутгийн иргэдийн амьжиргаа доройтно. Жишээлбэл агро ойн аж ахуй өмнө нь эрхэлж байсан мал аж ахуйгаас ашиг багатай байх гэх мэт . |
| | Жендерийн тэгш байдалтай холбоотой эрсдэл үүсч болзошгүй. Жишээ нь эрэгтэйчүүдэд зориулсан ажлын байр, ажил эрхлэх байр бий болж жендерийн харьцаа алдагдана. |
| **Ажлын байрны эрүүл ахуй, аюулгүй байдал** | Мод бэлтгэлийн кемпүүдийн орчинд нийгмийн асуудлууд үүсэх эрсдэлтэй. |
| | Хортон шавжтай тэмцэх, мод боловсруулах үйл ажиллагаа явуулж буй хүмүүсийн дунд эрүүл мэнд, аюулгүй байдалтай холбоотой эрсдэл үүснэ (харшил, ууланд авирч явах замд осол гарах гэх мэт). |
| **Уламжлал соёл зан заншил** | Уламжлал соёл зан заншил. REDD+-ийн бодлого, арга хэмжээнүүд нь уламжлалт амьдралын хэв маягт дарамт учруулж болзошгүй бөгөөд тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ тэлж томрох нь нутгийн иргэдийн уламжлалт амьдралын хэв маягийг зохицуулахтай зөрчилдөнө. Мал аж ахуйгаас шинэ амьжиргааны эх үүсвэрт шилжсэнээр уламжлалт нүүдлийн соёл алдагдаж болзошгүй. |
| **Үр ашиг хуваарилах** | Нөхөрлөлийн гишүүн бус нутгийн иргэд нь ойн нөөцөөс тэгш үр ашиг хүртэж чадахгүй байж болох магадлалтай бөгөөд аж ахуйн байгууллагуудад голлон анхаарсан бодлого, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд нөхөрлөл, нутгийн иргэд хангалттай оролцож чадахгүй байх эрсдэл бий. |
| | Урамшууллыг тэгш бус хуваарилах эрсдэл үүсч болно. Байгалийн нөөц ашиглалтын төлбөрөөс олох орлогыг хязгаарлагдмал тооны бүлэг буюу эрх мэдэлтнүүд хүртэж болзошгүй (нутгийн эрх барих байгууллага). |
| | Орон нутгийн зарим иргэд, өрхүүд буюу олон тооны малтай, бизнес эхлүүлэх хөрөнгө сайтай иргэд нь бодлого, арга хэмжээний үр дүнгээс илүү хүртэж болзошгүй. |
| **Мэдээлэл** | Мэдээллийг хүртээмжтэй, ойлгомжтой тарааж, түгээж чадахгүй байсны улмаас зорилтот бүлэгтээ мэдээллийг хүргэж чадахгүйд хүрнэ. Мэдээллийг хүртээмжтэй тараахгүй байснаас зорилтот бүлэг мэдээлэл авч чадахгүй байх эрсдэлтэй. (алслагдсан бүсийн) |
| **Ил тод засаглал** | Орлого цуглуулах, байгаль хамгаалах үйл ажиллагаанд төсөв хуваарилах явдал нэмэгдсэнээр иргэний нийгмийн байгууллага болон орон нутгийн захиргааны дунд орлого цуглуулах, байгаль хамгаалах үйл ажиллагаанд зориулсан санхүүжилт хуваарилахтай холбоотой зөрчил үүсч болзошгүй. |
| | Тендер болон гэрээт байгууллага сонгох үйл явцад авлига үүсэх эрсдэлтэй. |

## 7.3 Монгол Улсад мөрдөж байгаа одоогийн гомдол барагдуулах механизмууд

REDD+-ийн хүрээнд гарч болох гомдол, хохирлыг барагдуулах үндэс нь иргэдээс төрийн байгууллага болон албан тушаалтанд ирүүлсэн гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасан гомдол барагдуулах механизмуудтай холбоотой заалтууд дээр суурилах нь зүйтэй (1995 он). Мөн Монгол Улсын "Хүний эрхийн үндэсний комиссын тухай хууль" (2000 он), "Захиргааны ерөнхий хууль" (2015 он ) зэрэг багтана. Дээрх хуулиудад заасан гомдол барагдуулах механизмтай холбоотой заалтуудыг доор товч тайлбарлав.

Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд ирсэн гомдлыг шийдвэрлэх тухай хууль (1995 он): Энэ хуульд иргэдийн зүгээс санал, гомдол гаргах эрх болон төрийн байгууллагууд, албан тушаалтан тэдгээр гомдол, саналыг нь хүлээн авч шийдвэрлэх алхмуудын талаар хуульчилж өгсөн. Энэ хуульд заасны дагуу гомдол гаргагч нь дангаар болон хамтаараа санал гомдлоо бичгээр эсвэл амаар гаргаж болно. Гомдол, саналаа гардуулсан байгууллага болон албан тушаалтнаас холбогдох хариуг хүлээж авах эрхтэй. Өргөдөл гомдлоо буцааж татах хэрэв хангалттай хариу аваагүй гэж үзвэл өргөдөл, гомдлоо дээд шатны албан тушаалтанд гаргах эрхтэй. Төрийн байгууллага болон албан тушаалтнууд нь нөгөө талаас эдгээр өргөдөл, гомдлыг хүлээн авч бүртгэх үүрэгтэй бөгөөд тэдгээрийг хянан нягталж, цаашид дүн шинжилгээ хийх буюу өөр бусад байгууллага руу шилжүүлнэ. Мөн тухайн нөхцөл байдлаас хамаараад хэргийг хэрэгсэхгүй байх эсвэл түдгэлзүүлж болох бөгөөд эсвэл өргөдөл гомдлыг шийдвэрлэж хариу өгнө. Өргөдөл гомдол тус бүрийг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор шийдвэрлэх бөгөөд ингэхдээ энэ хугацааг 60 хүртэлх хоногоор сунгаж болно.

Монгол улсын хүний эрхийн комиссын тухай хууль (2000 он): Комисс нь Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөөний тухай заалтын хэрэгжилтэд хяналт тавьж, хүний эрхийг сахин хамгаалах, хөхүүлэн дэмжих байгууллага юм. Иргэд нь дангаараа болон хамтаараа Монгол улсын хүний эрхийн комиссын хамаарах чиг үүргийн хүрээнд гомдлоо өргөн мэдүүлж болох бөгөөд иргэдээс ирүүлсэн гомдлыг гомдол хяналт шалгалтын хэлтэс хүлээн авна. Эдгээр гомдлыг шийдвэрлэх журмыг тодорхой зааж өгч, олон нийтэд танилцуулсан ажээ. Гомдол гаргагч өөрийн биеэр болон утсаар, цахим хэлбэрээр гомдлоо гаргаж болно. Хэдий тийм боловч эрх нь зөрчигдсөн өдрөөс хойш 1 жилийн дотор гомдол гаргах эрхтэй. Монгол Улсын хүний эрхийн комиссар нь гомдлыг хүлээн авч шалгаж үзээд комиссын шаардлагад нийцээгүй гомдлыг хүлээн авахгүй буцааж болно. Иргэний болон эрүүгийн хуульд хамаарах гомдол маргааныг холбогдох эрх бүхий байгууллага буюу албан тушаалтанд шилжүүлж болно. Гомдол гаргагчид зөрчигдсөн эрхээ сэргээхтэй холбоотой хүлээх үүрэг, эрхийг нь тайлбарлаж өгнө. Монгол улсын хүний эрхийн комисс гомдол санал хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хариу өгөх бөгөөд тус комиссын даргын зөвшөөрлөөр уг гомдлыг шийдвэрлэхэд нэмэлт судалгаа, шинжилгээ шаардлагатай гэж үзвэл 30 хүртэлх хоногоор сунгаж болно. Гомдол саналыг хэрхэн шийдвэрлэх талаар шийдвэр гаргах үүднээс комиссар хэд хэдэн хувилбарыг дурдаж болно: Шүүхэд хандах, холбогдох эрх бүхий албан тушаалтанд хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн гэж үзсэн албан хаагчдад зохих шийтгэл, захиргааны хариуцлага ногдуулах талаар холбогдох эрх бүхий байгууллага болон албан тушаалтанд хандаж болно. Хүний эрх, эрх чөлөөг зөрчиж байгаа үйл ажиллагаагаа зогсоох холбогдох байгууллага, албан тушаалтнаас шаардах мөн эдгээр хүний эрх, эрх чөлөөг зөрчих нөхцөлийг үүсгэж байгаа байгууллагуудад шаардлага тавина. Талуудыг эвлэрүүлэн зуучлах, гомдол нь хангалттай үндэслэлтэй бус гэж үзсэн тохиолдолд гомдлыг гомдол гаргасан этгээдэд эргүүлж өгч болно. 2014 онд Монгол улсын хүний эрхийн үндэсний комиссын Улаанбаатар дахь төвийн хүний нөөц нь бэхжиж, 21 аймагт томилж ажиллуулсан байна хүний эрхийг хариуцсан 21 ажилтныг томилон ажиллуулсан .

Монгол улсын хүний эрхийн үндэсний комисс нь хүний эрх болон эрх чөлөөний талаарх чиг хандлага тухайн жилд хүлээж авсан өргөдөл гомдлын шалтгааны талаар дүн шинжилгээ хийсэн жилийн тайланг хэвлүүлдэг.

Захиргааны ерөнхий хууль (2015 он): Энэ хууль нь иргэд захиргааны байгууллагуудын хооронд үүсэх хууль эрх зүйн харилцааг тодорхой, нийцтэй, зохистой харьцааг хангах үүрэгтэй. Хуулийн 4-р хэсгийн 92-99-р зүйлд гомдлыг шийдвэрлэх журмын талаар заасан байдаг. Захиргааны актад гаргасан гомдлыг захиргааны байгууллага бүртгэн авч, захиргааны актын талаар мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг шийдвэрлэнэ. Уг гомдлыг 30 хонгийн дотор шийдвэрлэж гомдол гаргагчид мэдэгдэх бөгөөд шаардлагатай гэж үзвэл хугацааг 30 өдрөөр сунгаж болно. Гомдол авснаас хойш захиргааны этгээд үүнийг холбогдох хууль эрх зүйн заалттай нийцсэн эсэхийг нь судалж, хууль эрх зүйн заалт болон зорилготой нийцэж байгаа эсэхийг нь шалгаж, шийдвэрлэхээсээ өмнө холбогдох хувилбаруудыг авч үзсэн эсэхийг тодорхойлно. Захиргааны этгээд нь гомдлыг бусад этгээдэд дамжуулахыг ёсгүй. Үүссэн хохирлыг барагдуулах арга хэмжээ авах шаардлагатай бол энэ хариуцлагыг төр хүлээнэ.

## 7.4 Зөвлөмж

"REDD+"-н хүрээнд үүсэж болох гомдлыг шийдвэрлэх механизм нь дээр дурдсан гомдол барагдуулах механизмын талаар заалтыг агуулсан гурван эрх зүйн баримт бичиг дээр суурилах нь зүйтэй бөгөөд ингэснээр "REDD+"-г хэрэгжүүлэх явцад үүсэж болох хохирол, гомдлыг шийдвэрлэж болох юм. Хэдий тийм боловч хэрэгжүүлэхээсээ өмнө эдгээр гомдол барагдуулах механизмууд нь доорх хүснэгт 17-д[17] тайлбарласан гол зарчмуудыг хэрэгжүүлэхтэй нийцэж байгаа эсэх талаар нэмэлт үнэлгээ хийх нь зүйтэй. Гомдол барагдуулах албан бус механизмуудын талаар үнэлгээ хийж албан ба албан бус механизмууд нь хэрхэн нэгийгээ нөхөж болох талаар ойлгох мөн зөвлөгөө өгч болох юм.

*Хүснэгт 4: ГБМ-ийн гол зарчмууд*

| Зарчим | Авч үзэх асуудал |
|---|---|
| Зохих ёсны бие даасан байдал | ГБМ нь сонирхогч талуудын нөлөөнд автахгүй бие даасан хараат бус шинжтэй байж чадах уу?<br>ГБМ –ыг нийтээр бие даасан, хараат бус гэж хүлээн зөвшөөрч байна уу? |
| Хүртээмж | ГБМ нь бүх талд, газар зүйн алслагдсан байршил, хэл, боловсрол, орлогын түвшнээс нь үл хамааран хүртээмжтэй байж чадах?<br>Гомдол гаргах, арга хэмжээ авах журам нь төслийн үр ашиг хүртэгчдэд хялбархан ойлгогдохоор байна уу?<br>Нэргүй гомдол гаргаж болох уу?<br>Холбоо барих хэд хэдэн хувилбартай юу?<br>ГБМ-ыг төслийн үйл ажиллагааны нөлөөнд өртөж болзошгүй талуудад зохих ёсоор сурталчлан таниулдаг уу? |
| Үнэн зөв, тодорхой байх | ГБМ нь бүх гомдол гаргагчийн хэрэгцээнд нийцэж чадах уу?<br>ГБМ-ийн үйл явцын үе шат бүр тодорхой ойлгомжтой хугацаа заасан, шийдвэрлэж чадах (эсвэл чадахгүй байх) эсэх нь тодорхой байна уу? |

[17] Ойн нүүрстөрөгчийг хадгалах хамтарсан санаачилга болон UN-REDD хөтөлбөрөөс хамтран гомдол барагдуулах механизмын (ГБМ)-ын талаар REDD+-ийг хэрэгжүүлж байгаа орнуудад зориулж боловсруулсан удирдамж бичигт: Гомдол барагдуулах механизмыг байгуулж бэхжүүлэх нь, 2015 оны 6 сар.

| | |
|---|---|
| Шударга | Гомдолтой холбоотой мэдээллийг нууцалж, үнэн зөв үнэлж, ил тод шийдвэрлэж чадах уу? |
| Эрх тэгш | ГБМ-ийн үр дүн нь холбогдох үндэсний болон ОУ-ын стандартад нийцэж байна уу?<br>Өөр бусад гомдол барагдуулах механизмыг ашиглах боломжийг хязгаарлаж байна уу? |
| Ил тод | ГБМ-ын журам болон үр дүн нь олон нийтийн сонирхол, саналд нийцсэн ил тод байж чадах уу? |
| Чадавхтай | ГБМ-ыг ажиллуулж чадах зүтгэлтэй, зохих сургалтад хамрагдсан ажилтнууд бий юу?<br>Сургалтад хамруулах боломж байгаа эсэх мөн ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг системтэй үнэлдэг эсэх? |

Энэхүү үнэлгээнд ГБМ-ын одоо хэрэгжиж байгаа журам, алхмуудын талаар дэлгэрэнгүй оруулж[18] тэдгээр нь олон улсын стандартад хэрхэн нийцэж байгааг тайлбарлана. (Хүснэгт 5).

*Хүснэгт 5:* ГБМ-ыг олон улсын стандартын дагуу үнэлэх нь

| **Процесс** | **Авч үзэх асуултууд** |
|---|---|
| Хүлээн авах | Гомдол хүлээн авах олон суваг байдаг уу? |
| Ангилах, боловсруулах | Гомдол хүлээн авах олон суваг байдаг уу? |
| Мэдэгдэл өгөх, гомдлын дагуу ажиллах | Гомдлыг хүлээж авсан талаар бичгээр хариу өгдөг үү?<br>Энэ хариу бичигт ГБМ-ын үйл явц, холбоо барих мэдээлэл, гомдлыг барагдуулах хэр хугацаа орох талаар бичдэг үү?<br>Олон нийтэд нээлттэй, тодорхой цагийн хуваарь байдаг уу? |
| Баталгаажуулах, судалгаа хийх, арга хэмжээ хэрэгжүүлэх | Гомдол санал бүрийг тодорхой заасан стандартын дагуу шүүж байна уу?<br>Хэргийг судалж байгаа ажилтан нь төвийг сахисан байж чадаж байгаа эсэх, эсвэл үр дүнгээс ашиг хүртэх сонирхолтой байна уу?<br>Гомдлын дагуу тодорхой арга хэмжээ авсан уу? |
| Хяналт, үнэлгээ | Гомдлыг араас анхаарал тавих, гомдол шийдэх явцыг үнэлэх систем байдаг уу?<br>Гомдлыг хянах, шийдэх ажлыг үнэлэх шалгуур байдаг уу?<br>Мэдээлэл цуглуулж байгаа бол, цаашид ийм төстэй гомдол гарах явдлыг багасгах үүднээс бодлого боловсруулах, өөрчлөлт хийхэд тэр мэдээллийг ашигладаг уу?<br>Цуглуулсан мэдээллийг тодорхой ангиллаар, тухайлбал газарзүйн байрлал, салбар, жендерээр гэх мэт харуулдаг уу? |
| Санал өгөх | Энэ механизм хэр найдвартай байгаа талаар хэрэглэгчдээс санал авах систем байдаг уу?<br>Хэрэглэгчдээс авсан саналыг олон нийтэд танилцуулдаг уу?<br>Давж заалдах эрх байдаг уу? Байдаг бол ГБМ-ын хэрэглэгчдэд энэ эрхийн талаар мэдээлэл өгдөг үү? |
| Анализ хийх | ГБМ-ын үр дүнтэй байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх систем байдаг уу?<br>Цагийн хуваарь байдаг уу? |

[18] Ойн нүүрстөрөгчийг хадгалах хамтарсан санаачилга болон UN-REDD хөтөлбөрөөс хамтран гомдол барагдуулах механизмын (ГБМ)-ын талаар REDD+-ийг хэрэгжүүлж байгаа орнуудад зориулж боловсруулсан удирдамж бичигт: Гомдол барагдуулах механизмыг байгуулж бэхжүүлэх нь, 2015 оны 6 сар.

Дээрх үнэлгээнээс гарсан үр дүнг ашиглан одоогийн байгаа механизмуудын хувьд сайжруулбал зохих хэсгүүд хаана байгааг тодорхойлж, холбогдох арга хэмжээг авна. Газар дээр нь ажиллах гомдол барагдуулах механизмын багийг томилох шаардлагатай гэж үзвэл REDD+-ийг хэрэгжүүлэхээс өмнө томилж ажиллуулна. Ийм баг бүрдүүлэх бол дараах зүйлсийг тодорхой болгох ёстой.

- Гомдол барагдуулах механизмын чиг үүрэг
- Гомдол барагдуулах механизмын гүйцэтгэх үүрэг
- Гомдол барагдуулах механизмын бүрэлдэхүүн хэсэг болон тодорхой үүрэг хариуцлага
- Гомдол барагдуулах механизмын үйл явц мөн хэн гомдол гаргаж болох үүнийг хэрхэн мэдээлж, ямар мэдээллийг оруулах талаар багтаасан байна.
- Гомдол барагдуулах механизмын хяналт.

## 8. Дүгнэлт ба цаашид хэрэгжүүлэх алхмууд

Монгол Улсад REDD-ийн сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмыг хэрэгжүүлэх хүрээг 2017-2018 онд талуудын оролцоотойгоор боловсруулсан бөгөөд энэ нь тус улсад олон улсын сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг өөрийн улсдаа нутагшуулж олон улсын хэмжээнд тавигддаг сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг үндэсний зорилго, нөхцөл байдалтайгаа уялдуулан хангах, өөрийн улсад хэрэгжиж байгаа өнөөгийн системүүдийг бүрэн дүүрэн ашиглахад нь туслах зорилготой юм. Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг үндэсний онцлогт тохируулж хэрэглэх арга замд дараах таван гол элементийг багтаасан бөгөөд тэдгээрийг дараах баримт бичигт тусгасан. Үүнд зорилго, цар хүрээ, болзошгүй үр ашиг, эрсдэл, үр ашгийг нэмэгдүүлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээ, сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудтай холбоотой бодлого, журам, сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг үндэсний онцлогт тохируулан тодорхойлсон тодорхойлолт болон REDD+-ийн гомдол барагдуулах механизм (ГБМ) зэрэг багтана. Энэхүү баримт бичгийн холбогдох хэсэг бүрт дэлгэрэнгүй зөвлөмжийг оруулсан бөгөөд тэдгээрийг товчхон хураангуйлбал:

- REDD+-ийн хүрээнд хэрэгжүүлэхээр санал болгосон бодлого арга хэмжээг хэрэгжүүлэх явцад үүсэж болзошгүй үр ашиг, эрсдэлийн үнэлгээг тодорхойлсон талаарх мэдээлэл, мөн үр ашгийг дээшлүүлэх, эрсдэлийг бууруулах сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмын асуудлуудыг тусгах зэрэгтэй холбоотой санал болгосон арга хэмжээнүүдийг оруулсан ба эдгээрийг REDD+ Үндэсний хөтөлбөрийг Монгол Улсад хэрэгжүүлэх явцад нэгтгэж авч үзэхийг зөвлөсөн байна. Эдгээр нь REDD+-ийн бодлого арга хэмжээний загвар болон хяналтын тогтолцоо, сөрөг нөлөөллөөс сэргийлэх мэдээллийн систем зэрэгтэй.

- БХЖ-ын үнэлгээг хийсний дараа уг үнэлгээнээс гарсан үр дүнд тулгуурлан хэд хэдэн арга хэмжээг авлаа. Үүний дотор багц зөвлөмжийг боловсруулж Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлсэн бөгөөд эдгээр зөвлөмжүүдийг 2018 онд хийх байгаль орчны хууль эрх зүйн шинэчлэлд тусгахыг зөвлөсөн. БХЖ-ын хүрээнд гарч байгаа гол хийдэл, орхигдсон асуудлуудыг мөн энэ үеэр тодорхой болгож, байгаль орчны болон бусад салбарын хууль эрх зүйн шинэчлэлийг хийхэд тусгахыг мөн зөвлөсөн, бусад хийдэл болон орхигдсон асуудлууд нь БХЖ-н шинэчлэлийн асуудалд хамаарахгүй бөгөөд илүү түргэн шуурхай шийдэл болон бусад арга хэмжээг авах шаардлагатай болж байгаа юм.

- Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг Монгол Улсын онцлогт нийцүүлж тодорхойлох ажлыг 2018 онд хийж дуусгасан бөгөөд үүнийг боловсруулахдаа сөрөг нөлөөллөөс сэргийлэх Канкуны зарчмуудыг чиг болгон баримталж, тэдгээрийн агуулга, элементүүдийг монгол орны онцлогт тохируулан боловсруулсан багц зарчмуудыг тодорхойлж гаргаж ирсэн. Эдгээр элементүүдийг мөн олон улсын санхүүгийн корпорацийн үйл ажиллагааны стандарттай харьцуулж үзсэн. Монгол Улсад REDD+ий-г өргөн цар хүрээтэйгээр хэрэгжүүлэх хандлага төлөвшиж байгаа тул сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг үндэсний онцлогт тохируулж тодорхойлсон баримт бичгийг "цаашид өөрчилж" болох бөгөөд REDD+-ийг Монгол Улсад хэрэгжүүлэх явцад хянан үзэж, шаардлагатай өөрчлөлтүүдийг оруулж байх нь зүйтэй юм.
- REDD+-ийн хүрээнд гомдол гарах, гомдлыг барагдуулах механизмыг цаашид бий болгохдоо Монгол Улсад одоогоор хэрэгжиж байгаа үндэсний гурван гомдол барагдуулах механизм дээр тулгуурлах нь зүйтэй. Хэдий тийм боловч, үүнийг хэрэгжүүлж эхлэхээсээ өмнө эдгээр гомдол барагдуулах механизмууд нь REDD+-ийн үйл ажиллагааны хэрэгцээ, шаардлагыг ямар хэмжээнд хангаж чадах вэ гэдэг талаар нэмэлт судалгааг хийх нь зүйтэй бөгөөд эдгээр нь олон улсын тэргүүн туршлагатай уялдсан байвал зохино.

Үүнээс гадна, сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх хүрээтэй холбоотой, түүний REDD+-ийн хэрэгжилттэй уялдуулах талаар өгсөн хэд хэдэн зөвлөмж гарсан.

- Монгол оронд REDD+-ийг хэрэгжүүлэх орчин болон энэ нь цаашид сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг хэрэгжүүлэхэд хэрхэн нөлөөлөх талаар бүрэн тодорхойлж амжаагүй байна. Жишээлбэл, үүнд авч үзвэл зохих гол хүчин зүйлс нь:
    - REDD+-ийн үйл ажиллагааг үндэсний хэмжээнд хэрхэн зохицуулах, хэрэгжүүлэх, ойн агентлаг байгуулах асуудал багтах эсэхийг харгалзах эсэх? Тийм бол, энэ байгууллага нь СНСЗ-уудыг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх хангалттай чадавхтай байхын тулд ямар нөөц хэрэгтэй (хүн болон техникийн) вэ? Үүнээс гадна БАХ-нүүдийг хэрэгжүүлэхэд аль яам, агентлаг тэргүүлэх үүрэг гүйцэтгэх вэ (ж.нь. аж үйлдвэр, эрчим хүч г.м)?
    - БАХ-нүүдийг орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх эсэх, хэрхэн хэрэгжүүлэх, REDD+-ийн дэд хөтөлбөрүүдээр дамжуулж хэрэгжүүлэх эсэх? Тийм бол СНСЗ-ын асуудлуудыг эдгээр хөтөлбөр хэрхэн бүрэн тусгах, тэдгээрийг хэрэгжүүлэх хариуцлагыг хэрхэн оноох вэ?
- Эдгээр асуудлыг харгалзаж үзсэний үндсэн дээр олон тооны арга хэмжээг цаашид REDD+ Үндэсний хөтөлбөрт тусгахаар санал болгов:
    - Монгол оронд сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг хэрэгжүүлэх болон түүнд хяналт тавихтай холбоотой удирдамж боловсруулж, цаашид REDD+-ийг үндэсний болон орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх байгууллагуудад энэ удирдамжийг танилцуулж, сургалт явуулах шаардлагатай. Ийм гарын авлагад дараах зүйлсийг оруулсан байна. Үүнд: Монголд СНСЗ-уудыг тусгаж, хэрэгжүүлэхэд ашиглах БХЖ, бусад дүрэм, журам: эдгээр нь хяналт, үнэлгээний тогтолцоотой хэрхэн уялдах зэрэг асуудлыг багтаасан байна (СНСЗ-ын талаар ямар мэдээллийг цуглуулах гэх мэт)

- Үндэсний хэмжээнд сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг хэрэгжилтэд хяналт тавих, үнэлгээ хийхэд зориулсан шалгуур үзүүлэлт болон үйл ажиллагаануудыг REDD+-ийн хөтөлбөрт тусгасан байх, үүнд СНСЗ-тай холбоотой шалгуур үзүүлэлтүүдийг REDD+-ийн хяналтын тогтолцоонд суулгах, СНСЗ-ыг хэрэгжүүлэх, хяналт тавихад шаардагдах эх үүсвэрийг хуваарилж өгөх гэх мэт багтана.
- Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчим болон нийгмийн бүлгүүдийн оролцоо, гомдол барагдуулах механизм (ГБМ) зэрэгтэй холбоотой сургалтыг REDD+-ийг үндэсний болон орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх байгууллагуудад явуулна. Үүнийг REDD+ Үндэсний хөтөлбөрийн REDD+-ийн чадавх бэхжүүлэхтэй холбоотой хэсэгт тусгах нь зүйтэй.

Зураг © Гантулга Төмөртулга

## Хавсралт 1: СНСЗ-уудыг Монгол орны онцлогт нийцүүлж тодорхойлсон нь

Дараах хүснэгтэд СНСЗ-уудыг Монгол орны онцлогт нийцүүлж тодорхойлсон тодорхойлолт, СНСЗ тус бүрт холбогдох БХЖ-уудыг үзүүлэв.

| **Сөрөг нөлөөллөөс сэргийлэх Зарчим А: Тухайн үйл ажиллагаа нь ойн үндэсний хөтөлбөр, холбогдох олон улсын гэрээ, хэлэлцээрүүдийн зорилгод хувь нэмэр оруулахуйц буюу эсвэл тэдгээрт нийцсэн байна** | |
|---|---|
| **Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмыг үндэсний нөхцөлд тодорхойлсон элемент** | **Тухайн СНСЗ-ыг тусгаж, хэрэгжүүлэхтэй холбоотой БХЖ** |
| **А1. REDD+ Бодлого, арга хэмжээнүүд нь (БАХ) Байгаль орчныг хамгаалах талаар олон улсын хэмжээнд хүлээсэн үүрэг амлалтуудад нийцсэн, үндэсний хэмжээнд мөрдөж байгаа биологийн олон янз байдлыг хамгаалах бодлогод хувь нэмэр оруулна. Үүнд: РАМСАРЫН Конвенц, Ус хамгаалах үндэсний хөтөлбөр, Биологийн олон янз байдлыг хамгаалах Конвенц, Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөр, Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр, НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх Конвенц, Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр, Ойн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хууль бус мод бэлтгэлтэй тэмцэх тухай Санкт Петрбургийн тунхаг.** | Рамсарын Конвенц (1971) (Монгол улсад 1998 онд хүчин төгөлдөр болсон);<br>Усны тухай хууль (2012)<br>Ус үндэсний хөтөлбөр (2016-2021) / Монгол Улсын Усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө<br>Биологийн олон янз байдлын тухай Конвенц (1993)<br>Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөр (2015-2025)<br>Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр (1998)<br>НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх Конвенц (1994)<br>Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр (2010-2020)<br>Ойн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хууль бус мод бэлтгэлтэй тэмцэх тухай Санкт Петербургийн тунхаг (2005) |
| **А2. REDD+-ийн БАХ-нүүд нь Төрөөс ойн талаар баримтлах бодлого, Ойн тухай хууль, Ойн цэвэрлэгээ хөтөлбөр, Ногоон хөгжлийн бодлого болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцсэн байна.** | Төрөөс ойн талаар баримтлах бодлого (2015)<br>Ойн тухай хууль (2012)<br>Ойн цэвэрлэгээ хөтөлбөр (2014)<br>Ногоон хөгжлийн бодлого (2014)<br>Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал (1995) |

| | |
|---|---|
| **А3. REDD+-ийн БАХ-нүүд нь МУ-ын Засгийн газраас ядуурлыг бууруулах, тогтвортой хөгжлийн дэмжих чиглэлээр хэрэгжүүлж байгаа Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөр, Монгол Улсын Тогтвортой хөгжлийн хэтийн төлөв 2030 болон, олон улсын тогтвортой хөгжлийн зорилтуудад нийцсэн байна.** | Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөр, стратеги (1993 )<br>Монголын Улсын тогтвортой хөгжлийн хэтийн төлөв 2030<br>Олон улсын тогтвортой хөгжлийн зорилт (ТХЗ)<br>Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр (1998)<br>Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль (1994) /Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль (1997)<br>Байгаль орчныг хамгаалах тухай хууль (1995)<br>Ногоон хөгжлийн бодлого (2014) |
| **А4. REDD+ БАХ-нүүд нь уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлээр олон улсын өмнө хүлээсэн үүрэг амлалт, хэрэгжүүлж байгаа бодлого, хөтөлбөрүүд болох Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр, НҮБУАӨСК-ийг хэрэгжүүлэхэд оруулах Үндэсний хувь нэмэрт тусгагдсан холбогдох зорилго/ зорилттой нийцсэн байна.** | Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр (2017-2021)<br>Монгол Улсын Анхны үндэсний зорилтот хувь нэмэр (2016)<br>Төрөөс ойн талаар баримтлах бодлого (2015)<br>Ойн тухай хууль (2012) |
| **А5. REDD+ БАХ-нүүд нь Монгол Улсын Үндсэн хууль, Хүний эрхийн түгээмэл тунхаг, Хүний эрхийн үндэсний комиссын тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийн тухай Конвенц болон Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого зэрэг хүний эрх, иргэдийн амьжиргааг дэмжих талаар хүлээсэн үүрэг амлалт, бодлогод нийцсэн байна.** | Монгол улсын үндсэн хууль (1992/2001)<br>Хүний эрхийн түгээмэл тунхаг (1948)<br>Хүний эрхийн үндэсний комиссын тухай хууль (2000)<br>Хөдөлмөр эрхлэлтийн тухай олон улсын Конвенц (ОУ-ын Хөдөлмөрийн байгууллагын конвенцууд)<br>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар төрөөс баримтлах бодлого (2016)<br>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль (2011)<br>Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын гэрээ (1966)<br>Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын гэрээ (1966)<br>Хүүхдийн эрхийн тухай Конвенц (1989)<br>Хөдөлмөрийн тухай хууль (1999) |

| | |
|---|---|
| | Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль (1994) Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль (1997) |
| **Сөрөг нөлөөллөөс сэргийлэх Зарчим B: Хууль эрхзүй, бие даасан байдлыг харгалзан үзсэн ил тод, үр дүнтэй үндэсний ойн засаглалын бүтэцтэй байх** | |
| **Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмыг үндэсний нөхцөлд тодорхойлсон нь** | **Тухайн СНСЗ-ыг тусгаж, хэрэгжүүлэхтэй холбоотой БХЖ** |
| **B1. REDD+ БАХ-нүүдийг холбогдох БХЖ-ийн заалтуудад нийцүүлж хэрэгжүүлж, хяналт тавина. REDD+ Үндэсний Хөтөлбөрийн хэрэгжилтийг жилд нэг удаа талуудын оролцоотойгоор хянана.** | Захиргааны ерөнхий хууль (2015)<br>Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль, журам (2015)<br>Зөрчлийн тухай хууль (2017)<br>Төрийн хяналт, шалгалтын тухай хууль (2003)<br>Байгаль орчныг хамгаалах тухай хууль (1995) |
| **B2. REDD+-ийн БАХ-нүүдийг боловсруулж, хэрэгжүүлэхдээ шаардлагатай боловсон хүчин, техникийн нөөцийг хуваарилж, Ойн тухай хуулийн хүрээнд боловсруулсан ойн тогтвортой менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбоотой институцийн болон техникийн чадавхыг бэхжүүлэх үйл ажиллагааг багтаасан байна.** | Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль (2012)<br>Ойн тухай хууль (2012)<br>Төрийн албаны тухай хууль (2002)<br>Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль (1994) / Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль (1997)<br>Ногоон хөгжлийн бодлого (2014)<br>Төрөөс ойн талаар баримтлах бодлого (2015)<br>Ойн цэвэрлэгээ хөтөлбөр (2014) |

| | |
|---|---|
| **B3. Үндэсний REDD+-ийн БАХ-нүүд нь зөрчил, авлигын эрсдэлийг бууруулах, мөн ил тод байдал, хариуцлагыг нэмэгдүүлэх асуудлыг хариуцсан талуудын үүрэг, хариуцлагыг холбогдох БХЖ (Монгол Улсын Авлигатай тэмцэх хууль, Төсвийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль)-уудад заасны дагуу тодорхойлж, тэдгээр хууль, тогтоомжийг мөрдөнө.** | Авлигын эсрэг хууль (2006)<br>Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль (2005)<br>Төрийн хяналт шалгалтын тухай хууль (2003)<br>Төрийн албаны тухай хууль (2002) |
| **B4. REDD+ БАХ-нүүдийг боловсруулж хэрэгжүүлэхдээ ил тод, үр дүнтэй ойн сайн засаглалыг дэмжихэд чиглэсэн үндэсний болон орон нутгийн хэмжээнд хэрэгжиж байгаа бодлого, зохицуулалтууд, холбогдох хэрэгжүүлэгч байгууллагууд салбар хоорондын уялдаа холбоог хангасан байна.** | Захиргааны ерөнхий хууль (2015)<br>Ойн тухай хууль (2012)<br>Газрын тухай хууль (2002) |
| **B5. REDD+ БАХ-ын боловсруулж хэрэгжүүлэхдээ жендерийн тэгш байдлыг дэмжиж, Жендерийн тэгш байдлыг дэмжих тухай хуулийн шаардлагыг хангасан байна.** | Монгол Улсын үндсэн хууль (1992/2001/2013)<br>Монгол Улсын тогтвортой хөгжлийн хэтийн төлөв- 2030<br>Жендерийн тэгш байдлыг дэмжих тухай хууль (2011)<br>Жендерийн тэгш байдлын үндэсний хөтөлбөр (2017-2021)<br>Байгаль орчны салбарын жендерийн стратеги (2014-2030)<br>Эмэгтэйчүүдийн эсрэг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай Конвенц (1980) |
| **B6. REDD+ БАХ-г Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн холбогдох зүйл, заалтуудтай нийцүүлэн боловсруулж, хэрэгжүүлэх ба БАХ-нүүдийн талаарх мэдээлэл ил тод, хүртээмжтэй байх бөгөөд холбогдох талуудад мэдээллийг тохирох аргаар хүргэнэ.** | Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хууль (2011)<br>Төрөөс ойн талаар баримтлах бодлого (2015)<br>Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр (2003 )<br>Ажил эрхлэлтийг дэмжих тухай хууль (2011) |

| **Сөрөг нөлөөллөөс сэргийлэх Зарчим C: Олон улсын өмнө хүлээсэн үүрэг, үндэсний нөхцөл байдал, хууль тогтоомж, мөн НҮБ-ийн Ерөнхий Ассемблейн баталсан Уугуул иргэдийн эрхийн тухай НҮБ-ийн Тунхагийг харгалзан үзэж, уугуул иргэдийн болон орон нутгийн нөхөрлөлийн гишүүдийн мэдлэг, эрхийг хүндэтгэх** | |
|---|---|
| **Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмыг үндэсний нөхцөлд тодорхойлсон нь** | **Тухайн СНСЗ-ыг тусгаж, хэрэгжүүлэхтэй холбоотой БХЖ** |
| **C1. REDD+-ийг хэрэгжүүлэхдээ нутгийн иргэд болон угсаатны цөөнх гэдгийг холбогдох БХЖ-д зааснаар тодорхойлж авч үзэх ба байгалийн нөөцийг бие даан захирах эрхийг хамруулж ойлгоно.** | Монгол Улсын үндсэн хууль (1992/2001/2013)<br>Захиргааны ерөнхий хууль (2016)<br>Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр (2003 )<br>Иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| **C2. REDD+ БАХ-нүүд нь нүүрстөрөгчийг бууруулснаас ирэх үр өгөөж болон экосистемийн үйлчилгээг сайжруулсантай холбоотой үр ашгийг зохих ёсоор, тэгш хүртээх зарчмаар хэрэгжиж, REDD+-ийн тогтвортой байдлыг хангахад чиглэнэ. REDD+ БАХ-нүүдийн хүрээнд урамшуулах, үр ашгийг хуваарилахад одоогийн хэрэгжиж байгаа журам, бүтцийг (нөхөрлөл, орон нутгийг хөгжүүлэх сан г.м) ашиглана.** | Ойн тухай хууль (2012)<br>Ойн цэвэрлэгээ хөтөлбөр (2014)<br>Төсвийн тухай хууль (2011)<br>Байгаль орчин хамгаалах тухай хууль (1995)<br>Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль (1994) / Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль (1997)<br>Жижиг дунд үйлдвэрийн тухай хууль (2007)<br>Жендэрийн тэгш байдлыг дэмжих тухай хууль (2011) |
| **C3. REDD+-ийг боловсруулах, хэрэгжүүлэхдээ оролцогч талуудын газар болон байгалийн нөөц ашиглах эрхийг нь зохицуулсан БХЖ-уудтай нийцүүлнэ. Мөн REDD+-ийн БАХ-нүүд нь Газрын тухай хуулиар зохицуулагдах харилцааг илүү ойлгомжтой бөгөөд тодорхой болгож өгсөн байна.** | Монгол Улсын үндсэн хууль (1992/2001/2013)<br>Газрын тухай хууль (2002)<br>Ойн тухай хууль (2012)<br>Төрөөс ойн талаар баримтлах бодлого (2015)<br>Байгаль орчин хамгаалах тухай хууль (1995)<br>Усны тухай хууль (2012)<br>Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр (1998) |

| | |
|---|---|
| **C4. REDD+ БАХ-нүүдийг нутгийн иргэд эсвэл үндэстний цөөнхийн эзэмшлийн уламжлалт мэдлэг, өв соёл болон оюуны мэдлэг, хөрөнгийг хамгаалах буюу дэмжихэд чиглэсэн холбогдох БХЖ-уудын (Газрын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль) зүйл, заалтуудтай нийцүүлэн боловсруулж, хэрэгжүүлнэ. Нутгийн иргэдийн эзэмшлийн соёлын биет өвийг төр, шашны болон олон нийтийн байгууллагаас тогтоосон нөхцөлийн дагуу хамгаална.** | Монгол Улсын үндсэн хууль (1992/2001/2013)<br>Соёлын өвийг хамгаалах тухай хууль (2014)<br>Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль (1994)<br>Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль (1997)<br>Байгалийн ургамлын тухай хууль (1995)<br>Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр (2017-2021)<br>Генетикийн нөөцийн тухай хууль (БОАЖЯ боловсруулж байгаа) |
| **C5. Үндэсний REDD+-ийн БАХ-нүүдийг боловсруулж, хэрэгжүүлэхдээ тухайн газар болон байгалийн нөөцийг эзэмших эрхтэй иргэдийг нүүлгэн суурьшуулах болон/эсвэл эдийн засгийн үйл ажиллагааны зорилгоор нүүлгэх шаардлагатай болсонтой холбоотой үүсэх аливаа эрсдэлээс зайлсхийсэн буюу эрсдэлийн бууруулахад анхаарсан байна. REDD+ БАХ-г хэрэгжүүлэхээс өмнө нутгийн иргэдийг албан шахалтаар нүүлгэн шилжүүлсэн тохиолдолд зохих хэлбэрийн нөхөн төлбөрийг санал болгож, зөвшилцсөн байна.** | Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль (1994) / Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль (1997)<br>Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль (2012)<br>Газрын тухай хууль (2002)<br>Ойн тухай хууль (2012) |
| **Сөрөг нөлөөллөөс сэргийлэх Зарчим D: Оролцогч талууд, тухайлбал, нутгийн иргэд, орон нутгийн иргэдийн бүрэн бөгөөд үр дүнтэй оролцоог хангах;** | |
| **Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмыг үндэсний нөхцөлд тодорхойлсон нь** | **Тухайн СНСЗ-ыг тусгаж, хэрэгжүүлэхтэй холбоотой БХЖ** |
| **D1. REDD+-ийн БАХ-нүүдийг төлөвлөх, хэрэгжүүлэх явцад оролцох талуудыг тодорхойлсон байна. Тухайн БАХ-нээс хамаараад оролцогч талууд гэдэгт орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагууд, ТХНЗ, усны сав газар, нөхөрлөл, иргэний нийгмийн байгууллага, холбоо, малчид, аж ахуйн нэгж болон хувийн хэвшлийн бусад байгууллагыг** | Төрөөс ойн талаар баримтлах бодлого (2015)<br>Ойн тухай хууль (2012)<br>Ойн цэвэрлэгээ хөтөлбөр (2014) |

| | |
|---|---|
| **хамруулна. Тухайн төлөөлөн оролцогч талууд нь зохих ёсны төлөөлөл байж чадах эсэхийг холбогдох хууль, журмын дагуу тогтооно.** | Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль (1994) / Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль (1997)<br><br>Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль (2005) |
| **D2. REDD+ БАХ-нүүдийг тодорхойлох болон хэрэгжүүлэх явцад холбогдох оролцогч талууд нь санал болгож буй БАХ-нүүдийн талаар мэдээлэл авах, зөвлөлдөх, шийдвэр гаргахад оролцох эрхтэй болохыг хүлээн зөвшөөрч, холбогдох хууль журмын дагуу хэрэгжүүлнэ. REDD+-ийн төлөвлөгөө болон хэрэгжилттэй холбоотой шийдвэр нь гаргах үйл явц нь: (i) холбогдох нотолгоо, мэдлэгт суурилсан; (ii) төр, иргэний нийгэм, олон нийт болон бусад талуудын нээлттэй хэлэлцүүлэгт үндэслэсэн; (iii) дээрх талуудын өгсөн саналыг харгалзсан байна.** | Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрх чөлөөний тухай хууль (2011)<br><br>Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2016)<br><br>Захиргааны ерөнхий хууль (2015)<br><br>Зөрчлийн тухай хууль (2017)<br><br>Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль (2012)<br><br>Төрөөс ойн талаар баримтлах бодлого (2015)<br><br>Ойн тухай хууль (2012)<br><br>Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль (1994) / Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль (1997) |
| **D3. REDD+-ийн БАХ-нүүдийг төлөвлөж, хэрэгжүүлэхдээ холбогдох үндэсний хөгжлийн бодлого, хөтөлбөрүүдтэй уялдуулсан байх ба салбар дундын болон олон талын хамтын ажиллагааны механизмуудыг ашиглан REDD+ БАХ-нүүдийг хэрэгжүүлж хяналт тавина.** | REDD+-ийн хүрээнд бий болсон механизмууд (Жишээлбэл: Ойн тогтвортой хөгжлийн зөвлөл)<br><br>Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль (1994) / Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль (1997)<br><br>Иргэдийн төлөөлөгчдийн хурал<br><br>Ойн тухай хууль (2012)<br><br>Ойн цэвэрлэгээ хөтөлбөр(2014) |

| | |
|---|---|
| **D4. МУ-ын Засгийн газар нь REDD+ийн бодлого, арга хэмжээний хэрэгжилтийн улмаас эрх нь зөрчигдсөн гэх иргэд болон талуудад холбогдох БХЖ-ын дагуу санал гомдлоо шийдвэрлүүлэх эрхийг нь хангаж, гомдол, санал барагдуулах зохистой, ил тод механизмыг бүрдүүлж өгсөн байна.** | Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх журмын тухай хууль (2016)<br><br>Төрийн байгууллага болон албан тушаалтнуудад иргэдээс ирүүлсэн гомдол саналыг шийдвэрлэх тухай хууль (1995)<br><br>Монгол Улсын Хүний эрхийн комиссын тухай хууль (2000)<br><br>Төрийн хяналт, шалгалтын тухай хууль (2003) |
| **СНСЗ E: Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчим E:** Тэдгээр үйл ажиллагаа нь байгалийн ой, биологийн олон янз байдлыг хамгаалах асуудалтай нийцсэн байх ба [REDD+] үйл ажиллагаар байгалийн ойг хувиргахад ашиглах бус харин байгалийн ой болон түүнийг экосистемийн үйлчилгээг хамгаалахад чиглэсэн урамшуулал бий болгох, мөн нийгэм, байгаль орчны бусад үр ашгийг сайжруулахад ашигладаг байх. | |
| **Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмыг үндсэний нөхцөлд тодорхойлсон элемент** | **Тухайн СНСЗ-ыг тусгаж, хэрэгжүүлэхтэй холбоотой БХЖ** |
| **E1. REDD+ БАХ-нүүд нь байгалийн ойн талаарх улсын хэмжээнд мөрдөж байгаа албан ёсны тодорхойлолтод суурилсан, түүнд нийцсэн байна.** | Ойн тухай хууль (2012)<br><br>Ойн хяналтын түвшин (ОХТ)<br><br>Ойн тооллогын удирдамж (2014) |
| **E2. REDD+ БАХ-нүүдийг боловсруулж, хэрэгжүүлэхдээ ойн сан бүхий болон ойгоос бусад газар нутгийн аль алинд нь учрах нөлөөллийг үнэлэхтэй холбоотой хууль эрх зүйн шаардлагыг бүрэн хангасан байна.** | Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль (2012)<br><br>Төрөөс ойн талаар баримтлах бодлого (2015)<br><br>Ойн цэвэрлэгээ хөтөлбөр (2014) |
| **E3. REDD+ БАХ-нүүд нь байгалийн ойг хамгаалах, хадгалах явдлыг урамшуулах, ой ашиглагчдын хариуцлагыг дэмжихэд чиглэсэн арга хэмжээнүүдийг илүү сонгон хэрэгжүүлж, байгалийн ойг доройтуулахаас зайлсхийх буюу эрсдэлийг бууруулна.** | Төрөөс ойн талаар баримтлах бодлого (2015)<br><br>Ногоон хөгжлийн бодлого (2014)<br><br>Ойн тухай хууль (2012)<br><br>Ойн цэвэрлэгээ хөтөлбөр (2014) |

| | |
|---|---|
| | Ойн арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, үнэлэх, тарьсан модыг худалдаж авах тухай журам (Байгаль орчин ногоон хөгжлийн сайд болон сангийн сайдын хамтарсан тушаал 2013)<br>Ургамал хамгааллын тухай хууль (2007)<br>Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль (1994) / Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль (1997)<br>Байгаль орчныг хамгаалах тухай хууль (1995)<br>*(Үр ашиг хуваарилахтай холбоотой с2 элементийг үзнэ үү.)* |
| **E4. REDD+-ийн үйл ажиллагааг байгалийн ойг таримал ой болгон хувиргах буюу бусад зориулалтаар өөрчлөхөд ашиглахгүй, ийнхүү хувиргахыг дэмжихгүй байх** | Ойн тухай хууль (2012)<br>Газрын тухай хууль (2002)<br>Хувиргасан амьд организмын тухай хууль (2007)<br>*(Байгалийн ойн талаарх тодорхойлолтыг E1 элементээс үзнэ үү.)* |
| **E5. REDD+-ийн үйл ажиллагааг боловсруулах, эрэмбэлж, хэрэгжүүлэхдээ нийгмийн сөрөг нөлөө учруулахаас зайлсхийж, эдийн засаг, нийгмийн сайн сайхан байдал, үр ашгийг дэмжиж, ялангуяа эмзэг бүлгийн хүмүүст ажил эрхлэх боломжийг нь нэмэгдүүлэх талаар онцгой анхаарал хандуулна.** | Уур амьсгалын өөрчлөлтийн тухай үндэсний хөтөлбөр (2011)<br>Төрөөс ойн талаар баримтлах бодлого (2015)<br>Ногоон хөгжлийн бодлого (2014)<br>Ойн тухай хууль (2012)<br>Газрын тухай хууль (2002)<br>Ойн цэвэрлэгээ хөтөлбөр(2014)<br>Ажил эрхлэлтийг дэмжих тухай хууль (2011)<br>Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль (1994)<br>Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль (1997)<br>Аялал жуулчлалын тухай хууль (2000) / Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр (2016-2020) |

| | |
|---|---|
| | Монгол мал үндэсний хөтөлбөр (2016)<br>Ажлын байрны аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль (2008)<br>*(Ядуурлыг бууруулах тухай А3 , Эдийн засгийн үйл ажиллагаа явуулах шаардлагаар нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой асуудлаарх С5-аас тус тус харна уу.)* |
| **Е6. REDD+ БАХ-нүүд оролцогч талуудтай орон нутгийн болон үндэсний хэмжээнд зөвлөлдсөний үндсэн дээр хамгаалалтын ач холбогдол өндөртэй ойг тодорхойлж, тэдгээрийн экосистемийн үйлчилгээг хамгаалах, нөхөн сэргээхэд тусална.** | Ойн тухай хууль (2012)<br>Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль (1994) / Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль (1997)<br>Ойн тухай хууль (2012)<br>Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль (1994) / Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль (1997)<br>Төрөөс ойн талаар баримтлах бодлого (2015)<br>Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөр (2015-2025) |
| **Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчим F: Үр дүн хувирах эрсдэлийг тооцох**[19] | |
| **Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмыг үндэсний нөхцөлд тодорхойлсон элемент** | **Тухайн СНСЗ-ыг тусгаж, хэрэгжүүлэхтэй холбоотой БХЖ** |
| **F1. REDD+-ийн үйл ажиллагааг төлөвлөх, сонгох болон хэрэгжүүлж, хяналт тавихдаа ойн хомсдол, доройтолд хүргэж буй голлох шууд болон дам хүчин зүйлсийг бууруулахад чиглэсэн үйл ажиллагаануудыг хамруулахын зэрэгцээ REDD+-ийг Монгол Улсад тогтвортой хэрэгжүүлэхэд гол тулгуур болох ойн тогтвортой** | Ойн тухай хууль (2012)<br>Төрөөс ойн талаар баримтлах бодлого (2015)<br>Ногоон хөгжлийн бодлого (2014)<br>Газрын тухай хууль (2002) |

[19] Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмын хүрээнд ашиглаж байгаа "Үр дүн хувирах" гэдэг нэр томьёо нь REDD+-тэй холбоотой бөгөөд хүлэмжийн хийн ялгарал буурсан, бий болсон амжилт, үр дүн тогтвортой бус, хэзээ нэг цагт өөрчлөгдөж болно гэсэн утгатай юм.

| | |
|---|---|
| **менежмент, хамгааллын үйл ажиллагааг орон нутгийн болон улсын хэмжээнд сайжруулахад саад болж буй бэрхшээлийг шийдвэрлэх арга хэмжээнүүдийг ойн салбарын холбогдох БХЖ-ын дагуу тусгасан байна.** | Хөрс хамгаалах, Цөлжилтөөс сэргийлэх тухай хууль (2012) / Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр (2010-2020)<br><br>Ургамал хамгаалах тухай хууль (2007)<br><br>Байгаль орчин хамгаалах тухай хууль (1995)<br><br>(*Эрсдэлт хүчин зүйлсийн талаар F1 элементийг үзнэ үү.*) |
| **F2. REDD+ БАХ-нүүдийг боловсруулж, хэрэгжүүлэхдээ үр дүн хувирч, эсрэгээр өөрчлөгдөж болох эрсдэлүүдийг харгалзаж үзсэн байна. Эдгээр эрсдэлд (хуулийн, нийгэм, экологийн хүчин зүйлс буюу бодлого өөрчлөгдөж, ойн нөөцийн хэт ашиглалт нэмэгдэх г.м) дүн шинжилгээ хийсний үндсэн дээр, REDD+ БАХ-нүүдийг боловсруулж, хэрэгжүүлэхдээ үр дүн хувирах эрсдэлийг бууруулахад чиглэсэн арга хэмжээнүүдийг тусгасан байна.** | Ойн тухай хууль (2012)<br><br>Төрөөс ойн талаар баримтлах бодлого (2015)<br><br>Ногоон хөгжлийн бодлого (2014)<br><br>Газрын тухай хууль (2002)<br><br>Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль (2012)<br><br>Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр (2010-2020)<br><br>Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль(2012)<br><br>Төрийн албаны тухай хууль (2002)<br><br>**Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам** (2016)<br><br>Ойн болон хээрийн түймрээс сэргийлэх тухай журам (ЗГ-ын 2013 оны шийдвэр No. 109)<br><br>Байгаль орчныг хамгаалах тухай хууль (1995) |
| **F3. Үндэсний ойн мониторингийн систем (ҮОМС)[20] -ийг боловсруулж, сайжруулан ашиглахдаа хөтөлбөрийн үр дүн хувирч, өөрчлөгдөж байгаа талаар болон өмнө тодорхойлсон эрсдэлүүдтэй холбоотой мэдээллийг илрүүлэх давтамж, тохиргоог хийж өгсөн байна. Үүнийг хэрэгжүүлэх** | ҮОМС-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө/ Төвлөрсөн ойн мэдээллийн системийг ажиллуулах стандарт (SOPs). |

[20] REDD+-ийг хэрэгжүүлж байгаа орнууд нь хүлэмжийн хийн ялгарлын талаар үнэн бодитой мэдээлэл өгөх мониторингийн системтэй байх шаардлагатай бөгөөд НҮБУАӨСК-ийн Талуудын 16 дугаар бага хурлын Шийдвэрт заасны дагуу Үндэсний ойн мониторингийн систем (ҮОМС) байгуулсан байна.

| | |
|---|---|
| **хүний нөөцийн болон техникийн чадавхыг бүрдүүлсэн байна.** | |
| **F4. Аливаа үр дүн хувирч, эсрэгээр өөрчлөгдөх тохиолдол гарсан үед түүний шалтгааныг судалж, зохих менежментийн арга хэмжээ авч байх механизмыг REDD+-ийн хяналт, үнэлгээний системд суулгаж өгсөн байна.** | Төрийн хяналт, шалгалтын тухай хууль (2003)<br>Үндэсний REDD+ хөтөлбөр, хяналт, үнэлгээний систем, ҮОМС-ийн зарим үйл ажиллагаа, протоколтой холбоотой бусад бичиг баримтууд |
| **Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчим G:** Хүлэмжийн хийн ялгарлат өөр газар шилжих явдлыг бууруулах[21] | |
| **Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмыг үндэсний нөхцөлд тодорхойлсон элемент** | **Тухайн СНСЗ-ыг тусгаж, хэрэгжүүлэхтэй холбоотой БХЖ** |
| **G1. Монгол орны REDD+ Хөтөлбөр болон үүний гол хэсэг болох REDD+ БАХ-нүүдийг боловсруулахдаа улсын нийт нутаг дэвсгэрийг аль болох зохих ёсоор хамруулах (ойн болон ой бус экосистемүүдийг оруулах г.м) ба REDD+-ийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах шаардлагатай салбар дундын талуудын оролцоог багтаасан байна.** | Монгол орны REDD+ хөтөлбөр болон Ойгоос ялгарах хүлэмжийн хийн хяналтын түвшин.<br>Ойн тухай хууль (2012)<br>Төрөөс ойн талаар баримтлах бодлого (2015)<br>Газрын тухай хууль (2002)<br>Хөрс хамгаалах, Цөлжилтөөс сэргийлэх тухай хууль (2012)<br>Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр (2010-2020) |
| **G2. REDD+-ийн үйл ажиллагаар төлөвлөх, сонгох, хэрэгжүүлэх болон хяналт тавихдаа ойн хомсдол, доройтолд хүргэж буй голлох шууд болон дам хүчин зүйлсийг бууруулахад чиглэсэн үйл ажиллагаануудыг хамруулахын зэрэгцээ REDD+-ийг Монгол Улсад тогтвортой хэрэгжүүлэхэд гол тулгуур болох ойн тогтвортой менежмент, хамгааллын үйл ажиллагааг орон нутгийн болон улсын хэмжээнд сайжруулахад саад болж буй** | Ойн тухай хууль (2012)<br>Төрөөс ойн талаар баримтлах бодлого (2015)<br>Газрын тухай хууль (2002)<br>Хөрс хамгаалах, Цөлжилтөөс сэргийлэх тухай хууль (2012)<br>Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр (2010-2020) |

21 "Шилжих" буюу өөр газарт тархах гэдэг нэр томьёо нь тодорхой ой бүхий талбайг хамгаалж, ойн доройтол, хомсдлын хүчин зүйлсийг бууруулах явцад тэдгээр хүчин зүйл өөр газарт тархах буюу шилжихийг хэлнэ.

| | |
|---|---|
| **бэрхшээлийг шийдвэрлэх арга хэмжээнүүдийг ойн салбарын холбогдох БХЖ-ын дагуу тусгасан байна.** | Ургамал хамгаалах тухай хууль (2007)<br>*(Сөрөг хүчин зүйлсийг авч үзэх тухай F2 элементээс харна уу.)* |
| **G3. REDD+ БАХ-нүүдийг боловсруулахдаа тодорхой үйл ажиллагааг хэрэгжүүлсний улмаас сөрөг нөлөө нь ойн болон ойн бус өөр газарт шилжих эрсдэл үүсэж, ой түшиглэж амьдардаг болон бусад төрлийн аж ахуй эрхэлдэг иргэдийн амьжиргаанд нөлөөлөх эрсдэл үүсэж болохыг харгалзан үзсэн байна. Эдгээр эрсдэлийг шинжилж үзсэний үндсэн дээр тэдгээрийг бууруулахад чиглэсэн үйл ажиллагааг БАХ-нүүдэд тусгасан байна.** | Байгаль орчин хамгаалах тухай хууль (1995)<br>Ойн тухай хууль (2012)<br>Ногоон хөгжлийн бодлого (2014)<br>Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль (1994)<br>Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль (1997)<br>**Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам** (2016)<br>*(Үр дүн хувирах эрсдэлийн талаар F1-ийг , эдийн засгийн үйл ажиллагаа явуулах зорилгоор нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой асуудлын талаар C5 элементийг үзнэ үү.)* |
| **G4. REDD+-ийн үйл ажиллагааг хянах, үнэлэх системд хүлэмжийн хийн ялгаралт буурсан үр дүн хожим хувирах, ялгаралт ой, ойн бус өөр газарт шилжиж байгаа талаарх мэдээллийг илрүүлж, шалтгааныг олж тогтоох давтамжийг тохируулж өгсөн байх ба үүнийг гүйцэтгэхэд шаардагдах боловсон хүчний болон техникийн нөөцийг шийдэж өгсөн байна.** | ҮОМС-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө/ Төвлөрсөн ойн мэдээллийн системийг ажиллуулах стандарт (SOPs).<br>(ҮОМС-ийн талаар СНСЗ F3-ыг үз) |
| **G5. REDD+-ийн үйл ажиллагааг хянах, үнэлэх системд хүлэмжийн хийн ялгаралт ой, ойн бус өөр газарт шилжиж байгаа талаарх мэдээллийг илрүүлж, сөрөг нөлөө шилжиж байгаагийн цаад шалтгааныг олж тогтоон, зохих менежментийн арга хэмжээг авч байх механизмыг суулгаж өгсөн байна.** | Төрийн хяналт, шалгалтын тухай хууль (2003)<br>Үндэсний REDD+ хөтөлбөр, хяналт, үнэлгээний систем, ҮОМС-ийн зарим үйл ажиллагаа, протоколтой холбоотой бусад бичиг баримтууд |




UN-REDD PROGRAMME

Food and Agriculture Organization of the United Nations

UN environment

*Монгол орны UN-REDD Үндэсний Хөтөлбөр*

*Хаяг: Засгийн газрын II байр, Нэгдсэн үндэстний гудамж 5/2, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар 15160, Монгол улс*

*Утас: +976-7711-7750*

*Цахим шуудан: info@unredd.mn*

*Вэбсайт: www.reddplus.mn*